



ГЭР БҮЛ,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ ХУРААНГУЙ ЭМХЭТГЭЛ-2024

Улаанбаатар хот
2024 он

ӨМНӨХ ҮГ

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас жил бүрийн 12 дугаар сарын 03-ны өдрийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн өдөр болгон зарласан бөгөөд уг өдрийг угтан хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад тулгамдаж буй асуудлыг судалгаа, шинжилгээний үндэслэлтэй шийдвэрлэх, бодлогыг оновчтой томьёолоход нөлөөлөх, улмаар хөгжлийн бэрхшээл судлал салбар шинжлэх ухааныг хөгжүүлэх зорилготой “Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмж-2024” сэдэвт 12 дах удаагийн эрдэм шинжилгээний хурлыг 11 дүгээр сарын 28-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Хуралд нийт 90 орчим судалгааны өгүүлэл ирүүлснээс үзэхэд жил ирэх тусам хурлын цар хүрээ маань улам өргөжиж, салбар бүрийн оролцоо нэмэгдэж, бидэнд хамтран ажиллах, туршлага солилцох боломжийг олгож байгаад талархалтай байна.

Хөгжлийн бэрхшээлийн салбарт орж ирж буй судлаач бүхний оролцоог дэмжин, хичээл зүтгэлийг үнэлж өгүүлэл бүрийг эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд хэвлүүлдэг байсан бол энэ удаад бид судалгааны ажилд тавигдах гол шалгууруудыг хангасан шилдэг 8 илтгэлийг хуралд хэлэлцүүлж, нийт 50 гаруй өгүүллийг энэхүү эмхэтгэлд нэгтгэснийг та бүхэн хүндэтгэн хүлээн авч үзнэ үү.

Тус эрдэм шинжилгээний онол, практикийн хурлыг зохион байгуулахад дэмжиж ажилласан салбарын хамт олон, хамтран ажиллаж үнэтэй санал зөвлөмж өгсөн шүүгчдийн бүрэлдэхүүн, зочин илтгэгчид, өгүүлэл ирүүлсэн болон амжилттай илтгэлээ хэлэлцүүлсэн мэргэжилтэн, эрдэмтэн багш, судлаач, оюутнууддаа талархал илэрхийлж, цаашдын эрдэм судлалын ажилд нь амжилт хүсье.

Гарчиг

I Бүлэг. БОЛОВСРОЛ

Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид тулгарч буй асуудал ба ахиц дэвшил.....	6
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх арга зам.....	7
Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийг хамтын оролцоогоор дэмжих нь	9
Хөгжлийн онцлогтой хүүхэдтэй ажиллаж буй багшийн арга зүй, ур чадвар, хандлага чухал болох нь...	12
СӨБ-н байгууллагын хүүхдүүдэд бага наснаас нь хөгжлийн бэрхшээл, тэгш хүртээмжийн талаарх ойлголтыг бий болгох нь.....	14
Дээд боловсролыг хүртээмжтэй олгох нь (сонсголын бэрхшээлтэй иргэдийн жишээн дээр.....	16
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, сурч боловсрох асуудалд малчин эцэг, эхийн оролцоо.....	18
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдаж буй нь байдал.....	20
Ерөнхий боловсролын сургуульд аутизмтай хүүхдийг суралцуулах менежментийн байдлыг тодруулах нь.....	22
Суралцахуйн бэрхшээл–тэгш хүртээмж.....	24
Багш бол хамгийн сайн хамтрагч юм.....	26
Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг аг технологи болон зурган картаар хөгжүүлэх нь.....	28
Тархины саажилт булчингийн чангаралттай хүүхэдтэй ажиллах арга зүй.....	29
8-р ангийн эмэгтэй технологийн хичээлийн интеграцид суурилсан бие даалт.....	31
Интеграцид суурилсан багшлахуй, суралцахуй (хэрэглэгдэхүүний зөв сонголт ба тэгш хамруулах боловсролын хүүхдийг тэгш хөгжүүлэх нь жишээн дээр).....	34
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дээд боловсрол эзэмших боломж, хүртээмжийг нэмэгдүүлэх нь.....	36
Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг тэгш хамруулан сургах боловсролын үйлчилгээ, туршилт, үр дүн	39
Хөгжлийн онцлогтой сурагчдыг мэдлэг чадварын ахицад нөлөөлөх хүчин зүйлсийг нэмэгдүүлсэн туршлага, үйл ажиллагаа.....	42
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг “тэгш хамруулан сургахад” багшийн туслалцаа, дэмжлэг.....	44
Аутизмтай хүүхдийн нийгэмшихүйн үйлийг нь дэмжих нь.....	46
Хүүхдийн сонирхолд тулгуурлан сургалт үйл ажиллагааг интеграцлан зохион байгуулсан туршилтын үр дүн / аутизмтай хүүхдийн жишээн дээр/.....	49
Тэгш хамруулах боловсролын эрх зүйн орчны харьцуулсан судалгаа.....	51

II Бүлэг. ДЭД БҮТЭЦ

Харааны бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын үр дүн, арга туршлага.....	54
Ухаалаг хөтөч.....	56

III Бүлэг. ХӨДӨЛМӨР

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь (нөхцөл байдлын судалгааны үр дүн).....	60
Төвийн дэргэдэх “бүлгийн төсөл”-ийн арга зүйгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь.....	62

IV Бүлэг. ЭРҮҮЛ МЭНД

Тархины гэмтлийн дараах байдалд цогц сэргээн засах эмчилгээг урт хугацаанд хийсэн үр дүн.....	66
Аутизмын хүрээний хүүхдүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн өнөөгийн байдлын тойм өгүүллэг	68
Хөгжлийн бэрхшээлтэй өсвөр насны охидын нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролын талаарх мэдлэг, ойлголтыг тодорхойлох нь.....	71
Дорноговь аймгийн сайншанд сумын 0-16 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн өвчлөл болон боловсролын тэгш хүртээмжийг судалсан нь	74
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх хөдөлгөөн засал эмчилгээний тэгш хүртээмж.....	77
Тархины саатай хүүхдэд spider case буюу аалзны тор аргыг нэвтрүүлж эмчилгээнд ашигласан үр дүн	79
Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамт олонд түшиглэн сэргээн засах тусламж үйлчилгээний чанар, хүртээмж.....	81

IV Бүлэг. ЭРҮҮЛ МЭНД

<i>Эрчимт эмчилгээний тасагт тархины цочмог харвалттай эмчлүүлэгчийн эрт үеийн хөдөлгөөний чадварыг icmts-ээр үнэлэх нь</i>	84
<i>Аутизмтай хүүхдийг морин эмчилгээгээр сувилах нь</i>	4
<i>Төрөлхийн майга тавхайн эмгэгийн үед гэлтгөнөн боолт ба иллэг массаж хийсэн эмчилгээний үр дүн</i>	85
<i>Тэгш хамруулах боловсролын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг судалсан нь (ерөнхий боловсролын сургуулийн жишээн дээр)</i>	88
	90

V Бүлэг. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

<i>Хуулийн зохицуулалтыг кейс /тохиолдол/ хэлбэрт оруулж, аудио тайлбартайгаар харааны бэрхшээлтэй иргэдэд хүргэсэн үр дүн</i>	94
<i>Мэргэжлийн боловсролын сургуульд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын үйлдвэрлэлийн дадлагыг үр дүнтэй болгоход төр, нийгмийн түншлэлийн харилцааны бодлогын зохицуулалт</i>	97
<i>Олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санхүүгийн боловсролын тулгамдсан асуудал, анхаарах арга зам</i>	100

VI Бүлэг. НИЙГЭМ ХАМГААЛАЛ

<i>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн оролцоо, дэмжлэг(нөхцөл байдлын судалгааны үр дүн)</i>	104
<i>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зонхилон тохиолдож буй сэтгэл хөдлөл, зан үйлийн хэв шинжийг судлах нь</i>	106
<i>Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл ба нийгмийн харууцлага, шийдэл</i>	108
<i>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох үүрэг бүхий салбар комиссын үйл ажиллагааг сайжруулахад технологийн шийдлийг ашиглах нь</i>	110
<i>Аутизмын хүрээний эмгэгтэй хүмүүсийн эрх зөрчигдөж байгаа тухай</i>	113
<i>Хөгжлийн бэрхшээлтэй хүнд туслах ажилтныг бэлтгэж буй олон улсын туршлага (өрнө, дорнын 8-н улсын жишээн дээр)</i>	115
<i>Аутизмтай хүүхдийн эцэг эхийн сэтгэл зүйн байдал</i>	118
<i>Тусгай хэрэгцээт хүүхдэд тэгш боломж олгоё (орон нутаг дахь нөхцөл байдал, судалгааны үр дүн)</i> ...	120
<i>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь</i>	122
<i>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд асрахад тулгамдаж буй нийгмийн асуудлууд</i>	125
<i>Үйлчилгээний шинэлэг байдал үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжинд нөлөөлөх нь</i>	127
<i>Бие даан амьдрах эрх</i>	128



I. БҮЛЭГ БОЛОВСРОЛ

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАЖ БУЙ БАГШИД ТУЛГАРЧ БУЙ АСУУДАЛ БА АХИЦ ДЭВШИЛ

Б.Ганцэцэг, Г.Батцэцэг¹

¹Ерөнхий боловсролын 105-р сургуулийн бага ангийн багш

Үндэслэл:

Тэгш хамран сургах боловсрол гэж суралцахуйн бүхий л үйл явцад тулгарах аливаа саад бэрхшээлийг тодорхойлж, түүнийг арилгах замаар бүх хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид чанартай, тэгш боломж, нөхцөлд суралцах явцыг хэлнэ¹. Өөрөөр хэлбэл боловсрол, сургалтын хүртээмж, явц үр дүн нь тухайн суралцагчийн ар гэрийн байдал, эцэг эхийн боловсрол ба орлогын түвшин амьдарч буй газар орон, үндэс угсаа, хэл соёл, хөгжлийн онцлог зэрэг тухайн хүнээс хамаарахгүй хүчин зүйлээс шалтгаалдаггүй байж болохгүй юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 16.7 дугаар заалтаар Монгол хүний сурч боловсрох эрхийг баталгаажуулсан билээ. 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд бусад хүүхдийн хамт сургуульд сурч боловсрох эрхтэй, бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ гэж тодорхой заасан байна. Бүх хүний хувьд насан туршдаа бие даан амьдрахад нь нийгэм сэтгэл зүйн гол ур чадваруудыг зөвхөн тэгш хамруулсан орчинд л эзэмших боломжтой.

Судалгааны зорилго:

ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшид тулгамдаж буй асуудал ба ахиц дэвшлийг илрүүлж, гарц гаргалгааг хэлэлцэх

Судалгааны арга зүй:

Ерөнхий боловсролын сургуулийн багш сурагчдын нөхцөл байдлын судалгаа, илтгэл тайлангууд

Үр дүн:

Хүүхдийн ялгаатай байдлыг хүндэтгэн хүлээн зөвшөөрч, тэднийг дэмжин хөгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй болон бусад эцэг эхчүүдийн хэн хэн нь адилхан үүрэг хариуцлага үүрч үр дүнтэй үйл ажиллагаа өрнүүлж, тэгш эрхийг баталгаажуулснаар илүү сайхан нийгмийг хамтдаа бүтээнэ.

Дүгнэлт:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад арга зүй дутмаг, цаг хугацаа их шаарддаг, тохируулгад хэрэглэгдэхүүнүүд шаардлагатай, ар гэрийн харилцаа хандлага муу, нийгэмшихүйн хувьд хүлээн авах чадвар болон хавсарсан эмгэгтэй байдаг зэрэг нь багш нарт тулгамдаж буй асуудал болж байгаа нь ажиглагдаж байна. Эцэг эхийн судалгаанаас харахад дэмжлэгийн багтай хамтарч ажилладаггүй, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахад эцэг эхийн оролцоо бага, сурч боловсрох таатай орчин бүрдээгүй, анги хамт олны харилцаа хандлага сул байгаа нь ажиглагдлаа. Ирээдүйд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгэмд айдасгүй алхахад, илүү сайн боловсрол эзэмшихэд нь, бие даан илүү ихийг хийж, илүү олон чадварт суралцахад нь, ажил хөдөлмөр эрхэлж ахуй амьдралаа сайжруулахад нь, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч хүн бүр үнэ цэнтэй хэмээн хүндлэгдэхэд нь багш, эцэг эхийн хамтын ажиллагааг чухал гэдгийг ойлгож, нэгдэн ажиллах хэрэгцээ чухал байна. Иймээс багш нарын ур чадварыг сайжруулах, мэдээлэл, материаллаг байдлыг хангах, эцэг эхчүүд, олон нийтэд тэгш хамран сургах боловсролын чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах шаардлага байсаар байна.

Ашигласан материал:

1. БСШУС-ын сайдын А\155 дугаар тушаал “ Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, боловсруулах аргачлал батлах тухай
2. БСШУС-ын сайдын 2019 оны А\292 тушаал “ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журам
3. МУ-ын хууль “ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” –ийн 4.13
4. Зан төрх, танин мэдэхүйн бэрхшээлтэй хүүхдийн талаарх ойлголт, илрүүлэх арга зүй бага ангийн багш нарт зориулсан зөвлөмж\ 2020 он

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХЭД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ

С.Ариунгэрэл1
1Эрдмийн өргөө сургуулийн захирал
Ariungerel0304@gmail.com

Үндэслэл:

Дэлхий нийтийн чиг хандлага ялгаатай хэрэгцээндээ нийцүүлэн боловсролд тэгш хамрагдах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч, хөгжихөд ээлтэй орчныг бий болгохыг зорьж байгаа билээ. Учир нь тэгш хамруулан сургах гэдэг нь бүх нийтийн асуудал юм. Боловсрол тэгш хүртээмжтэй байна гэдэг нь суралцахуйн бүхий л үйл явцад тулгарах аливаа саад бэрхшээлийг тодорхойлж түүнийг арилгах замаар тэгш боломж бүрдсэн орчин нөхцөлд боловсрол эзэмших, суралцах үйл явцыг хэлнэ. Монгол улсын хувьд ч боловсрол, сургалтын хүртээмж, явц, үр дүн нь тухайн сурагчийн ар гэрийн нөхцөл, эцэг эхийн боловсрол, орлого, үндэс угсаа, хэл соёл, хөгжлийн онцлог зэрэг тухайн хүүхдээс хамаарахгүй хүчин зүйлээс шалтгаалдаг байж болохгүй хэмээх үзэл баримтлалыг бодлого эрх зүйн баримт бичгүүддээ тусган оруулжээ.

БШУ-ны сайдын гаргасан А/553 тоот тушаалд Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах бодлого чиглэлийг тодорхойлсон бөгөөд бүх түвшний боловсролд суралцагчийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн хувилбарт, сонголттой сургалтуудыг санал болгох, цахим технологийг ашиглан сургалтын уян хатан зохион байгуулалтыг нэвтрүүлэх, эцэг эх асран хамгаалагч нарт чиглэсэн олон талт үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх хэмээн заажээ. Үүний зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБ-ын тусгай сургуулиас бусад хэв шинж бүхий сургуульд сургах эрх зүйн баримт бичиг батлагдан гарсны дагуу эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдээ ердийн сургуульд сургах нь элбэг болжээ. Иймээс эцэг эх, асран хамгаалагчдыг сургуультай хэрхэн хамтран ажиллах, сургуулийн үйл ажиллагаанд яаж оролцох арга замыг боловсронгуй болгох нь өнөөгийн хэрэгцээ шаардлага болоод байна.

Судалгааны зорилго:

Сургуулийн орчинд эцэг эх, асран хамгаалагч нарыг хүүхэдтэйгээ хамтран ажиллах, хичээлд нь туслах замаар хүүхдийн хөгжилд дэмжлэг үзүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийв.

Судалгааны арга зүй:

1. Эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллөөс сургуулийн үйл ажиллагаанд оролцоход тулгарч буй саад бэрхшээлийг илрүүлэх тандалт судалгааг асуулгаар авч нэгтгэх
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч нартай ажиллах сургуулийн үйл ажиллагааны бодлого чиглэл, зохион байгуулдаг үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах

Дээрх судалгаануудыг Excel программ ашиглан хамгийн их хариултаас эхлэн хамгийн бага хариулт хүртэл дараалалд оруулан боловсруулалт хийж гүйцэтгэсэн.

Үр дүн:

Сургуулийн үйл ажиллагаанд өөрийн санаачилгаар оролцдог уу гэсэн асуулгад судалгаанд оролцогчид 100% үгүй гэж хариулжээ. Сургуулийн үйл ажиллагаанд оролцдоггүй шалтгаанаа бичнэ үү гэсэн асуулгад судалгаанд оролцогчдын 80% нь шаардлага гарсан үед очихоос өөр оролцох боломж байдаггүй, 10% нь сургууль, багштай харилцах учраа сайн мэдэхгүй байна, 10% нь мэдээ, мэдээлэл муутай гэж хариулжээ. Сургуулийн ямар үйл ажиллагаанд оролцдог вэ? гэсэн асуулгад судалгаанд оролцогчид 100% нь эцэг эхийн хуралд, School police хийдэг гэжээ.

Дүгнэлт:

Сургуулийн төлөвлөлтөөс харахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн дунд зохион байгуулах үйл ажиллагааг тусгайлан төлөвлөдөггүй. Сургуулийн нийт эцэг эх, асран хамгаалагч нарын дунд зохион байгуулдаг үйл ажиллагаанд оролцдог. Сургуулиас санаачилсан

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

ажлууд ихэнх байдаг, төлөвлөсөн ажлуудад ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд чиглэсэн ажлууд байхгүй. Судалгааны явцад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагч нар сургуультай хамтран ажиллах хүсэл маш их байдаг нь харагдсан. Хүүхдийн онцлогт тулгуурласан шинэлэг ажлыг санаачилж хамтран ажиллавал эцэг эхийн нөөц боломж байна. Эцэг эхчүүдэд чиглэсэн ажлуудыг зохион байгуулахдаа тэднийг сонсогч, ажиглагчийн байр сууринаас биш хүүхдээ ойлгох, хүүхдийнхээ хөгжилд дам болон шууд хэлбэрээр дэмжлэг үзүүлэх боломжтой, оролцоотой ажлуудыг төлөвлөх нь зүйтэй юм. Зөвхөн сургуулийн зүгээс бодлого тодорхойлж нийтлэг ажилд оролцуулаад байвал эцэг эх, асран хамгаалагч нар хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад тулгардаг асуудлыг тэр бүр олж харахгүй өнгөрөх, бодлого шийдвэрт тусахгүй байх аюултай. Тиймээс эцэг эх, асран хамгаалагч нарыг өөрсдийн үр хүүхдийн эрх ашгийг хөндсөн аливаа бодлого шийдвэр, үйл ажиллагаанд оролцуулах замаар тэдний идэвхийг дэмжих хэрэгтэй.

Түлхүүр үг: Эцэг эхийн эрх үүрэг, дэмжлэг, нийгэмшихүйн хөгжил, харилцаа.

Ашигласан материал:

1. *Save the children. (2017). Эцэг эх багштай харилцах сургалтын модуль. Улаанбаатар.*
2. *Unicef. (2021). Анги удирдсан багшаар дамжуулан эцэг эхийн боловсролыг дэмжих нь . Улаанбаатар.*
3. *БШУЯ-ны эрх зүйн баримт бичгүүд. Улаанбаатар.*
4. *Батдэлгэр, Ж. (1997). Боловсрол судлалын ерөнхий үндэс. Улаанбаатар.*
5. *Калкынч, Ф. (2001). Боловсрол гэр бүлээс эхэлдэг. Улаанбаатар.*
6. *Жамц, Л. (1996). Боловсрол судлалын үндэс. Улаанбаатар.*

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ХАМТЫН ОРОЛЦООГООР ДЭМЖИХ НЬ

Т.Бямбахорол1
1Нийслэлийн 290 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч
Bymbaa3051@gmail.com

Үндэслэл:

Сүүлийн үед манай нийгэмд тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэд олноор нэмэгдэх болсон. Тусгай хэрэгцээт хүүхдийг Боловсролын ерөнхий хуульд тэгш хамруулна гэж зааснаар анги бүлэг бүрд 1-3 хүүхэд суралцах болсон. Үүнийг дагаад багшийн ачаалал нэмэгдсэн, тухайн хүүхдийн хөгжих бололцоо ч дутмаг байсан. Үүнийг шийдэх гарц гаргалгаа хийсний үр дүнд байгууллагын менежмент, хамт олон, эцэг эхийн оролцоотойгоор тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийг дэмжих өрөөг бий болгосон. Өрөө бий болсноор хүүхдэд ахиц амжилт гарсан, багшийн ачаалал буурч байгаа нь ажиглагдаж байна.

Судалгааны зорилго:

Байгууллагын менежмент хамт олны оролцоотойгоор тусгай хэрэгцээт хүүхдийг ялгаварлан гадуурхахгүйгээр өнөөгийн нийгэмд сурч хөгжих таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Судалгааны арга зүй:

Хамт олны санал асуулга хэлэлцүүлэг, цэцэрлэгийн нийт эцэг эхчүүдээс авсан асуулга судалгаа, Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн хөгжилд гарсан ахиц үр дүнгүүдэд дүн шинжилгээ хийж үр дүнг боловсруулсан.

Үр дүн:

Судалгаа 1. Бидэнд тулгарсан асуудал бол жил ирэх тусам цэцэрлэгт тусгай хэрэгцээт хүүхэд нэмэгдэж байгаа нь хүүхэдтэй ажиллаж буй бидэнд маш их ачаалал нэмэгдэж байсан. Тусгай хэрэгцээт хүүхдийг сургалт үйл ажиллагаанд тэгш хамруулж, нийгэмшүүлэн хөгжлийн хувьд ахиц гаргах шийдлийг бид хамт олноороо хэлэлцээд дотоод нөөц боломжоо тусгай хэрэгцээт хүүхдэд зориулан өрөө тохижуулж, тухайн хүүхдийг тайвшруулах, өөрийнхөөрөө байх, өөрийнхөө сонгон авсан тоглоом, үйлээрээ стрессээ тайлах, багш хүүхэдтэй тулж ажиллах таатай орчин бүрдүүлж чадсан юм. Тус өрөө ашиглалтад орсноор бүлгийн багш тухайн хүүхэдтэй илүү ажилласнаар хүүхдийн хөгжил, чадварт бага ч болов мэдэгдэхүйц ахиц гарч, хүүхдийн эцэг эх асран хамгаалагчид ч тус өрөөнд сэтгэл хангалуун байгаа нь судалгаагаар харагдаж байсан.

Хамт олны хурлаар хэлэлцүүлэг зохион байгуулсан байдал:

Хамт олны хэлэлцүүлэгт 53 багш ажилтнаас 48 хүн оролцож 90% ийн ирцтэй зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт тэргүүлэгчээр эрхлэгч Т.Бямбахорол, нарийн бичгийн даргаар арга зүйч Ж.Уранчимэг нар ажиллаж байна.


Хэлэлцүүлэгт дэвшүүлсэн санал:

1. Манай хамт олон тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн хөгжлийг дэмжин ажиллаж чадаж байна уу?
2. Хөгжлийн онцлогтой хүүхдэд энэ байгууллагын хүн бүр хүрч ажиллах, туслах, дэмжлэг үзүүлэх ямар ажлыг байгууллага дотроо зохион байгуулвал хөгжлийн онцлогтой хүүхдийг тэгш хамруулах нөхцөл боломжоор хангаж чадна гэж бодож байна вэ? гэсэн 2 асуудлын хүрээнд хэлэлцүүлгийг зохион явууллаа.

Хэлэлцүүлгийн үр дүн:

Энэхүү хэлэлцүүлгийн үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээг хангах, ганцаарчлан ажиллах, өөрийн сонирхолд нийцсэн өрөөг байгуулахыг 100%-ийн саналтайгаар дэмжсэн. Үүний дагуу ажлын төлөвлөгөө боловсруулан ажилласан.

График 1. Ангид сурах нөхцөл, орчин бүрдсэн эсэх



Судалгаа 2. 290-р цэцэрлэгийн нийт эцэг эхчүүдийн дунд GOOGLE FORM ашиглан 318 эцэг эхийн санал хүсэлтийг хүлээн авсан. Энэ нь нийт эцэг эхийн 60%-ийг хамруулсан. Энэхүү судалгааны гол зорилго нь цэцэрлэгийн нийт эцэг эх, асран хамгаалагчдын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх ойлголт мэдлэг, мөн тусгай хэрэгцээт хүүхэд хамрагдаж буй ангийн эцэг эхчүүдэд гарч буй бэрхшээл асуудал, мөн санал сэтгэгдлийг хүлээн авахыг зорьсон.

Дүгнэлт:

Энэхүү судалгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл аюулгүй, сурч

хөгжих орчин нөхцөлийн талаарх эцэг эх, асран хамгаалагч нарын сэтгэл ханамжийг харуулахыг зорьсон юм. Үүнд МХБ-ийн багш нарын “Чимээгүй булан”-г буюу номын төвийг түшиглэн хийсэн тусгай хэрэгцээт хүүхдийн сурах орчин нь хангалтгүй байгаа гэж нийт судалгаанд хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчдын 51% нь үзсэн байсан. Үүнээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тулгуурлан сурах, хөгжих таатай орчин хэрэгцээ шаардлага бий болсон нэг чухал илрэл юм.

Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийг дэмжих төв байгуулах үйл явц:

Тус төвийг байгуулахад хамт олны оролцоо, эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг туслалцаа их шаардлагатай байсан. Ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу ажлаа хуваарилан авч тус, тусынхаа ажил үүргийн чанартай биелүүлж, хамт олон бүгд гар бие оролцон тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийг дэмжих төвийг амжилттай бий болгож үйл ажиллагааг эхлүүлсэн.

Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийг дэмжих төв:

Нийслэлийн 290 дүгээр цэцэрлэг нь 2021 оны 02 сарын 28-ны өдөр үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн Боловсролын Ерөнхий хуульд заасны дагуу тэгш хамруулах боловсролын бодлогыг дэмжин ажиллаж, тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах орчин нөхцөл, хөгжлийг дэмжих зорилгоор шат дараалалтай төлөвлөгөөний дагуу ажилласны үр дүнд **“Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийг дэмжих төв”**-ийг 2023 оны 01 сарын 02 өдөр үүсгэн байгуулсан. Энэ төвийг үүсгэн байгуулахад байгуулга хамт олон, багш, эцэг эх, асран хамгаалагч нарын санал санаачилга, оролцооны үндсэн дээр бий болсон.

Судалгаа 3. 290-р цэцэрлэгийн тусгай хэрэгцээт 6 хүүхдийн хөгжлийн түвшнийг тодорхойлон, бүлгийн багш нарын ганцаарчлан ажиллах төлөвлөгөөнд тулгуурлан эзэмшүүлэх агуулгыг холын зорилт болгон ганцаарчлан сургалтын явуулсан ахиц өөрчлөлтийг хүснэгтээс үзэхэд:

Бүлгийн багш: Юунибилэг	Холын зорилт: Гар угаах дарааллыг бусдын дэмжлэгтэйгээр хэвших	Түвшин 3 /хөгжлийн түвшин/ Ахлах бүлэг	Бүлгийн багш: Б.Золбаяр	Холын зорилт: “За, май”, “Баярлалаа”, “Уучлаарай” зэрэг үгийг хэрэглэж, үйл хөдөлгөөр илэрхийлэх	Түвшин 5 /хөгжлийн түвшин/ Дунд бүлэг	Бүлгийн багш: В.Ариунтуул	Холын зорилт: Дүрсийг хэвэнд тохируулан хийх	Түвшин 1 /хөгжлийн түвшин/ Ахлах бүлэг
Агуулга	Бусдын зааврын дагуу гар угаах дарааллыг зөв гүйцэтгэх		Агуулга:	“За, май”, “Баярлалаа”, “Уучлаарай” зэрэг үгийг хэрэглэж хэвших		Агуулга	Хэвнээс дугуй дүрсийг гаргах	
Орчин	Гар угаах		Орчин:	Бусдад суудал/дараалал тавьж өгөх, эд юмс өгөх, бусдаас туслалцаа авах, бусдад төвөг удсан нөхцөл байдалд		Орчин	Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийн өрөө	
Ахиц өөрчлөлт: олон удаагийн илгэлт, сэрлэлтүүрл, иллагааны дүнд	1. Нүүрийг угаахад дургуйцаж уйлдаг байсан бол дэмжлэгтэй-гээр угаалгах дуртай болсон.	2. Гарыг бохирдсон үед угаадаг гэдгийг мэдэх, багшийн дэмжлэгтэй-гээр гараа угааж хөвшиж сурна.	Ахиц өөрчлөлт /олон удаагийн давтамж-тайгаар, үйл ажиллагаа нь үр дүнд/	Багштайгаа болон ангийн найзуудтайгаа мэндлэх, “Баярлалаа”, “Уучлаарай” зэрэг үгийг хэрэглэж, үйл хөдөл, биеийн хэлэмжээр илэрхийлж чаддаг болсон.	Бусдад болохгүй гэдгийг мэдэх, төвөг удсан “Баярлалаа”, “Уучлаарай” гэсэн үгийг хэлэмжээр хэрэглэж хэвшсэн. Хүүхэд зөв үйлдлээр илэрхийлж хэрэглэсэн тохиолдолд магтана.	Ахиц өөрчлөлт /олон удаагийн давтамж-тайгаар/	Багш дүрсийг нэг нэгээр нь хэвэнд хийж үзүүлнэ. Багш хүүхдэд “Дүрсийг хэвнээс гаргаарай” гэж хэлнэ. Багшийн зааврын дагуу үйллийг хийнэ.	Хүүхэд дүрсийг гаргаж чадвал алга ташиж урамшуулна. “Гаргасан дүрсээ багцдаа өгөөрэй” гэж хэлэхэд хүүхэд дүрсийг авч өгсөн. Хэвийн багшид өгөхийг хүсэхэд өгч багш харин нь магтана./эрхий гозойлох, алга таших гэх мэт/

Хөгжлийн түвшинд гарсан ахиц өөрчлөлт:

Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийн ахицыг ажиглахад түвшин 1 ба 2 чадварыг эзэмшээд, дараагийн түвшингийн чадваруудыг холын зорилт болгон багш ганцаарчлан ажиллах төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Хөгжлийн түвшингийн үзүүлэлтээр суралцагчдын 90% ахисан үзүүлэлтийг харуулж байна. Үүнээс үзэхэд тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийг дэмжих

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

өрөөнд багшийн ганцаарчлан ажиллаж буй сургалтын ахиц үр дүн үүгээр харагдаж байна. Дүрслэхийн чадварын хувьд хүүхдийн тухайн хүүхдэд илэрч буй зан чанарын онцлог дээр тулгуурлан сарайчих үйлээс дээшилж, дугуй дүрсийг дүрслэн хүний нүд амны зураглал гарган дүрсэлж чадаж байгаа нь ажиглагдсан. Мөн энэхүү төвд хамрагдсанаас хойш нийгэмшихүй болон эцэг эх, цэцэрлэгийн аль ч ажилтантай хамтран тоглож, өөрийгөө тодорхой хэмжээнд биеийн хэлцэмж, богино үгээр илэрхийлж чадсан нь хөгжлийн ахиц юм.

Дүгнэлт:

Манай цэцэрлэг нь 2021оны 2дугаар сарын 28-ны өдөр хүүхдүүдээ хүлээж авч үйл ажиллагаагаа албан ёсоор явуулж эхэлсэн. 2021 оны байдлаар 3 хүүхэд 3 багш байсан бол 2022 онд 4 хүүхэд 4 багш, 2023 онд 6 хүүхэд 5 багш болж тусгай хэрэгцээт хүүхдийн тоо нэмэгдсэн. Түүнийгээ дагаад бид бүхэн тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийг дэмжих олон олон аргуудыг хэрэглэж, туршиж үзсэний үр дүнд хамтын оролцоотойгоор менежментээ сайжруулж “Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийг дэмжих төв” байгуулж түүгээрээ дамжуулан цэцэрлэгийнхээ тусгай боловсрол шаардлагатай хүүхдүүд болон эцэг эхэд үйлчлэн ахиц гаргаж чадсан нь манай хамт олны ДЭВШИЛТТЭЙ тал юм. Мөн эцэг эхийн хандлага өөрчлөгдөж, хүүхдээ хөгжүүлэх хүсэл эрмэлзэл нэмэгдсэн. Цаашид энэхүү төвийнхөө үйл ажиллагааг улам бүр өргөжүүлж олон хүүхэд, эцэг эхчүүдийг хөгжүүлэх, дэмжсэн үйл ажиллагааг тогтмол явуулна.

Хүндрэл бэрхшээл: Хамгийн их тулгарч байсан бэрхшээл бол хөрөнгө мөнгөний бэрхшээл байлаа. Бид үүнийгээ хамт олны хүч, хичээл зүтгэл, эцэг эхийн дэмжлэгээр даван туулж тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийг дэмжих төвтэй болсон.

Дэвшүүлж буй санаа:

Төр засаг-БШУЯ-НБГ: Төрийн өмчийн ЕБС, СӨБ-д хүүхэд бүрийг тэгш харуулан гэсэн чиглэлийн хүрээнд тухайн цэцэрлэг сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан стандартын дагуу гадна болон дотоод орчин зайлшгүй бүрдүүлж, аюулгүй тав тухтай сурах орчныг хангах.

Байгууллага-цэцэрлэг: Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах, тэдний сэтгэл зүйн боловсролд анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай тул цэцэрлэг сургуулиуд сэтгэл зүйчтэй болох. Мөн цэцэрлэг бүр дотоод хамт олны нөөц боломжид тулгуурлан тусгай хэрэгцээт хүүхдэд тусгайлан зориулсан төвийг байгуулан ажиллавал илүү үр дүнтэй нь харагдаж байна.

Ашигласан материал:

1. Батдэлгэр.Ж. “Бага насны хүүхдийн сэтгэл судлал”,.УБ.,2013 он
2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрх”,.УБ.,2021 он
3. “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”,.УБ.,.2019 он
4. “Туршилтын сургуулийн эмхэтгэл”,.УБ.,.2019 он
5. “Үндэсний статистикийн хороо”-ны мэдээллийн сан,.УБ.,2022 он

ХӨГЖЛИЙН ОНЦЛОГТОЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАЖ БУЙ БАГШИЙН АРГА ЗҮЙ, УР ЧАДВАР, ХАНДЛАГА ЧУХАЛ БОЛОХ НЬ

Н.Ариунболор1

1Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, Ерөнхий боловсролын 1-р сургуулийн багш
Ariunbolor.abo@gmail.com

Үндэслэл:

Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”-д Зорилт 2.1. хүрээнд: Хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн үе хэмээн тодорхойлсон байна. Энэхүү зорилтын хүрээнд хөгжлийн онцлогтой сурагчтай багш нэг бүр ажиллах хэрэгцээ шаардлага бий болж байна. Мөн монгол улсын хувьд сүүлийн гурван жилд ЕБС-д суралцаж байгаа тусгай хэрэгцээт хүүхдийн тоо өссөн ба цаашид ч өсөх хандлагатай байна. Миний бодлоор хөгжлийн онцлогтой хүүхдийг бусдын ижил сургах, хөгжүүлэх боломжтой бөгөөд багшийн арга зүй ур чадвар, хүнлэг сэтгэл, хичээл зүтгэл маш чухал юм гэсэн таамаглал дэвшүүлсэн ба түүнийгээ нотлохыг хичээлээ.

Судалгааны зорилго:

Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллаж буй багшийн ур чадвар, хандлага, арга зүй нь тухайн хүүхдийн хөгжилд нөлөөлж буй хамгийн чухал хүчин зүйл гэдгийг батлах зорилготой.

Судалгааны арга зүй:

Ажиглалтын арга, ярилцлагын арга, асуулгын арга, харьцуулсан судалгааны арга.


Үр дүн:

Багш нараас идэвх санаачилгатай ажиллаж, хичээл үр дүн нь ил харагдаж, богино хугацаанд мэдээлэл цуглуулж болохуйц 3 багшийн үйл ажиллагааг ажиглан судалж ярилцлага хийсэн. Үүний үр дүнд багш нарын нийтлэг арга зүйн онцлог нь:

- Өдөр бүр хүүхэдтэй тогтмол ажиллаж үр дүнгээ хянах
- Хэрэглэгдэхүүний тохируулгыг маш сайн хийх
- Орчны тохируулгыг хийж, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх
- Гарын жижиг булчинг хөгжүүлэх дасгалыг тогтмол хийлгэх
- Анги нийтийн хичээлд тухайн сэдвийн дагуу ижилхэн хичээллүүлэх ба зөвхөн тухайн хүүхдийнхээ чадварт тохирсон дасгал даалгаврыг тусад нь бэлтгэж хичээлд оролцуулдаг.


Асуулга судалгааг Аймгийн төвийн 1-р сургууль, Уулбаян сумын сургуулийн багш нараас авч харьцуулсан. Үр дүнг харахад ХБ-тэй сурагчтай ажиллахад ажлын ачаалал, арга зүйн дутмаг байдал гэх мэт хүндрэл бэрхшээл учирч байна. Мөн ярилцлагын явцад багшийн арга зүй чухал гэдгийг илэрхийлсэн бөгөөд багш мэдрэмжтэй, сэтгэл зүтгэлтэй тухайн хүүхдийнхээ царайны хувирал, ядрал, дуртай дургүй байгаа өнгө аяс зэргийг мэдэрдэг, тухайн цаг үед тохирсон даалгавар сургалтын хэрэглэгдэхүүн ашигладаг зарим үед хичээл гэхээс илүү урам

Сүхбаатар аймгийн ЕБ-н 1-р сургууль
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад багш таны арга зүй ур чадварын түвшин
22 responses




Уулбаян сумын ЕБ-н сургууль

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад багш таны арга зүй ур чадварын түвшин




Сүхбаатар аймгийн ЕБ-н 1-р сургууль
3. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах сонирхолтой эсэх
22 responses



Уулбаян сумын ЕБ-н сургууль

3. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах сонирхолтой эсэх



Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

өгч, дэмжиж, хайрлаж байх хэрэгтэй гэдгийг онцгойлж байв. Мөн Уулбаян сумын багш нарын хувьд тусгай хэрэгцээт сурагчтай ажиллах сонирхолгүй байгааг харж болохоор байна. Энэ нь тусгай хэрэгцээт хүүхдийн тоо цөөн, зайлшгүй ажиллах шаардлага гарах нь бага байхтай холбоотой ба ХБ-тэй хүүхэдтэй зайлшгүй ижил боломж олгож ажиллах ёстой гэдэг ойлголт сайн түгэн дэлгэрээгүй байгаатай холбоотой, өөрсдөөсөө ачааллыг холдуулах хандлагатай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн түвшний хувьд муу, дундаж гэсэн хариулт ихэнх хувийг эзэлж байгаа нь, арга зүйн дэмжлэг мэдлэг мэдээлэл сумын сургуульд хүрэхгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Дүгнэлт:

Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллаж буй багшийн ур чадвар, хандлага, арга зүй нь тухайн хүүхдийн хөгжилд нөлөөлж буй хамгийн чухал хүчин зүйл мөн боловч сургуулийн бодлого, багш нарын үйл ажиллагааг дэмжих, зайлшгүй чухал гэдгийг анхаарах шаардлагатай байна.

Дэвшүүлэх асуудал:

- Багш нар сургалт үйл ажиллагаагаа тэгш хүртээмжтэй явуулж, ХБ-тэй суралцагчид ижил боломж олгоход БГ зөвлөн тусалж, хяналт тавих
- Нийгмийг эерэг зөв ойлголттой болгох мэдээ мэдээллээр тогтмол хангах
- Орчин нөхцөл, тусгай хэрэглэгдэхүүнээр хангах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
- Багшийн ажлын ачааллыг тооцож, үр дүнд суурилсан нэмэгдэл урамшуулал олгох
- Багшийн ур чадвар арга зүйг дэмжиж тусалж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх
- Багшийн ур чадвар, хандлага, арга зүйгээс гадна, сургуулийн бодлого удирдлагын дэмжлэгийг нэмэгдүүлэх

Түлхүүр үг: Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга зүй, багшийн хандлага, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө.

Ашигласан материал:

1. БШУЯ, FPJ, Save the Children. (2020). “Тэгш хамруулах боловсрол” Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль. Улаанбаатар.
2. БШУЯ, ADB, JFPR, FPJ, ТБШХ.(2022). Тэгш хамруулсан сургалтыг хэрэгжүүлэх зөвлөмж. УБ
3. Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэдтэй ажиллах арга зүй, УБ 2016 х-7
4. БШУЯ, ADB, JFPR, FPJ, ТБШХ.(2023). Тэгш хамран сургах боловсролын бодлого, соёл, үйл ажиллагааг хэрэгжүүлэх сургалтын гарын авлага. УБ.
5. Х.Бямбажав, МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн Тэгш хамрах боловсролын тэнхимийн багш, “Тусгай боловсролын удиртгал”лекц

**СӨБ-Н БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДҮҮДЭД БАГА НАСНААС НЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ,
ТЭГШ ХҮРТЭЭМЖИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТЫГ БИЙ БОЛГОХ НЬ**

Б.Болор, Г.Батгэрэл1
1Чингэлтэй дүүргийн 298-р цэцэрлэг
bobo22994@gmail.com

Үндэслэл:

Боловсролын хуульд зааснаар хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэлх хүүхэдэнгийн ангид хамрагдах боломжтой. Гэвч хөгжлийн бэрхшээлийг албан ёсоор тодорхойлох, оношлох явдал сул бөгөөд тохиромжтой үнэлгээ хийгддэггүй мөн тодорхойлохдоо эмч, эмнэлгийн магадалгааг шаарддаг. тул цэцэрлэгийн багш нар хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн түвшнийг өөрсдөө тодорхойлох шаардлагатай болдог. Хөгжлийн бэрхшээлийн төрөл болон хүндрэлийн түвшнээс болоод багш нар хүүхдүүдтэй ялгавартай байдлаар харьцах магадлалтай байж болох билээ. Цэцэрлэгийн нэг анги хэт олон буюу 35–40 хүүхэдтэй тул ажлын өндөр ачаалал болон багшийн туслах ба бусад төрлийн тусламжгүй тохиолдолд багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг энгийн ангид суралцахаас халширдаг. Иймээс багш бид мэргэжлийн онол, арга зүй, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхийн тулд ажилдаа дасан зохицох нь хамгийн чухал асуудал болоод байна. Сүүлийн жилүүдэд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нь өссөн судалгааг үзэхэд бага насандаа эрт илрүүлэгт хамрагдаж чадахгүй мөн энэ асуудал нь эцэг эх асран хамгаалагч нар нь хүлээн зөвшөөрөхгүй удаашрах хандлагаас болоод хүүхэд өөрт тохирсон мэдлэг болоод нийгэмшихүйн үйл явц асуудал үүсээд байна.

Сургуулийн өмнөх нас буюу 2-5 насанд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэг хийж шат дараатай арга хэмжээ авах нь аль аль талдаа хэрэгтэй бөгөөд хүүхэд өөрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн боловсролыг эзэмших боломж байгаа цаашид сургуулийн өмнөх боловсролын хүрээнд бага наснаас нь ердийн хүүхдүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тусалдаг дэмждэг ойлгодог болох төлөвшил хандлагыг бий болгох нь зүйтэй хэмээн энэхүү сэдвийг сонгох болсон нэг үндэслэл юм.

Судалгааны зорилго:

Цэцэрлэгийн багш нар хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хэрхэн ажиллаж буй арга зүй туршлагыг судлах.

Судалгааны арга зүй:

Асуулга-анкетын арга, харьцуулах, мэдээллийг нэгтгэн дүгнэх аргыг ашиглав.

Үр дүн:

Судалгаанд нийт 21 багш хамрагдсан бөгөөд 16 нь улсад ажилладаг 5 нь хувийн хэвшлийн нийт 7 цэцэрлэгийн багш нар хамрагдсан үүнээс 5 цэцэрлэг нь улс бөгөөд 2 цэцэрлэг нь хувийн хэвшлийн. 5 улсын цэцэрлэгээс 2 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг.

Энэ нь ЧД-н 2 цэцэрлэг бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэйгээ ганцаарчлан ажиллах төлөвлөгөөний дагуу ажиллаж байгаа хэдий ч туршлага арга зүй хуваалцах болон дэмжлэгийн багийн үйл ажиллагаа дутмаг байгаа нь ажиглагдсан.

Дүгнэлт:

Ихэнх цэцэрлэгүүд ганцаарчлан ажиллах төлөвлөгөө хийгддэг бөгөөд дэмжлэгийн багаар асуудлаа шийдвэрлэдэггүй ба мэргэжлийн байгууллагуудаас туслалцаа дэмжлэг авч тулгамдсан асуудлуудаа тухай бүрд нь шийдвэрлэж чадахгүй байна. Мөн ганцаарчлан ажиллах хүүхэдтэйгээ тусгай хэрэгцээ шаардлагын дагуу болон түний эцэг эхтэй хамтран ажиллаж байгаа хэдий ч цэцэрлэгийн удирдлага болон дэмжлэгийн багийн ажлуудыг сайжруулах ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг арга зүйн туршлагаасаа хуваалцдаг мэргэжил нэгт багш нар өөр хоорондоо мэдлэг мэдээллээ солилцох нь үр дүнтэй ажил явагдана гэж бодож байна. Дэмжлэгийн багийн амжилттай ажилласан сайн туршлагаа хуваалцана уу гэсэн асуумжид тодорхой туршлага гэж харагдаагүй нь энэ талын асуудал дээр анхаарах шаардлага байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад хүүхдийн тоо нэг ангид дунжаар 30-40 бөгөөд эцэг эх хүлээн зөвшөөрдөггүй гэх асуудлууд одоог хүртэл хэвээрээ байгаа нь багшийн сургалт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

үйл ажиллагаа явуулахад бэрхшээл гарч байгаа бөгөөд цаашид энэ асуудлыг сайжруулах шаардлагатай.

Санал:

Тухайн байгууллагын багш, хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нарт:

1. Цэцэрлэгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах дэмжлэгийн багийн үйл ажиллагааг сайжруулах
2. Багш нар нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй дутмаг тул сургалтыг сайжруулах мөн мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж багш болон эцэг эх, асран хамгаалагч нартаа сургалт зохион байгуулах.
3. Олон нийтэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлэх нь ач тустай байх гэсэн зөвлөгөө зөвлөмжийг түгээн дэлгэрүүлэх.

Хөгжлийн бэрхшээл ба тэгш хамруулах СӨБ нас буюу 2 наснаас эхлэн ойлголт өгөх

Хөгжлийн бэрхшээлтэй тусгай хэрэгцээ шаардагдсан хүүхдүүд одоо цагт мөн ирээдүйд ч байх учраас бага наснаас нь энэ хүүхдүүдийн талаар ойлголт өгч тусалж дэмждэг сайхан сэтгэлтэй байх “ЗҮРХ СЭТГЭЛИЙН БОЛОВСРОЛ” олгох үүнд:

- Тухайн сургууль, цэцэрлэг нь өөрсдийн дотоод зохион байгуулалт жилийн ажилд тусган үйл ажиллагааг чанаржуулах
- Бага нас буюу 2-5 настай хүүхдүүд хэрэгцээ шаардлагатай нэгэндээ тусалдаг дэмждэг гэсэн ойлголтыг өгч нийгэмшүүлэх. Сургалт болон бусад цагуудаар сардаа 2 удаа зориудын зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулж хэвших
- Дэмжлэг хэрэгтэй болон тусгай хэрэгцээ шаардагдаж байгаа хүүхдийг гадуурхах үл ойшоохгүй байх тал дээр сануулга болон самбар байршуулах.
- Сургууль цэцэрлэгийн орчинд нийгмийн болон бусад дэмжлэгийн багууд үйл ажиллагаа зохион байгуулж явуулдаг байх.
- Олон нийтийн цахим сүлжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусалж энэрч хайрлаж байгаа богино хэмжээний хүүхэлдэйн кино, өгүүллэг, контент байршуулах.

Түлхүүр үг: Зөв хандлага, зөв төлөвшил.

Ашигласан материал:

1. Тэгш хамруулан сургах боловсрол УБ-2024 он
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн гарын авлага УБ-2019 он
3. Тэгш хамруулан сургах бодлогын хураангуй УБ-2023 он
4. https://cdn.greensoft.mn/тэгш_хамруулах_боловсролыг_дэмжих_төсөл-2022, тэгш хамруулах боловсрол бодлогын хураангуй-2023

ДЭЭД БОЛОВСРОЛЫГ ХҮРТЭЭМЖТЭЙ ОЛГОХ НЬ (СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

Ш.Оюумаа1

1ШУТИС, Гадаад хэлний сургууль, Хэрэглээний хэл шинжлэлийн салбар
oyumaa@must.edu.mn

Үндэслэл:

Дэлхий даяар хэрэглэдэг зөвхөн ганц дохионы хэл байхгүй. Газар зүй, түүхээсээ шалтгаалан бүгд өөр хоорондоо ялгаатай. Дохионы хэлээр ярьдаг хүмүүс өөр орны дохионы хэл сурах хэцүү. Бид гадаад хэл сурах гэж жил, арван жилийг зарцуулдагтай адил. Хэрэв ерөнхий боловсрол, их дээд сургуулиудын багш нар дохионы хэлний мэдлэгийг багшийн боловсрол олж, суралцаж байх хугацаандаа эзэмшиж чадвал хичээлээ давхар дохионы хэлээр зааж сонсгол болон ярианы бэрхшээлтэй иргэдэд дээд боловсрол эзэмших боломж илүү нээлттэй болох болно. Тэр дундаа тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан хөтөлбөр дэлхийн бусад оронд маш өргөн цар хүрээтэй хэрэгждэг тул монголын тусгай хэрэгцээт иргэд англи дохионы хэлийг сурсан байхад гадаад орон тэдний хувьд нээлттэй гэсэн үг юм.

Судалгааны зорилго:

Англи, монгол дохионы хэлний ижил төстэй талыг олж гаргаад ирвэл сургагч багш нарт сурахад амар байх ба давхар тусгай хэрэгцээт иргэдийн хэлний мэдлэг дээшлэх ч боломж бий гэх зорилго тавин дараах судалгааг хийсэн болно.

Судалгааны арга зүй:

Америкийн дохионы хэлний 2022 оны судалгаа (ASL 2022 survey Social Media message), Towards Sign language-Centric Design of ASL Survey tools, зэрэг судалгаанаас шинжилгээ хийн үр дүнг боловсруулсан.

Үр дүн:


Хуруугаар үсэглэх нь мөн л америк дохионы хэлний нэгэн хэсэг. Хүний нэр, гарчиг зэрэгт хурууны үсэглэл /Fingerspelling/ ашигладаг. АНУ-ын хувьд сонсголын бэрхшээлтэй эцэг эхээс сонсголын бэрхшээлтэй хүүхэд төрх нь аравт нэг тохиох тоон үзүүлэлт байдаг бөгөөд ийм нөхцөл байдалд хэвийн сонсголттой эцэг эхийг нэгдсэн дохионы хэлний сургалтад хамруулах үндэсний хөтөлбөр байдаг нь сонсголын бэрхшээлтэй хүүхдийг эртнээс дохионы хэлэнд сургаж нийгэмшүүлэх маш том алхам болдог аж.

Харин монгол улсын хувьд ийм сургалт, үйл ажиллагаа байхгүй. Тиймээс зөвхөн тусгай хэрэгцээт сургуульд тухайн хүүхэд хамрагдаж байж дохионы хэлэнд суралцдаг. Эцэг эх, асран хамгаалагч өөрөө судалж ойр зуурын биеийн хэлийг ашиглаж харьцдаг. Биеийн хэл, дохионы хэл хоёр нь тусдаа ухагдахуун юм.

Зураг 1: Монгол дохионы хэлний цагаан толгой



Зураг 2: Англи америк дохионы хэлний цагаан толгой



Дүгнэлт:

Уг судалгаагаар монгол, англи хэлний дохионы хэлний ижил төстэй зүйлсийг гаргаж ирснээр монгол дохионы хэлээр харилцдаг сонсголын болон ярианы бэрхшээлтэй иргэдэд дээд боловсролыг тэр дундаа ахисан түвшний англи хэлийг тус иргэдэд суралцах давуу боломжийг гаргах гэсэн ч монгол, англи дохионы хэл нь ойролцоо тал маш хомс байгааг харж болно. Хэрвээ монгол дохионы хэлээ бүрэн дүүрэн сурсан бол Англи дохионы хэлийн аль болох бага насандаа сурвал илүү үр дүнтэй гэж судлаачдын хийсэн судалгаанаас харагдаж байна. Монгол дохионы хэлээр харьцдаг хүн дохионы англи хэл сурахад ижил төстэй гэхээс илүүтээ шинийг илэрхийлж сурах нь илүү дээр гэсэн үр дүнд хүрлээ. Хэлтэй бол хөлтэй гэдэг шиг хэдий сонсголын бэрхшээлтэй ч гэсэн англи дохионы хэл сурсан байхад гадаадын оронд их орноо төлөөлөн оролцож болох хурал, олон нийтийн ажил, тэтгэлэгт сургалт байдаг. Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан дээд боловсрол эзэмших боломж нээгдэж түүгээр ч хязгаарлахгүй монгол дахь сонсголын бэрхшээлтэй иргэддээ дараагийн шатны гүүр болох боломж бий. Тиймээс их дээд сургуулиудын багш нар багшлах эрх авах сургалтад дохионы хэлний мэдлэгийн хичээлийг нэмж оруулж өгвөл монгол улсын иргэдийн цөөнх болох хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдэд илүү боломж нээгдэх гарц бий болно. Гэсэн хэдий ч сонсголын бэрхшээлтэй гэж хэн нэгнээс ямар нэгэн зүйлээр дутуу гэсэн үг биш тиймээс илүү ихийг суралцаж дэлхийн алдартай инженер, шинжлэх ухаанч, спортын тамирчин гэх мэт өөрийн хүссэн мэргэжлийг эзэмшин амжилттай нэгэн болох боломж бий.

Түлхүүр үг: Сонсгол, бэрхшээл, дохио зангаа, тусгай хэрэгцээ, боломж.

Ашигласан материал:

1. *Сонсголгүй боловсрол ТББ (2017). Дохионы хэлний зурагт толь бичиг. Монгол улс, Улаанбаатар хот.*
2. *Монгол дохионы хэлний толь: Дохионы хэл сурахад тань тусалъяа. (2014).*
3. *Монгол Улс, Улаанбаатар хот.*
4. *Martin L.A. Sternberg. (2018). American Sign Language dictionary.*
5. *Baron's (2020). American Sign Language. A Comprehensive Guide to ASL.*
6. *Irene Duke (2016). Learn Sign Language in a Hurry.*

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, СУРЧ БОЛОВСРОХ АСУУДАЛД МАЛЧИН ЭЦЭГ, ЭХИЙН ОРОЛЦОО

Ч.Чулуунтуяа¹

¹Зөрчлийн хэрэг бүртгэх алба, Зөрчлийн хэрэг бүртгэлт, мэргэжил арга зүйн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа

Үндэслэл:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, сурч боловсрох асуудалд хандах нийгмийн хандлагыг өөрчлөх чиглэлээр орон нутгийн төрийн болон төрийн бус, боловсролын байгууллагатай хамтран малчин эцэг, эх (асран хамгаалагч)-ийг тусгай хөтөлбөр, сургалтад хамруулан, сурган дадлагажуулж цаашид хүүхдийн хөгжих, сурч боловсрох эрхийг хангах чадвар эзэмшүүлэх.

Судалгааны зорилго:

Хөдөө орон нутаг, алслагдмал дүүрэгт оршин сууж, амьдрах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангах, цаашдын амьдралд тулгарах хүндрэл бэрхшээлийг даван туулах чадвар эзэмшүүлэхээр малчин эцэг, эх (асран хамгаалагч)-ийг тусгай хөтөлбөр, сургалтад хамруулан багшлах арга барил суулгах.

Судалгааны арга зүй:

БСШУСЯ GPE WB (2019). Монгол Улсын бага боловсролын салбарын судалгаа тайлан. Монгол Улс, Улаанбаатар хот. UNESCO SDG GEMR (2016). Хүмүүс, гараг дэлхийн төлөө боловсрол: Бүх нийтийн төлөө тогтвортой ирээдүйг бүтээх нь. Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлангийн хураангуй. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын ялгаварлан гадуурхалтад өртөх, нийгмийн сөрөг хандлагын судалгаа”-ны тайлан, илтгэлүүд, нийгмийн социал медиа орчны мэдээллүүдэд агуулгын шинжилгээ хийн үр дүнг боловсруулав.

Үр дүн:

Тусгаар тогтносон бүрэн эрхт ардчилсан Монгол улсын төрийн байгууллага, түүний салбар нэгжүүд, албан хаагчид бид Монгол улсын үндсэн хууль, төрийн албаны болон бусад хуулийн дагуу хүлээсэн үүргээ чин шударгаар биелүүлж иргэний хуулиар олгогдсон үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэх, тэгш эрхийн зарчмыг ханган, нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах, тэднийг адилхан боломжтой, хамтдаа амьдрах орчин бүрдүүлэхээр ажиллаж байгаа нь нийгмийн харилцаа, үр дагавар тодорхойлж байдаг. Өдөр, хоног, сар жилээр улс орны хөгжил дэвшил сайжирч, эдийн засаг, улс төрийн байдал тогтворжихын хирээр хүний эрхийг хангах чиглэлээр түлхүү анхаарч, ажилласнаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулах, тэдний нийгэмд амьдрах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх салбарт хэрэгжүүлдэг тэгш байдлын үзэл боломж бүрдэж байгаа боловч Монгол орны онцлог байдал (малчин гэр бүлийн хүүхдүүд)тэдэнд тохирсон сургалтын хөтөлбөр, материал, хэрэгцээнд нийцсэн тусгай сургалт, багшлах арга барил шаардлагатай гэж үзэн дараах асуудлыг хөндөж байна. Үүнд:Боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжиж малчин эцэг эх (асран хамгаалагчдын) чадавхыг дээшлүүлэх хүүхдэд ээлтэй сурч боловсрох, хөгжих нөхцөлийг бүрдүүлэх орон нутгийн байгууллага хоорондын хамтын ажиллагааны уялдаа холбоог богино хугацаанд, үр дүнтэй сайжруулах чиглэлээр арга замыг тодорхойлох нь зүйтэй. Ингэж чадсанаар малчин эцэг, эх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэдээ тэгш хамруулах боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох, хөгжих эрхийн талаарх мэдлэг, чадвар сайжрах юм.

Дүгнэлт:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, гэр бүлд тохиолддог хүндрэл бэрхшээлийг даван туулахад туслах, зөвлөх чадвар, хүүхдийн сурч боловсрох, хөгжих эрхийг хангах үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадварыг эзэмшүүлэх байдлыг бий болгох ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих, сурч боловсрох асуудалд хандах нийгмийн хандлагыг өөрчлөх, орон нутгийн засаг захиргаа, боловсролын болон бусад байгууллага, иргэдийн оролцоог

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

нэмэгдүүлснээр хүүхдүүд болон эцэг, эхийн сурах боловсрох орчныг бүрдүүлэх нөхцөл байдал сайжирна. Хүүхдийн сурч боловсрох, хөгжих хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр дэмжин туслах арга замуудыг тодорхойлсноор, хүүхэд бүр өөр өөрийн онцлог, чадвар, сэтгэл зүйтэй байгааг анхаарч хөгжлийн бэрхшээлийн онцлог болгонд тохирсон дэмжлэг үзүүлэх юм. Хүүхдийн бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц гарахуйц ажил арга хэмжээг цогцоор нь зохион байгуулж, үр дүнг хүүхдийн хөгжлөөс шалтгаалан тооцох нь зүйтэй. Жишээлбэл: Харааны бэрхшээл, оюун ухааны бэрхшээл, хэл ярианы бэрхшээл, хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагч нартай хамтарсан сургалтыг боловсруулж, тэдний амьдрал, ажлын нөхцөл байдлыг уялдуулан хамруулах, мөн хүүхэд хөгжих эрхээ амралт, чөлөөт цагаараа тоглож наадах, хүүхдийн зуслан, сувилалд амарч сувилуулах, өөрийн хүсэл сонирхлын дагуу уралдаан тэмцээн, хөгжлийн хөтөлбөр, дугуйлан секц, клубт хамрагдах, хөгжлийн төв, ордонд суралцах зэрэг хэлбэрээр нь тодорхойлж дэмжих явдал нь амьдралын эрч, хүч баяр баясгалан, ертөнцийг үзэх үзэл, нийгмийн хандлагыг өөрчлөхөд хамгийн чухал нөлөөтэй. Үүний үр дүнд малчин эцэг эх хүүхдийг сургуульд суралцуулахын ач тус, үр нөлөөг ойлгож, хичээл сургалтын үйл ажиллагаанд тасралтгүй хамруулах хандлагатай болж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах тэгш хүртээмжтэй байдлыг би болгоно гэж үзэж байна. Аз жаргалын гурван тулгуур бол эрүүл мэнд, хайр халамж, нөөц боломж гэж үзэж байгаа тул багш сургууль болон бусадтай хамтран суралцах, хөгжих нөөц боломжийг бүрдүүлэх талаар санал санаачилгатай байж чадвал хүүдийн тань ирээдүй улам өнгөлөг гэрэл гэгээтэй болно гэдэгт би итгэж байна.

Түлхүүр үг: Тусгай хөтөлбөр, бэрхшээлийг даван туулах, нийгмийн хандлага.

Ашигласан материал:

1. *Тэгш хамруулах боловсрол. Дунд ангийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлсэн сургалтын модуль, Монгол улс, Улаанбаатар хот.*
2. *Тэгш хамруулах боловсрол. Боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ дэмжих малчин эцэг эх/асран хамгаалагчдын чадавхыг дээшлүүлэх сургалтын модуль, Монгол улс, Улаанбаатар хот.*
3. *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, эцэг эхчүүдийн холбоо пэйж хуудас*
4. *Бүх нийт боловсролын төлөө иргэний нийгсийн үндэсний эвсэл. (2020). Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд чанарын судалгааны тайлан. Монгол Улс, Улаанбаатар хот.*

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛД ХАМРАГДАЖ БУЙ НЬ БАЙДАЛ

Б. Баяржаргал, Б. Ижилцэцэг, Ж. Энхбаяр, Ө. Даваасүрэн1
Орхон аймаг 7-р сургууль ТХБ-ын багш:

Үндэслэл:

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох стандарт журам (1993) Улс орнууд Хөгжлийнх бэрхшээлийн холбоо, залуучууд, насанд хүрэгчид адил тэгш анхан шатны болон дунд боловсролыг олгох бөгөөд үүнийг тэгш хамруулах боловсрол. Тэгш хамран



сургах боловсрол нь бүх суралцагчдад чанартай боловсрол эзэмшүүлэхэд нэн чухал ач холбогдолтой бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг хамруулан бүх суралцагчийн хувьд боловсролын бүх түвшинд (сургуулийн өмнөх, бага, дунд, дээд болон мэргэжлийн боловсрол, насан туршийн суралцахуй, хичээлээс гадуурх болон нийгмийн үйл ажиллагаа) ялгаварлалаас ангид, бусадтай адил тэгш байдлын үндсэн дээр боловсрол олгох ёстой


Судалгааны зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах, хөгжлийн ялгаатай байдлыг ойлгон боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг засан сайжруулахад оршино.

Судалгааны арга зүй:

FGD- Focus Group Discussions: Фокус бүлгийн ярилцлагын арга нь хэрэглэгчдийн хандлага, зан төлөв, үзэл бодол тухайн зүйлийн талаарх учир шалтгаантай холбоотой асуудлуудыг илүү гүнзгийрүүлэн ойлгохын тулд ашигладаг судалгааны нэгэн арга юм. Өөрөөр хэлбэл тоон үр дүнгээс илүү чанарын холбогдолтой үр дүнгүүдийг олж авахад ашигладаг. Фокус бүлгийн ярилцлагад тухайн хэлэлцэх асуудлын талаар нарийн мэдлэгтэй, зорилтот хүмүүсийг оролцуулдаг бөгөөд тэдгээр хүмүүсийг судалгаанд оролцуулаад өмнө нь тодорхой шүүлтүүр асуулгыг асууж зорилтот хүн мөн эсэхийг шалгадаг. Фокус бүлгийн ярилцлагыг зориулалтын, стандарт өрөө танхимд, мэргэжлийн оператор тусламжтай зохион байгуулснаар судалгаанд оролцогчдын үзэл бодлыг чөлөөтэй, ямар нэгэн нөлөөлөхгүйгээр илэрхийлэх боломжтой судалгаа юм.


Ярилцлага (Ганцаарчилсан): Гэр бүлийн сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөний үед хэрэглэдэг арга техник

Үндсэн техник



- Анхдагч уулзалтын техник нь үйлчлүүлэгч болон түүний асуудлыг сонсоход тусалдаг, чимээгүй сонсох, идэвхитэй сонсох (давтан яриулах, тодруулах, зарим хэсгийн илүү авч үзэх, үйлчлүүлэгчийн ярьж байгаа зүйлд өөрийн санал бодлоо илэрхийлэх) харилцан сэтгэл хуваалцаж сонсох, асуулт тавих техник

Нөлөөллийн техник



- хоёрдогч уулзалтын техникийг амжилттай явуулах гол нөхцөл нь үйлчлүүлэгчтэй нягт холбоо тогтоох, үр дүнтэй судалгаа явуулах хэсэг буюу тайлбар тавиулах, эргэх холбоо тогтоох, мэдээлэл зөвлөмж өгөх, сэтгэл заслын өвөрмөц маягийн арга техник зэрэг орно.

Санал асуулга:

Хариулт хурдан авах онцлогтой. Дараагийн ажиллаа төлөвлөх, арга хэмжээний бүртгэл хөтлөх, товч санал асуулга явуулах, өөрт хэрэгтэй мэдээлэл эз олж авах, ямар асуудал үүсгэх,

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

үүсэн гарч байна гэх мэт олон зүйлийг харна. Таны судалгааны хариултуудыг Маягт дээр цэгцтэйгээр, автоматаар цуглуулах бөгөөд хариултын мэдээлэл, диаграммыг шууд харуулж өгөх давуу талтай.

Үр дүн:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд шинэлэг санаануудыг нэвтрүүлэх нь тэднийг суралцах үйл явцыг илүү сонирхолтой, хүртээмжтэй болгоход тусалдаг. Энэ нь тэдний хөгжлийн боломжийг нэмэгдүүлж, тэднийг нийгэмд идэвхтэй оролцуулахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Сургалт, орчны тохиргоо, технологийн дэмжлэг, гэр бүлийн оролцоо зэрэг олон талт арга хэмжээг хослуулан хэрэгжүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг сайжруулах боломжтой. Үүнд:

- Тусгай хөтөлбөр болон тохирох арга зүйг түгээн дэлгэрүүлэх
- Хөгжлийн бэрхшээлийн онош үнэн зөв гаргах ялангуяа хавсарсан бэрхшээл тодорхойлон гаргах
- Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад тохирсон ном сурах бичих 1-9 анги
- Ажиллах арга зүйн дэмжлэг тусалцааг сайжруулах
- Эцэг эхийн сэтгэл зүйн зөвлөгөө дэмжлэг өгөх нэн шаардлагатай

Дүгнэлт:

Манай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ялгаатай байдалд тохирсон хэрэглэгдэхүүн анги танхим бүрд тохирсон сургалтын орчныг бүрдүүлж ажиллаж байгаа ба ганцаарчилсан хөтөлбөр болон хөгжлийн ялгаатай хүүхдүүдтэй ажиллах арга зүйг хэрэгжүүлэхэд бэрхшээлүүд тулгарч байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь сургалтын үйл явц, сургалтын орчин, багш нарын мэргэжлийн хөгжилд тодорхой анхаарал хандуулах шаардлагатайг илтгэж байна. Хөгжлийн ялгаатай сурагчдад зориулсан боловсролын орчин, хөгжлийн түвшинд тохируулан сургалтын орчныг бүрдүүлэх, сурагчдын онош болон гарааны үнэлгээ зөв тодорхойлох. Сурагчдад тохирсон сургалтын сурах бичиг болон багш нарыг чадавхжуулах нэн шаардлагатай байна.

Түлхүүр үг: Тэгш боломж, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын үйлчилгээ, тохирсон ном сурах бичиг, тусгай хөтөлбөр.

Ашигласан материал:

1. Whang, Jurng Hyun (Ph.D.). (2018 он). Нийслэлийн боловсролын газар, тусгай боловсролын дэмжих төв мэргэжлийн үр чадвар дээшлүүлэх зуны сургалтын материал. Монгол Улс, Улаанбаатар хот: Д. Одгэрэл.
2. О. Мягмар (2012). Сэтгэл зүйн зөвлөгөө, гэр бүл хүүхдэд чиглэсэн онол-арга зүйн асуудлууд. Монгол Улс: Улаанбаатар хот.
3. Г. Батцэнгэл. (2018 он). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургах сэтгэл зүйн үндэс. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Г.Батцэнгэл, Г.Гэрэлтуяа. (2009 он). Хөгжлийн бэрхшээлийг танин мэдэхүй. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Одгэрэл, Д. (2018 он). Тусгай боловсрол. Монгол Улс, Улаанбаатар хот.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД АУТИЗМТАЙ ХҮҮХДИЙГ СУРАЛЦУУЛАХ МЕНЕЖМЕНТИЙН БАЙДЛЫГ ТОДРУУЛАХ НЬ

Б.Буянжаргал
МУБИС, Багш

Үндэслэл:

Хүн төрөлхтний хөгжилтэй зэрэгцэн сэтгэцийн эрүүл мэндийн өвчлөл, эмгэг нэмэгдэж буй бөгөөд үүний дотроо аутизмын өвчлөл хурдацтай өсөж байна. Тодруулбал “Аутизм, Хөгжлийн бэрхшээлийн мониторингийн сүлжээ” хэмээх байгууллагаас АНУ-д хийсэн судалгаагаар 2000 онд 150 хүүхэд тутамд 1 хүүхэд аутизмын хүрээний эмгэгээр оношлогдож байсан бол 2020 онд 36 хүүхэд тутамд 1 болж нэмэгджээ.

Судалгааны зорилго:

Аутизмтай сурагчдыг ерөнхий боловсролын сургуулийн орчинд суралцахад таатай орчныг бүрдүүлэх менежментийг судлахад оршино.

Судалгааны арга зүй:

Ажиглалт, асуулга, задлан шинжлэх, аргуудыг ашигласнаас гадна, google Forms, EXCEL программын тооцоо судалгааны нэгтгэл дээр үндэслэнэ. Улаанбаатар хотын дүүргийн ЕБС-ийн багш, хөдөө орон нутгийн ЕБС-ийн багш, удирдлага, эцэг эх, асран хамгаалагчдыг судалгаанд хамруулав.

Үр дүн:


Аутизмын талаарх ойлголт

Аутизм (autos-өөрөө гэсэн утгатай грек үгнээс гаралтай) нэр томъёог Е.Блейлер, өвөрмөц маягийн сэтгэхүйн төрлийг тэмдэглэж хэрэглэсэн. Анх бага насны хүүхдэд илрэх аутизмын хам шинжийг 1943 онд Америкийн эмч Л.Каннер судалж “Онцгой ганцаардлын” хэмээснийг түүний нэрээр Каннер синдром, гэж нэрлэсэн бол...1944 онд Австрийн нярайн их эмч Н.Аспергер, арай өөр шинж тэмдэг бүхий хүүхдийн талаар тэмдэглээд түүнийг “Аустистик сэтгэцийн эмгэг” гэжээ. Тэгвэл 1970-аад онд Английн сэтгэл мэдрэлийн эмч М.Рүттер хэл яриа-танин мэдэхүйн бэрхшээлийг аутизмын анхдагч шинж тэмдэг хэмээн нэрлэжээ .

Ерөнхийдөө хүүхдэд дараах шинж тэмдэг илэрдэг.

- Хэл ярианы хөгжлийн хоцрогдол
- Бусадтай харилцах бэрхшээл
- Сэрэл мэдрэмжийн өөрчлөлт
- Хүсэл сонирхол, үйл ажиллагааны хүрээ нь хязгаарлагдмал
- Оюуны ухааны үйл ажиллагаа хязгаарлагдмал тогтворгүй хөгжил зэргээр аутизмын хүрээний эмгэг илэрдэг байна.

Зураг. 1. Аутизмын талаарх олон улсын статистик



Монгол Улс дахь нөхцөл байдал:

Энэ үзүүлэлт Монголд 2017 онд 55 хүүхэд тутмын нэг оношлогдсон бол 2021 оны судалгаагаар 33 хүүхэд тутмын нэг нь аутизмтай гэж гарсан бөгөөд 2050 он гэхэд хоёр хүүхэд тутмын нэг нь аутизмын эмгэгтэй болно гэсэн урьдчилсан судалгаа гарчээ. Манай Улсын одоогийн ЕБС-ийн анги бүрдэлтийн тоо хэмжээгээр тооцоолж үзвэл хөдөө орон нутагт нэг бүлэг тус бүрд 1 сурагч, Улаанбаатар хотын дийлэнх сургуулийн бүлэг тус бүрд 2 сурагч болох бөгөөд цаашдаа энэ тоо улам нэмэгдэх нь урьдчилсан судалгаанаас ажиглагдаж байна. Иймд аутизмтай хүүхдийг “Тусгай сургууль”, ердийн сургууль хэмээн ангилан хамруулах боломжгүй болох нь харагдаж байна.

Дүгнэлт:

Дээрх судалгаанаас үзэхэд бүлэг тус бүрд 1-3 аутизмтай сурагчид суралцаж буй бөгөөд нэмэгдэх хандлагатай төлөв байдал нь сургуулийн менежментэд тэдгээр хүүхдийн эрхийг хангахад шаардагдах орчин нөхцөлийг бүрдүүлэх, багш нарыг аутизмтай сурагч болон түүний эцэг эх асран хамгаалагчтай харилцах, хамтран ажиллах нэмэлт сургалт, арга зүйд суралцуулах, санхүү, эд материалын дэмжлэг үзүүлэх, багшийн ачааллын бууруулах зэрэг арга замыг тодорхойлох зэрэг тулгамдсан асуудлууд үүсэж байна. Мөн сургуулийн менежментийг удирдан чиглүүлэгчид аутизмын талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй байгаа нь уг судалгаанаас илэрч байна. Иймд тэдгээр удирдлагуудыг сургалтад хамрагдах шаардлагатай байгаа нь энэ судалгаанаас харагдаж байна. Хамгийн чухал нь сургууль, багш, эцэг эх асран хамгаалагчдад зориулсан аутизмын талаар сургалтыг нэн яаралтай зохион байгуулах шаардлагатай байна. Эцэг эх асран хамгаалагчдад мэдээлэл өгөх зэрэг менежментийн асуудал нь өнөөгийн боловсролын байгууллагад нийтлэг тулгамдаж байгаа харагдаж байна. Мөн багш нарт аутизмтай сурагчидтай ажиллах ойлголт, арга зүйг нэвтрүүлэх шаалдлагатай байна.

Түлхүүр үг: Сургуулийн суралцах таатай орчин, байгууллагын менежмент, багш, эцэг эх, асран хамгаалагч.

Ашигласан материал:

1. *1Г.Батцэнгэл. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын сэтгэл зүйн үндэс. УБ.,2020.м.226-227*
2. <https://www.cdc.gov/ncbddd/autism/data.html?fbclid=IwAR340NYkKGXhyz2rgzu9HEp33-LhBhs-BR3km-Rq8LtsVoDeH5ybKRV6ZuLM>
3. <https://news.mn/r/2637182/>
4. <https://legalinfo.mn/mn/detail/11711>
5. <https://news.mn/r/2637182/>

СУРАЛЦАХУЙН БЭРХШЭЭЛ–ТЭГШ ХҮРТЭЭМЖ

Х.Амарсанаа, Ш.Мөнгөнзул¹

¹Орхон аймаг долоодугаар цэцэрлэг

Үндэслэл:

Боловсролд тэгш хамруулах гэдэг нь суралцагсдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, хэл соёл, нийгмийн гарал, эдийн засгийн хүчин зүйлсийг үл хамааран хүн бүр тэгш боловсрол эзэмших эрхийг хангах явдал юм. Суралцахуйн бэрхшээл, зан үйлийг эмгэгийг тухайн хүүхдийн давуу тал болгон ашиглаж, хүүхдийн хөгжлийг дэмжих боломжтой.

Судалгааны зорилго:

Суралцахуйн бэрхшээл, зан үйлийн эмгэгийн талаарх ойлголтыг онолын түвшинд судалж, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нар, эцэг эхчүүдээс зан үйлийн эмгэгтэй хүүхдийн талаар судалгаа авч, суралцахуйн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйг боловсруулах, дүн шинжилгээ хийх, зөвлөмж гаргахад оршино.

Үр дүн:

Судлагдсан байдлын тойм

Дэлхий даяар 2024 оны байдлаар 970 сая орчим хүн сэтгэгц болон зан үйлийн эмгэгээр шаналж байгаа бөгөөд тэдний 82 хувийг бага, дунд орлоготой улс орнуудын хүн ам эзэлдэг гэсэн тоо баримт гарчээ. Оросын агуу их яруу найрагч Александр Сергеевич Пушкин сурлага сайнгүй боловч яруу найрагт их дуртай, авьяастайг нь багш нар нь хүлээн зөвшөөрдөг байжээ. А.С.Пушкинийг судлаачид суралцахуйн бэрхшээлтэй байсан гэж үздэг. Мөн АНУ-ын усанд сэлэгч Олимпын 28 медалийн эзэн, Майкл Фред Фелпс 6-р ангидаа ADHD өвчтэй гэж оношлогдсон. Тэрээр хичээл дээрээ анхаарал төвлөрдөггүй сууж чаддаггүй байсан ч хичээлээ тараад усан санд гурван цаг хүртэл сэлж чаддаг байв.

Зан үйл гэдэг нь аж амьдралтай уялдан хэвшиж тогтсон заншил, түүнтэй холбоотой элдэв үйл хөдлөл. Зан үйлийн эмгэг гэж нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахуун, эрх зүй, ёс заншил, харилцаа, сахилга бат, амьдралын эрүүл хэв маягийн хэм хэмжээг баримталдаггүй, нийгэм, хамт олны дунд дасан зохицох чадваргүй байдлыг хэлнэ хэмээн тодорхойлсон.

Хүүхдийн Зөрүүд, Өөртөө итгэлгүй, Хувиа хичээсэн, зодоонч, ховч болох, хумсаа идэх, удаа дараа бусдын зүйлийг зөвшөөрөлгүй авах ах, эгч, дүүтэйгээ хэт таарамжгүй байх гэх мэт үйлдлүүд нь сөрөг зан үйлүүд юм. Харин зан үйлийн эмгэг нь оюуны чадамжтай шууд холбоотой биш боловч тэдний асуудал бүхий зан үйл нь сурах үйл явцад нөлөөлдөг байна.

Зан үйлийн эмгэгтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нар юуг илүү анхаарч мэдэх хэрэгтэй вэ? Гэвэл юуны өмнө сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдэд тохирох үйлчилгээ үзүүлэхийн тулд боловсролд тасралтгүй хамруулах шаардлагатай юм.

- Ердийн цэцэрлэг, сургуульд эдгээр хүүхдэд зориулсан нэмэлт туслах хэрэгсэл ашиглах
- Зарим хүүхдийн хувьд зөвхөн түүнд тусгайлан зориулсан хөтөлбөр боловсруулах,
- Ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулан ажиллах,
- Сургууль цэцэрлэг дотроо тусгай анги бүлэг нээж тусгай боловсролын багш ажиллах
- Хүүхдийн зан үйл өөрийнх нь болон бусад суралцагчийн сурах үйл явцад сөрөг нөлөө үзүүлж буй тохиолдолд цэцэрлэг сургуулийн зүгээс эерэг **ЗАН ҮЙЛИЙН ИНТЕРВЕНЦИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ** ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний нэг хэсэг болгон боловсруулна. Тус төлөвлөгөө нь тухайн хүүхдийн одоогийн зан үйлд болон сурах үйл явцыг сайжруулахад төвлөрсөн байна.

СУРГАЛТЫН ЭЕРЭГ ОРЧИН-БАГШИЙН ХАРИЛЦАА ХАНДЛАГА

- Суралцагчид хичээл сурлага, зан үйлийн хувьд ахиц амжилтад хүрэх нь олон боломж бүрдүүлсэн, сургалтын эерэг орчноос ихээхэн хамаарна.
- Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхэд болон багшийн хоорондын харилцаа маш чухал үүрэгтэй.
- Хэрвээ багш суралцагчтай эерэг харилцаатай бол тухайн хүүхэд зан үйлийн үр дагаврыг хүлээн зөвшөөрөх, дүрэм журмыг дагаж мөрдөхдөө илүү байдаг. Багш болон суралцагчийн хоорондын харилцаа таарамжгүй бол тухайн хүүхэд санаатай зөрүүдлэх үүрэг даалгаврыг биелүүлэхгүй байх, хичээл сурлагадаа муу, зан үйлийн олон асуудал

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

гаргах зэрэг сөрөг нөлөөтэй.

Хүснэгт 1. Кейс №1. Суралцагч: А.И

Д/д	Нас	Хөгжлийн нас	Онош	Илрэх зан үйл	Илрэх цаг хугацаа шинж тэмдэг	Давтамж
1	6 нас 2 сар	2 нас	Аутизм F84	Ширээн дээр гарын хурууг сарвалзуулан чанга нүднэ./ хөгжим тоглох гэж байна уу? гэмээр/	Ширээн дээр суух үйл ажиллагаа эхлэх үед	Өдөрт 4-5 удаа
Тухайн зан үйлийг засаж буй байдал: Хэрэгцээ сонирхлыг ажиглан ямар тохиолдолд юу хүсэж буйг ажиглан зурган карт харуулан хэрэгцээг ханган тайвшруулж сургалт үйл ажиллагаанд оролцуулна. <ul style="list-style-type: none">• Хөгжмийн сургалт үйл ажиллагаагаар даралтад хөгжим дээр хурууг даруулан тоглуулах.• Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хуваарийн дагуу бусад сургалт үйл ажиллагаанд татан оруулна.• Хөдөлгөөн, эрүүл мэнд шатаар өгсөх уруудах, гүйх “Туулай” хөгжимт хөдөлгөөний аянд дэгдүүлэх бартаат замаар алхах харайх гүйх.• Усан эмчилгээ /шавших, шүрших, хийн шавшилт хийх/• Бариа засал: Бүтэн болон хэсгийн бариа /Шар тосон бариа, сүүн бариа/ гэх мэт.						

Суралцагч А.И -ийг 3 сарын турш өдөр тутам хөдөлгөөнөөр хөгжье, Бяцхан хөгжимчин, Усан засал сургалт, үйл ажиллагаанд хамруулан ганцаарчилсан хөтөлбөр боловсруулан ажилласнаар хүүхдийн илрэх шинж тэмдэг 1-2 удаа болж цөөрсөн 0,4%-ийн ахицтай байна.

Дүгнэлт:

Хүн бүр боловсролын гадна үлдэх ёсгүй юм. Бүхий л боловсролын тогтолцоо нь сурагч бүрийг амжилтад хүрэх тэгш боломжоор хангахыг зорьдог. Уг илтгэлийн хүрээнд суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийн сурах онцлог болон зан үйлийн эмгэгтэй хүүхэдтэй ажиллах талаар авч үзсэн бөгөөд дараах дүгнэлтийг хийлээ.

Ашигласан материал:

1. Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь: хэрэгцээ тодорхойлох судалгааны тайлан. Save the Children, & IRIM Монгол Улс, Улаанбаатар хот 2018
2. Суралцахуйн бэрхшээл ба суралцагчдын ялгаатай байдал Энхбат.Б; Болормаа, Д. Улаанбаатар хот. 2019
3. Өдрийн сонин “Суралцахуйн бэрхшээл чухам юунаас шалтгаалдагийг шинжлэх ухаан яг таг тогтоогоогүй байгаа” нийтлэл Баяраа, Д. (2016.11.24). Өдрийн сонин. Улаанбаатар хот. 2016
4. Тэгш хамран сургах боловсролын бодлого, соёл үйл ажиллагааг хэрэгжүүлэх сургалтын гарын авлага. Улаанбаатар.; 2023 он
5. Тэгш хамруулан сургах боловсрол, Боловсролын бүх түвшний мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж. Улаанбаатар 2024

БАГШ БОЛ ХАМГИЙН САЙН ХАМТРАГЧ ЮМ

О.Мядагмаа¹

¹Ховд аймаг, Жаргалант сум, Ерөнхий боловсролын 1-р сургуулийн багш
myadgaako@gmail.com

Үндэслэл:

Боловсролын байгуулга нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулах сурч боловсрох эрхийг хангах нь хуулийн хүрээнд хүлээсэн үүрэг юм. Энэхүү судалгааны ажлаар хөгжлийн бэрхшээлтэй багш, сурагчдад тулгамдаж байгаа асуудал түүнийг даван туулах арга зам, туршлагыг судалж түгээн дэлгэрүүлэх юм. Бид ирээдүйдээ өнөөдрөөс эхлэн итгэлтэй алхах боломжийг бүрдүүлж өгөхгүй бол маргаашийн нар мөхнө. Тийм учир хөгжлийн ямар ч бэрхшээлтэй суралцагч байсан эрх тэгш хандаж, ялгаварлахгүй хичээлээ ялгаатай байдлаар боловсруулж мэдлэгийг тэгш олгох нь их чухал юм.

Судалгааны зорилго:

Сургуулийн багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга туршлага, хүүхдэд тулгамдаж байгаа асуудлыг илрүүлэх зорилготой.

Судалгааны арга зүй:

Ерөнхий боловсролын сургуулийн багш, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдаас тулгамдаж буй асуудлыг нээлттэй, хаалттай, ярилцлагын аргуудаар судалж үр дүнг боловсруулав.

Үр дүн:

НҮБ-ын Хүүхдийн сангийн шинжээчид “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийнхээ хийж чадахгүйг нь бус, хөгжлийн боломж, чадварт нь суурилан сургах нь чухал” гэж зөвлөдөг. 6 ангиас дээш ангиудад хичээл ордог багш нараас *google forms*-оор авсан асуулгад нийт 58 багш хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан нийт багш нарын 71% хөгжлийн бэрхшээлтэй сурагчтай өөрийн арга барилаар ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад хичээл орохдоо өөрт хийж чадах даалгаврыг нь зурах, уншаад бичих, цахим хичээл, дадлага ажлын дэвтрийг тусад нь бэлтгэж өгөх зэрэг мөн зарим даалгаврыг гэртээ хийгээд үнэлгээгээ авч болдог учир хичээлдээ ирэхдээ их баяртай байдаг байна.

6-12 ангид суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй 6 сурагчаас нээлттэй асуулга, ярилцлагын аргаар тулгамдаж байгаа асуудал, цаашид ямар дэмжлэг хэрэгтэй байгааг судлахад хичээлдээ ирэхдээ бүгд баяртай ирдэг гэж хариулсан бөгөөд ангийн сурагчид маш их ойлгож тусладаг, хичээл заадаг багш нар их ойлгож хичээлээ тусад нь бэлтгэж өгдөг. Харин анги болон сургуульд зориулалтын шат байхгүй, ширээ сандал, ангийн хүрэлцээ зэргээс хамаарч асуудлууд тулгарч байна гэж хариулсан.

Дүгнэлт:

Яст мэлхий туулайг ч гүйцэж болно.

Хүүхэд болгон харилцан адилгүй учир мэдээллийг хүлээж авах, боловсруулах чадвар нь хурдан удаан байж болно. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчид боловсролын салбарт тэгш хамрагдаж сурч боловсрох нь монголын ирээдүйн төлөө хийж байгаа нэг алхам юм. Багш нарын ихэнх нь аутизм болон дауны синдромтой хүүхдийг ялгаж чаддаггүй учир ажиллах арга барилаа олоход их хүндрэлтэй байдаг учир мэргэжлийн зөвлөгөө мэдээллээр хангаж байх нь чухал юм. Өөрийн туршлагаас үзэхэд сонсгол муу сурагчид хичээлээ гүйцэт сонсож ойлгоогүйн улмаас их хоцорч, хичээлдээ сонирхолгүй болдог. Ийм сурагчийг хичээлтэйгээ холбоотой зураг зуруулж түүнийг нь бага багаар тайлбарлуулсны үр дүнд одоо хичээлдээ их сонирхолтой, хийж чадахгүй байгаагаа хичээлийн дараа асууж лавлах нь их болсон нь багш ямар сурагчтай яаж харилцах нь чухал болохыг мэдэх хэрэгтэй байна.

Түлхүүр үг: Сургууль, багш, суралцагч, туршлага, асуудал.

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

гарын авлага. 2019 УБ

2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах бодлогыг хэрэгжүүлэх нь” хөвсгөл аймгийн туршлагад суурилсан гарын авлага. 2020 УБ
3. Монгол улсын үндсэн хууль
4. Хүүхдийн эрхийн зөрчил гаргахад хэнд, хаана хандах вэ? Гарын авлага 2020 УБ

ЯЛГААТАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДИЙГ AR ТЕХНОЛОГИ БОЛОН ЗУРГАН КАРТААР ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Д.Ариунаа, Л.Цэнд-Аюуш¹

¹ХУД, 28-р цэцэрлэг

Ariunaa04081@gmail.com

Үндэслэл:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хэвийн хөгжилтэй хүүхдийн адил боловсролд тэгш эрхтэйгээр хамруулах, хүүхэд бүрийн онцлог хэрэгцээнд нь нийцүүлж, хөгжүүлэх “Тохирох хэрэглэгдэхүүн”-ээр “Ганцаарчилсан төлөвлөгөө” боловсруулж ямар ч бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах, хөгжүүлэх талаар судлан шинжлэх зайлшгүй шаардлагатай байгаа учраас энэ сэдвийг сонгосон.

Судалгааны зорилго:

Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг сурч, хөгжихөд Pecs арга / хүүхдийг харилцах чадварт сургах зураг солилцооны арга / AR технологиор дэмжлэг үзүүлж, гарсан өөрчлөлтийг түгээн дэлгэрүүлэх.

Судалгааны арга зүй:

Цэцэрлэгт хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй 11 хүүхдийг сургалт үйл ажиллагаагаар PECS буюу хүүхдийг харилцах чадварт сургах, зураг солилцох харилцааны арга, AR технологийн ном, пазл, зургаар тоглох явцад ажиглалт хийх харилцаа үүсгэх, картан дээрх зургийг таних, нэрлэхэд ажиглалт хийж, хүүхдийн хэл яриа, харилцаанд гарсан ахиц үр дүнг боловсруулав.

Үр дүн:

Хүүхдүүдийн өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол зурган картыг ашиглахад хүүхдүүд нь сонирхож эхлээд, өөрийн дуртай зүйлсийн зурагт картуудыг сонгож авч нэрлэдэг болсон. Багшийн зааврыг дагаж байгаа боловч ганцаараа бие даан хийх чадвар дутмаг, багшийн дэмжлэгтэйгээр зурган картыг ашиглан өгүүлбэрийг зохиох, үйл явдлыг зургаар илэрхийлэх чадвартай болсон. Хоёр үетэй үгийг хэлж эхэлсэн. Зургийн нэр болон утгыг мэддэг болсон. Хүүхдийг бие даан харилцаанд ороход бодит мэдрэмж төрүүлж, шинж чанарыг ялган таних, тухайн зургийн агуулгыг хүүхдэд мартагдашгүйгээр ойлгуулж, шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэг олгох шаардлага тулгарсан.

Дүгнэлт:

Хүүхдийг харилцах чадварт сургах, зураг солилцох харилцааны арга, AR технологийг хамт хэрэглэж жилийн хугацаанд хэрэгжүүлэхэд чиглэл тус бүр дээр дараах ахиц гарсан. Аливаа аргыг хослуулан хэрэглэхэд үр дүнтэй байсан. Гарсан өөрчлөлтийг дүгнэж үзэхэд, хүүхдэд тохирсон сонирхолтой аргазүй нь багшлахуйд дөхөм бол, тухайн хүүхдийн хэл яриа, харилцаанд өөрчлөлт гарч байгааг харагдаж байна.

Аутизмтай хүүхдийн сонирхол хэрэгцээг ажиглаж мэдэх, түүн дээрээ тулгуурлан сургалт үйл ажиллагааг өөрийнх нь сонирхсон тоглоом, хэрэглэгдэхүүнээр төлөвлөн зохион байлгуулах нь суралцахуйд ахиц гарч байна.

Ашигласан материал:

1. БШУЯ, JICA. (2024). Хүүхдийн цэцэрлэгт тэгш хамран сургах үйл ажиллагааг зохион байгуулах нь. УБ:
2. Багшийн хөтөч” Улаанбаатар, 2023, хуудас 46
3. Р. Нэнсэндэн. Хүүхдийн эмгэг сэтгэл судлалын зарим асуудал., УБ., 2015
4. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөмж, Улаанбаатар, 2019, хуудас 67-88
5. “Хөгжлийн ерөнхий эмгэгүүд” цахим хаяг: <https://erdemed.com/icd10/f84/>

ТАРХИНЫ СААЖИЛТ БУЛЧИНГИЙН ЧАНГАРАЛТТАЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

Н.Бүжинлхам¹, Д. Ичинноров²

¹Баянхонгор аймаг, 5-р цэцэрлэгийн арга зүйч, ²ахлах бүлгийн багш

Үндэслэл:

Төрөөс “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” /2016 он/, “Боловсролын ерөнхий хууль” /2023 он/, “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль”/2023 он/ “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах журам” /2021 он/, “Харааны бэрхшээлтэй хүүхдэд ахуйн баримжаа олгох сургалтын жишиг хөтөлбөр” /2021 он/ зэрэг эрх зүйн баримт бичиг сүүлийн жилүүдэд гаргасан. Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний амьдрах, сурч боловсрох, эрх тэгш байдлыг хангах нь хувь хүний хөгжил болон нийгмийн амьдрал цаашлаад улс орны эдийн засгийн хөгжилд эергээр нөлөөлөх тул хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хэрэгжүүлэн боловсролын үйлчилгээг гадуур орхиж болохгүй учраас энэ сэдвийг сонгон авч судаллаа.

Судалгааны зорилго:

Булчингийн чангаралттай хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагад нь тохирсон боловсролын тусгай үйлчилгээг үзүүлж хөгжлийг нь дэмжин ажиллах.

Судалгааны арга зүй:

А. Мэдээ баримт цуглуулсан арга:

- Ганцаарчилсан ажиллах ажлын төлөвлөгөө
- Ажиглалт, тэмдэглэлийн арга
- Асуулгын буюу анкетын арга

Б. Мэдээ баримт боловсруулсан арга:

- Хүүхдийн өдөр тутмын тэмдэглэл
- Эцэг эхийн ярилцлагын тэмдэглэл

Үр дүн:

Эхний үед багш хүүхдийг ажиглан өдөр бүр тэмдэглэл хөтөлсний үндсэн дээр хүүхдийн нийгэмшихүй болон ярих, зурах, халбага барьж сурах чадваруудыг хөгжүүлэх шаардлагатайг олж харсан. Багш хүүхэдтэй ямар сургалтын хэрэглэгдэхүүн ашиглан хүүхдийн хөгжлийг дэмжин ажиллах, арга зүйгээ сонгон сургалтын ганцаарчилсан хөтөлбөр боловсруулан алхамчлан ажилласан. Булчингийн чангаралтай хүүхдийн гарын жижиг булчинг суллан, хөгжүүлэх зорилгоор тоглоомыг томоос нь жижиг рүү, дасгал даалгаврыг хөнгөнөөс нь хүндрүүлэх аргыг хэрэглэн эцэг эх асран хамгаалагчтай хамтран хүүхдийн хөгжлийг дэмжин ажилласнаар хүүхэд бие даан халбага барьж хоолоо иддэг, харандаа барьж эрээчин сараачин зурдаг болсон нь хүүхдэд гарсан том ахиц байсан. Мөн багш, эцэг эх, хүүхдийн гуравласан хамтын харилцаа хүүхдийн хөгжилд хамгийн ихээр нөлөөлсөн. Учир нь багш нэмэлт дасгал даалгаврыг бэлтгэн гэрт нь өгч явуулан эцэг эхэд хүүхдэд дэмжлэг үзүүлэн хамтран хийлгэх зөвлөгөө өгдөг байсан нь энэ судалгааны үр дүнд нөлөөлж байлаа. Үүнээс үзэхэд булчингийн чангаралтай хүүхэдтэй ажиллах багш, эцэг эх хүүхдийн бэрхшээлд тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгон, хүүхэдтэй уйгагүй шантрахгүй олон цагаар ажилласны үр дүнд хүүхдэд ахиц гардаг болохыг энэ судалгааны үр дүн илэрхийлж байна.

Дүгнэлт:

- Багшийн өдөр тутмын ажиглалт, тэмдэглэл
- Хүүхдийн хөгжилд сургалтын хэрэглэгдэхүүн ашигласан нь гэсэн дэд сэдвийн хүрээнд судалгааны ажил хийлээ.

Булчингийн чангаралтай хүүхдийн гарын булчинг суллах, бие даан халбагаа барьж хооллож сургах, харандаа барьж эрээчин сараачин зурах, ярьж сурах чадваруудыг дэмжихэд чиглэсэн том хэмжээний зурагт үзүүлэн, том тоглоом наадгайгаар тоглуулах, дасгал даалгаврыг хөнгөнөөс нь хүндрүүлэх арга ашиглан хүүхдийн сонирхолд тулгуурлан сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгон хүүхэд, эцэг эхтэй хамтран ажиллахад, хүүхдийн хөгжилд хэрхэн

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

ахиц гарах, эцэг эх асран хамгаалагч нарт тулгамддаг асуудлыг шийдвэрлэх, тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд боловсролын үйлчилгээг хэрхэн хүргэж ажиллах, бусад багш нарт булчингийн чангаралтай хүүхэдтэй хэрхэн ажиллах арга зүйгээ хуваалцахыг зорилго болголоо. Тухайн багшийн хүүхэдтэй ажиллах ур чадвар, сэтгэл, менежмент хамгийн гол зүйл байлаа. Багшийн ажиглалт тэмдэглэл, хүүхэдтэй ажиллах арга зүй хүүхдийн хөгжилд хэрхэн үр дүнд хүрч буйг энэхүү судалгаанаас харуулж байна.

Түлхүүр үг: Ажиглалт, тэмдэглэл, хөгжил.

Ашигласан материал:

1. *Баасанжаргал Р. & Мөнхтуяа.Ц. (2019). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох багшлах арга зүйн гарын авлага. Монгол Улс, Улаанбаатар хот.*
2. *Гэрэлтуяа.Б., Амаржаргал.Г., & Пүрэвсайхан.С. (2022) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад чиглэсэн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. Монгол Улс, Улаанбаатар хот.*

8-Р АНГИЙН ЭМЭГТЭЙ ТЕХНОЛОГИЙН ХИЧЭЭЛИЙН ИНТЕГРАЦИД СУУРИЛСАН БИЕ ДААЛТ

Б.Оюунгэрэл, Д.Баярмаа¹

¹Нийслэлийн ерөнхий боловсролын 55-р дугаар сургууль
gegenee.ob@gmail.com

Үндэслэл:

Энэ хичээлийн жилээс БИЕ ДААЛТ-ын 7 хоногтой болсонтой холбоотойгоор яаж сурагчдыг өөрийн нөөц бололцоонд тулгуурлан, өөрийгөө хөгжүүлэх, бие даан бүтээлчээр сэтгэх, суралцах, хөгжихөд дэмжлэг үзүүлэх вэ гэсэн асуулт багш бидний өмнө нүүр тулаад байна. Дизайн, технологийн хичээл бол бусад хичээлээс ялгаатай нь сурагцагч бүр биет бүтээл хийдгээрээ онцлог давуу талтай. Бие даалтын ажил нь бүх хичээлийн агуулгыг хамарсан, бусад хичээлээр сурч мэдсэнээ ашиглан асуудлаа шийдэх боломжтойгоос гадна дизайн, технологийн хичээлийг зөвхөн танхимд бус танхимаас гадна чөлөөтэй орчинд явуулах боломжтой байдаг. **Ашиглаж чадсан боломж амжилтын эхлэл** – Бие даалтын 7 хоногийг боломж болгон, хөгжлийн бэрхшээлтэй сурагч бүрээс амжилт гаргахыг зорилоо. 2024-2025 оны хичээлийн жилд суралцагчийн эзэмших чадамжийг хөгжүүлэхэд бүх талын оролцоо, хамтын ажиллагааг хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулах зорилгыг дэвшүүлжээ. Энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд хичээл сургалтын үйл ажиллагааг танхимын бус нөхцөлд ч тасралтгүй үр дүнтэй явуулж, суралцагч өмнө үзсэн хичээлээ сэргээн санаж, бататгаж, шинэ мэдлэг бүтээх сургалтын арга нь интерацид суурилсан бие даалт юм.

Судалгааны зорилго:

Интеграцид суурилсан бие даалтын ажлаар хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хөгжүүлэх боломжийг судлах.

Судалгааны арга:

Асуудал дэвшүүлэх, Материал цуглуулах, Баримт бичиг судлах, Санал асуулгын арга, Харьцуулан жиших арга, Нэгтгэн дүгнэх арга, Бүлгээр ярилцах, Хүмүүсийн санал бодлыг тандах.

Үр дүн:


Багш нараас авсан судалгаа. Асуулгад Технологийн заах аргын нэгдлийн багш нар 19.7%, Нийгмийн ухааны болон Байгалын уханы заах аргын нэгдлийн багш нар 15.5%, Заслын заах аргын нэгдлийн багш нар 25.4%, Бага ангийн заах аргын нэгдлийн багш нар 23.9% хамрагдлаа. Судалгаанд хамрагдсан багш нар бүх судлагдахуунаас тэгш хувьтай хамрагдсан нь судалгааны зорилгод тохирч байна (График 1.1). Сурагчид аливаа хичээлийн бие даалтыг хийхдээ бусад судлагдахууны багш нараас зөвлөгөө тусламж хүсэх нь бага байдаг гэсэн үр дүн гарсан байна (График 1.2). Суралцагч нь бие даалт хийхдээ бусад хичээлийн багшаас зөвлөгөө, тусламж авах шаардлага гарвал ямар ч судлагдахууны багш туслахад бэлэн байдаг нь судалгааны таамаглалтай нийцэж байна (График 1.3). Судалгаанд хамрагдсан багш нар сурагчдад бие даалт өгдөг боловч, ихэнх нь буюу 80.3% нь интеграцид суурилсан бие даалтын даалгавар өгдөггүй байна.

Сурагчдаас авсан судалгаа. Судалгаанд 55-р сургуулийн 8-12 дугаар ангийн нийт 133 сурагч хамрагдлаа (График 2.1). Дунд, ахлах ангийн хичээлүүдээр сурагчдад бие даан бүтээл хийх даалгаврыг бүх судлагдахууны багш нар өгдөг ба Технологи, Түүх, Нийгэм ахуйн баримжаа зэрэг хичээлүүдэд ихэвчлэн бие даалт өгдөг байна (График 2.2) Сурагчдад бие даалт хийхэд нь бусад хичээлийн агуулгаас судлах хэрэгцээ шаардлага гардаг байна (График 2.3). Бие даалтын ажил хийх явцад 1-2 хичээл ихэнхдээ интеграцилагддаг нь судалгааны таамгаас бага байлаа. Бие даалт хийх хугацаа богино, сурагчид бусад хичээлийн ямар агуулгыг судлахаа тодорхойлж чадахгүй байна гэж үзлээ (График 2.4). Судлах шаардлагатай хичээлээ сурагчид бие даан судалдаг нь бие даалт өгсөн багш нь аль хичээлийн ямар агуулгыг судлах талаар чиглүүлж өгөөгүйгээс үүдэн сурагчид багш нараас зөвлөгөө авч хэвшээгүй байна гэж дүгнэгдлээ (График 2.5). Бие даалтын даалгаврыг хийснээр сурагчид бүтээлээрээ уралдаан тэмцээнд орох боломж сайжирдаг боловч тухайн судлагдахууны багшаас зөвлөгөө авч чадахгүй байгаа нь үр дүнг муу

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
болгож байна (График 2,6).



Практикт туршсан үр дүн: 2024- 2025 оны хичээлийн жилийн 9 дахь 7 хоногт бие даалтын 7 хоногтой болсноор технологийн хичээлийн “Жижиг эдлэл хийх” нэгж хичээлийн хүрээнд англи хэлний хичээлтэй интеграцчилсан бие даалтын ажлыг бэлтгэн 8а,б ангийн сурагчдыг гүйцэтгүүлэхээр хүүхэд бүрийн бэрхшээлийн түвшинд тохируулж, боловсруулжээ. Сурагч бүр бие даалтыг 100% гүйцэтгэж 7 сурагч тус бүр 1 бүтээл хийж дуусгалаа (зураг 1. Хичээлийн болон агуулгын интеграци)




(График 1.1)



(График 1.2)




(График 1.3)




(График 1.4)



(График 2.1)



(График 2.2)



(График 2.3)



(График 2.4)



(График 2.5)



(График 2.6)

Дүгнэлт:

Хандлагаа өөрчилцгөөе - Хамтдаа суралцацгаая. Судалгааны ажлыг хийж гүйцэтгээд дараах дүгнэлтийг хийж байна. Бие даалтын 7 хоног нь сурагчдад танхимын бус орчинд бие даан хөгжих боломжийг нэмэгдүүлснээр сурагч бие даан бүтээл хийснээрээ өөрийгөө шинээр нээж, хөгжүүлсэн. Бие даалт нь сурагчдад амжилтаа ахиулах, цаашлаад мэргэжлээ сонгоход нь түлхэц болж байна. Багш нар тухайн 7 хоногт ээлжит нэгж хичээлийн бататгалыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх давуу тал бий болсон. Интеграцчилсан бие даалт нь ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙГ СОНИРХОЛТОЙ ХЭЛБЭРЭЭР ТӨЛӨВЛӨХ – бие даалт хийхдээ бусад судлагдахууны хичээлийг сэргээн санах, бататгах, шинэ мэдлэг олж авах давуу талыг бий болгосон. Эцэг эх, асран халамжлагч нар нь хүүхдүүддээ тусалж, анхаарал халамж тавихад нь дэмжлэг үзүүлэх боломжийг өгч байна.

Дэвшүүлсэн санаа: Багш нар өөрийн хичээлдээ интеграцид суурилсан бие даалтыг хичээлийн жилийн тогтсон хугацаанд өгч хэвших нь сургалтын чанарт сайнаар нөлөөлнө. Бие даалт өгөхдөө сурагчдад бусад судлагдахууны хэн багшаас, ямар агуулгыг асууж судлахыг нь оновчтой чиглүүлж өгдөг байх. Сурагчдад бие даалтыг өгөхдөө цаг үеийн нөхцөл байдалд нь тохирсон,

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

тодорхой нэг уралдаан тэмцээний урьдчилсан бэлтгэл байдлаар өгвөл илүү үр дүн гарна.

Түлхүүр үг: Бүтээлч сэтгэлгээ, шинэ мэдлэг, бататгал, олон талт ажиллагаа.

Ашигласан материал:

1. Бүрэн дунд боловсролын сургалтын “ХӨТӨЛБӨР” сайжруулсан хоёр дахь хэвлэл УБ.2019 он
2. Интеграц хичээлийн арга зүй • БСШУСЯ, ШХА, &БМДИ, УБ., (2018)
3. Ред. Пүрэв О, Содномваанчиг Г. Сургалтын технологи, үзэл баримтлал, онол арга зүйн зарим асуудал. УБ. 2001.
4. Тогтвортой хөгжлийн боловсролыг ЕБС-ийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй” Улаанбаатар: ТХБ төсөл • БОМСТ, УБ., (2020)
5. Т.Отгонбаяр, Т.Ариунаа, Д.Баттогтох “Идэвхтэй сургалтын аргууд” УБ 2013

ИНТЕГРАЦИД СУУРИЛСАН БАГШЛАХУЙ, СУРАЛЦАХУЙ (ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ЗӨВ СОНГОЛТ БА ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ХҮҮХДИЙГ ТЭГШ ХӨГЖҮҮЛЭХ НЬ ЖИШЭЭН ДЭЭР)

Б.Дэлгэрцэцэг¹

¹Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, Ерөнхий боловсролын 1-р сургуулийн багш
degeebatochir@gmail.com

Үндэслэл:

Боловсролын эрх тэгш байдлыг хангах нь одоо цаг үед нэн тэргүүнд тавигдаж байгаа билээ. ТЭГШ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗАМААР СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ НЬ ТӨСӨЛ нь 2023-2024 хичээлийн жилд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1-р р сургууль дээр хэрэгжиж байгаа юм. Тус сургуульд нийт 13 тусгай хэрэгцээт боловсрол эзэмших шаардлагатай суралцагчид суралцдаг. Боловсрол, шинжлэх ухааны яамны сайдын А/155 дугаар тушаалын дагуу дээрх 13 суралцагчийг “Ганцаарчилсан хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнээс гадна ЕБС-д хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургалтын орчинтой танилцуулах, татан оруулах, сурах хүсэл тэмүүлэлтэй болгоход чиглэгдэнэ. Тус сургууль нь энэ төсөлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшлах нөөц бололцоогоор бүрэн хангагдсан ч сурагч бүрийн онцлогт тохируулан ашиглах боломтой хичээлийн хэрэглэгдэхүүнийг боловсруулах ба ТДХ-ын арга буюу тодорхой дүрслэл хийсвэрлэлийн аргаар хөгжлийн бэрхшээлтэй буюу онцлог сурагчийг хөгжүүлэхэд тодорхой тогтмол ашигладаг тоглоомын болон бодит дүрслэлийн аргын дүрс хэлбэрээр бүх хичээлд холбон тоглоомын аргад суурилан хэрэглүүлэх нь илүү үр дүнтэй юм гэж үзлээ.

Судалгааны зорилго:

Хичээлийг хүүхэд бүрийн онцлогт тохируулан хувирган хэрэглэх, хичээлийн бэлтгэл үед хэрэглэгдэхүүнийг оновчтой, дахин ашиглагдахуйц санааг олж цаг зав, эд материалаа хэмнэх арга замыг олох, турших, үр дүнг тоцоолох.

Судалгааны арга зүй:

Ерөнхий боловсролын сургуулийн 1-2 дугаар ангийн суралцагч дээр дүрсээр судлагдахууны ойлголтыг бүрэн өгч чадаж байна уу? гэдэгт нөхцөл байдлын судалгааг бүрэн хийж, түүнийгээ туршин хэрэгжүүлж үр дүн тооцоолон агуулгын шинжилгээ хийн үр дүнг боловсруулав.

Үр дүн:

Дүрсийг

- Математик- Хүрдээр үржих, хуваах, багцлах, боломж тооцоолох, нэмэх хасах үйлдэл, тэгш хэм, өгөгдөлтэй ажиллах, хэмжигдэхүүний ойлголтуудыг өгөх боломжтой гэж үзлээ.
- Дүрслэх урлаг- Дүрсээр бүтээх, зурах, зураас, өнгөний хүрд
- Монгол хэл- Тоглоомын зааврыг дагаж мөрдөх, дүрэм зохиох, тоглоомын заавар, миний дуртай тоглоом, хөлөгт тоглоомыг өөрчлөн наадацгаая, заавар уншаад ойлгоё, танилцуулга ярьж бичиж сурья, үг сүлгийн анаграм тайлах, боломжит үгийг үүсгэх
- Хүн ба орчин хичээлээр жилийн дөрвөн улирлал, улиралд болох байгалийн үзэгдлүүд, баяр ёслолуудыг ярилцаж ХҮН БА ОРЧИН хичээлийн шинэ мэдлэгийг олгох боломжтой байна.

Иймд энэхүү туршлагыг түгээж одоогийн байдлаар багш нарын төлөөллөөс Баянзүрх дүүргийн багш нар, Сэлэнгэ аймгийн бага боловсролын багш нарын уулзалт зөвлөгөөнд дээр туршлагыг дэлгэрүүлэн хуваалцаж, судалгаат хичээл, сайн арга зүйн зөвлөгөөнд амжилттай оролцож бие биедээ туршлагаа хуваалцсан ба тэгш хамруулах боовсролын хүрээнд туршлага арга зүйгээ түгээн дэлгэрүүлээд байна. Бусад багш нар маань тун удахгүй туршин зааж судалгааныхаа эхний хэсгийг илгээх байх гэж найдаж байна.

Хичээлийн хэрэглэгдэхүүнийг зөвхөн нэг чадварыг хөгжүүлэхээс илүүтэйгээр бусад чадваруудыг хөгжүүлэхийг зорьж бэлтгэвэл сурагчдын сургалтын чанарт өөрчлөлт гараад зогсохгүй, багшийн ажлын ачааллыг багасгах боломж нээлттэй гэж үзлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

Яг үүнтэй адил хоёр болон түүнээс дээш чадваруудыг эзэмшүүлэх зорилготой бэлтгэгдсэн хэрэглэгдэхүүн тусгай группд байршуулан файл үүсгэгдэн оруулж бусдын цагийг хэмнэх, миний туршилтыг батлах, судалгааны ажилд голлох үүрэг гүйцэтгэх боломжийг эрж хайн байршуулж эхлээд байна.

1 ба 2 дугаар ангийн сайт үүсгэн багийн ажлыг хөнгөвчлөхөд дэм болохоор ажиллаж байна. Энэ хүч сайтыг УБ хотын баялаг дүүргийн 1 дүгээр ангийн багш нартай хуваалцан ажиллаж байна.

Хүүхэд бүрийн хүслийн үүдийг нээх их багш нь та байг

Дүгнэлт:

Хичээлийн хэрэглэгдэхүүнийг бэлтгэх явцдаа БЛҮМИЙН ТАКСОНОМ-ын шатлалын дагуу хүүхэд нэг бүрийн чадварыг үе шаттайгаар сайжруулах зорилгоор бэлтгэх нь өндөр үр дүнтэй гэдгийг өөрийн анги болон туршилт судалгааны үед батлан тогтоолоо. Хичээлийн хэрэглэгдэхүүнийг нэг агуулга, нэг хичээлд л ашиглагдах зорилгоор биш бусад хичээлийн ямар агуулгыг барьж хийвэл болох вэ? гэдгийг судлан бүтээлчээр хийснээр цаг хугацаа, эд материал хэмнээд зогсохгүй багшид ирэх ажлын ачааллыг багасгах боломжтойг өөрийн биеэр мэдэрлээ. Тэгш боломжийг хангах зорилтот бүлгийн суралцагч дүрслэлийн аргаар судлагдахууны ойлголтыг маш сайн тодорхой биет дүрслэлээр нарын ойлгож авч чадаж байгаа юм. Одоогийн байдлаар 1р ангид F84 онштойгоор орж ирсэн суралцагчид уншиж бичиж, бодож өөрийн хэрэгцээт зүйлийг ярьж ойлгуулж байгаа нь хэрэглэгдэхүүний оновчтой сонголт байсан гэж үзлээ. Яг үүнтэй адил хоёр болон түүнээс дээш чадваруудыг эзэмшүүлэх зорилготой бэлтгэгдсэн хэрэглэгдэхүүн тусгай группд файл үүсгэгдэн орсон нь бусдын цагийг хэмнэх, миний туршилтыг батлах, судалгааны ажилд голлох үүрэг гүйцэтгэх боломж нээгдсэн гэж үзлээ.

Түлхүүр үг: Тэгш боломж, хэрэглэгдэхүүний зөв сонголт, дүрс, ДТХ, сурагчийн сурах боломж.

Ашигласан материал:

1. МУБИС-ийн эрдэмтэд “Багшлахуйн нууц” 2017/3 тусгай дугаар
2. А.Алтанжаргал “Эрдэм шинжилгээний ажил” 2019
3. Жадамба “Лавай сэтгүүл” МУБИС 2016 он
4. Смайл боз. “Анги удирдах урлаг”

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ДЭЭД БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ БОЛОМЖ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Я.Отгонбаяр¹, М.Бат-Эрдэнэ²

¹МУИС, ШУС, Социологи, нийгмийн ажлын тэнхим, дэд проф,

²Нийслэлийн 10-р цэцэрлэг, нийгмийн ажилтан

Otgonbayar_ya@num.edu.mn

Үндэслэл:

Боловсрол нь хүний суурь эрх болохоос гадна тогтвортой хөгжлийг хангах үндэс суурь учраас нийгмийн тэргүүлэх ач холбогдол бүхий чиглэл болдог. Өнөөдөр Монгол улсад 111228 хөгжлийн бэрхшээлтэй хүн байна. Энэ нь нийт хүн амын 3 орчим хувийг эзэлж байна (ҮСХ 2023). Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ (Алсын хараа 2050). Боловсролын багц хуулийн 14.1.3.бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэх... гэж тус тус зааж өгсөн. ХБ-тэй иргэдийн нийгмийн оролцоог хангах, хүртээмжтэй дэд бүтэц, чанартай эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг бүрэн утгаар нь хүртэх нөхцөлийг хангах, хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой сорилтуудтай тулгарч байгааг судалгаа шинжилгээний дүн харуулсаар байна. Тухайлбал “Тэгш хамран сургах бодлогын хураангуй” 2023 судалгааны тайланд ХБТ-эй иргэдийг их, дээд сургуульд суралцах боломж нөхцөлийг бүрдүүлэх, хэрхэн дэмжих талаар тодорхойгүй байгааг дурдсан байна. Өнөөдөр нийт их, дээд сургуульд суралцагчдын 0,3 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт тул энэ нь судлах хэрэгцээ шаардлагыг нөхцөлдүүлээ.

Судалгааны зорилго, зорилт:

Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд их, дээд сургуульд элсэх, суралцах явцад ямар бэрхшээл тулгарч, тэдний суралцахуйг дэмжсэн тохируулга хэрхэн хийгдэж байгааг судлан цаашид сайжруулах, сайн туршлагыг дэлгэрүүлэх санал зөвлөмж гаргахад судалгааны зорилго оршиж байгаа төдийгүй энэ хүрээнд их, дээд сургуулиуд ХБ-тэй иргэдийг суралцахуйг хэрхэн дэмжиж, тохируулга хийж байгаа эсэхийг судлан тодруулсан.

Судалгааны арга зүй, дизайн:



Тус судалгааны ажлын мэдээллийг тоон болон чанарын судалгааны аргаар цуглуулж, ХБ-тэй суралцагч хариуцсан алба нэгж, мэргэжилтнүүд, ХБ-тэй суралцагчдаас ярилцлага авч, ХБ-тэй иргэдийн сурах, боловсрол эзэмших эрхийн хэрэгжилт, дэмжлэг, тохируулгын аргачлалын талаар олон улсад хийгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний нийтлэл, өгүүлэл, үндэсний хэмжээний эрх зүйн орчин, бодлого, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, судалгааны мэдээллийг SPSS 24.0 программд нэгтгэн үр дүнг гаргалаа.

Үр дүн:

Боловсролын багц хуулийн шинэчлэлээр боловсролын бүх шатны сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын суралцах онцлогийг харгалзан сургалтын хөтөлбөртөө тохируулга хийхээр тусгаж багш бүр ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах,

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

тэднийг сургаж хөгжүүлэх арга зүйн ур чадвар эзэмшсэн байхыг онцгойлон авч үзсэн. Өнөөдөр нийт их, дээд сургуульд 145,345 суралцагч суралцаж байна. Түүнээс 488 буюу 0,3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид байна. Хүйсийн хувьд 220 буюу 45 хувь нь эрэгтэй, 268 буюу 55 хувь нь эмэгтэй суралцагчид байна (БЯ 2024).

Хүснэгт 1. Судалгааны үр дүнгийн мэдээллийн матриц (+ - ? тэмдэглэгээ хийсэн)

№	Асуулт	Судалгаанд оролцсон сургуулиуд				
		МУИС	ШУТИС	АШУУИС	МУБИС	ХААИС
1	Танай сургууль ХБ-тэй суралцагчдын суралцахуйг дэмжсэн тусгай тохируулга, журам бий юу?	+	-	?	-	-
2	Танай сургуульд багш, ажилтнуудад ХБ-тэй суралцагчийн суралцахуйд хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар чиглүүлэг, сургалт, арга зүйгээр хангадаг уу?	+	+	+	+	+
3	Танай сургуулийн элсэлтийн шалгалтын журамд ХБ-тэй суралцагчдыг дэмжсэн тусгай заалт байдаг уу?	-	-	+	-	?
4	Танай сургуульд ХБ-тэй суралцагчидтай ажилладаг, суралцахад нь дэмжлэг үзүүлдэг тусгай алба нэгж, ажилтан байдаг уу?	+	+	+	+	+
5	Танай сургуулийн сургалтын гарын авлагад ХБ-тэй суралцагчийн суралцахуйг дэмжсэн мэдээлэл байдаг уу?	+	-	-	-	?

Дээрх матрицаас харахад МУИС-аас бусад их сургуульд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын суралцахуйг дэмжсэн хичээл, сургалтын тохируулга байхгүй байна. Мөн элсэлтийн журамд ХБ-тэй иргэдийг дэмжсэн заалт журам байхгүй харин сургууль бүр тэтгэлэгт хамруулах журамдаа ХБ-тэй суралцагчдыг оруулсан байна. Их сургуулиудын гарын авлагад ХБ-тэй суралцагчийн суралцахуйг хэрхэн дэмжих талаар тусгадаггүй байна. Харин МУИС-аас ХБ-тэй суралцагчдад зориулсан “Хичээлийн тохируулга үйлчилгээ” гэсэн тусгай гарын авлагыг гаргасан түүний дагуу ХБ-тэй иргэдийн суралцахуйд дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа юм байна.

Дүгнэлт:

- Төрийн өмчийн 5 их сургуулийн хэмжээнд ХБ-тэй суралцагчдын суралцахуйг дэмжсэн, тэдний онцлогт тохирсон сургалтын тохируулга хийх байдал ямар байгааг судлан үзэхэд МУИС-аас бусад их, дээд сургуульд ийм тохируулга хийгээгүй байна.
- ХБ-тэй иргэд их, дээд сургуульд элсэн суралцахын тулд ЭЕШ өгөх, элсэн орсны дараа хичээл сонголт, шалгалт, даалгавар гэх мэт олон асуудлыг шийдэхэд дэмжлэг үзүүлсэн чиглүүлэг өгсөн гарын авлага, тохируулга хэрэглэгдэхүүнээр төдийлөн хангагдаагүй байгаа нь ХБ-тэй суралцагчдыг их сургуульд амжилттай суралцахад тодорхой хэмжээний хүндрэл болсоор байна.
- Ихэнх их сургуулиудын элсэлтийн журам, гарын авлагад ХБ-тэй суралцагчийг хөнгөлөлттэй нөхцөлөөр элсүүлэх журам, заалт тусгагдаагүй байна. Өнөөдрийн байдлаар ХБ-тэй суралцагчдад тэтгэлэг олгож байгаагаар тэдэнд үзүүлэх дэмжлэгийг хязгаарлах хандлага байна.
- Одоогоор МУИС ХБ-тэй суралцагч хариуцсан тусгай ажилтанг ажиллуулсан, хичээлийн тохируулга үйлчилгээ тусгай гарын авлага гаргасан, ХБ-тэй суралцагчийг дэмжих хөтөлбөр батлан хэрэгжүүлсэн зэрэг олон ажлуудыг цогцоор нь хийсэн учраас сайн туршлага болж байна.

Санал зөвлөмж:

1. Боловсролын багц хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотой түүний дагуу холбогдож журам, дүрэм бий болж ХБ-тэй иргэдэд тэгш хамран сурах боломжийг нэмэгдүүлэхэд боловсролын төрийн захиргааны байгууллага санаачилгатай ажиллах шаардлагатай байна.
2. Боловсролын төрийн захиргааны байгууллагаас ХБ-тэй иргэдийн их, дээд сургуульд элсэн ороход бодлогын дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн зохицуулалт хийх.
3. Их, дээд сургуулиуд суралцаж байгаа ХБ-тэй суралцагчдын суралцахуйг дэмжих, тэдний онцлогт тохирсон тохируулга, оновчтой аргачлалыг бий болгож хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллах.

Ашигласан материал:

1. *Amity L. Noltemeyer (2012). The History of Inequality in Education . Sacred Heart University .*
2. *A.Gutmann. (1999). Democratic Education .*
3. *Barnes C. (2011) Understanding disability and the importance of design for all. JACCES. 1(1):50–88*
4. *V.Tinto (1975, 1993) Exploring the Character of Student Persistence in Higher Education: The Impact of Perception, Motivation, and Engagement : Handbook 2022*
5. *Vaccaro, Kimball, Newman, Moore, and Troiano (2018) Constructing a Sense of Purpose and a Professional Teaching Identity: Experiences of Teacher Candidates with Disabilities The Educational Forum Volume 84, 2020 - Issue 3*

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАГЧДЫГ ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ, ТУРШИЛТ, ҮР ДҮН

¹Э.Мөнхзул

¹Орхон аймаг, 4-р сургууль, Бага ангийн багш
zula.zulka8989@gmail.com

Үндэслэл:

Хандлага, мөс чанар нь хүний дотоод ертөнцөд оршиж байдаг бөгөөд харин тэдгээрт үндэслэсэн зан үйл ил харагддагийг чадамжийн мөсөн уул Мак Клеландын загвар дээр суурилсан дараах зургаас харж болно (*Н.Норжинхорлоо, 2021*) гэсэн онолын санаанд тулгуурласан. Хандлагыг эерэг, сөрөг гэж авч үзэж болно. Сайхан харилцаа эерэг хандлагаас эхэлнэ. Саар харилцаа хандлагаасаа харагддаг.

Судалгааны зорилго:

2019-2024 оны хичээлийн жилийн хугацаанд даан авсан ангийн хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын эцэг эхийн хандлагыг судлан, зөв хандлагыг бий болгох замаар сургалтын явц дахь бэрхшээл, зөрчлийг арилгаж, сурлагын чанарт ахиц гаргаж болно гэдгийг судалгааны ажлаараа дамжуулан илэрхийлэхийг зорилоо.

Судалгааны арга:

Задлан шинжилж, нэгтгэн дүгнэх замаар тандалт, баримтын судалгаа хийж, сургалтын явц дахь бэрхшээлийг арилгах шийдлийг олох боломжийг судлан, тоон ба чанарын үнэлгээ хийлээ.

Үр дүн:

Баримт бичгийн судалгаа

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургахад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний талаар гарсан хууль тогтоомж, тодорхойлолтыг харьцуулж дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1. Харьцуулсан зураглал


Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль	Бага дунд боловсролын тухай хууль	Хүүхэд хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайдын тушаал	Багшийн ажлын байрны тодорхойлолт
14.4. Эцэг эх асран хамгаалагч харгалзан дэмжигч нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмшүүлэх сургалтад хамруулах үүрэгтэй бөгөөд энэ	13.3 Ерөнхий боловсролын бусад сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бага, дунд, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй	3.2.1.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суурь боловсролд тэгш хамруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх 3.2.1.7 Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх,	Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай суралцагчдын хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн арга зүй, дэмжлэг үзүүлэх зорилгоор ашиглах	Зорилт-1 Тусгай хэрэгцээт хүүхдийн онцлогийг харгалзсан орчин бүрдүүлэхэд нөлөөлөх Зорилт-4 Нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай сурагчдыг судлах оношлох, хүүхдийг эрсдэлээс
үүргээ биелүүлэхэд нь боловсролын байгууллагын болон нийгмийн ажилтан холбогдох мэдээллээр хангах үүрэгтэй		хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд тохирсон сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэн боловсруулах	“Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө”-ний үлгэрчилсэн загвар	хамгаалах, урьдчилан сэргийлэх, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх

Дээрх хууль тогтоомжуудын заалтуудыг нэгтгээд үзэхэд ХБХ-ийг судлан оношилж тэдэнд тэгш боловсрол эзэмшүүлж, сургалтад хамруулах нь сургууль, эцэг, эх, асран хамгаалагч, нийгмийн ажилтан, АУБ нарын үүрэг мөн бөгөөд тэдгээр хүүхдүүдийг ердийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд суралцахад нь тусгайлсан хөтөлбөр төлөвлөгөөтэй ажиллах шаардлага үүсэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилласан туршилт, судалгаа

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

Схем 1. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хичээл сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулах



Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын мэдээлэл

Сурагчдын нэрс	Онош	Анх	Хичээлийн жил	Хичээл сургалтанд	Сурагчийн хувьд
Сурагч О. А 2-р сургууль 1-р анги	Оюун ухаан сэтгэц	Танихгүй хүний царай хардаггүй 2 жил сургуулиас завсардсан	2019-2020	Багшаас айхаа больсон 1-10 дотор цифрээ таних, зураг зурах, өнгө ялгадаг,	Өөрийгөө бүрэн илэрхийлж бусадтай харилцах чадвартай.
Сурагч Н. О 2-р сургууль 1-р анги	Биеийн хөгжил	Хөлийн тавхай цооролттой байнгын асаргаанд, ичдэг бүрэг	2020-2021	Хичээлийн хоцрогдол багасаж ямар ч шалгалтанд 65-75% гүйцэтгэлтэй болсон.	Найз нөхөд ангийнхан ойлгодог тул ичих, айх эмээх байхгүй сургуульд явах дуртай болсон.
Сурагч Э. Э 4-р сургууль 4-5-р анги	Аутизм	Бусадтай харилцахдаа сандардаг, ээрэх, дотогшоо, ганц ч найзгүй	2021-2022	Хичээлийн хоцрогдолгүй ямар ч шалгалт 90% дээш хувь үнэлэгдэх, анги хамт олны үйл ажиллагаанд биеэ дайчлан оролцдог болсон.	Өөрөө хичээлдээ ирдэг, бусадтай харилцахдаа сандрал ил биш, өөрийгөө хянаж сурсан. Аутизм эдгэрэх шатанд орсон ахицтай.
Сурагч Н. А 4-р сургууль 1-р анги	Сонсгол, хэл яриа	Үгийн баялаг байхгүй, 30%сонсголтой тул шулганах авиа гаргах, орилдог	2022-2023	1-10 дотор нэмэх, хасах, зургаар өгүүлбэртэй бодлого боддог, үгийн сан нэмэгдэж сайхан амраарай, баяртай, багш, эмээ сүү уу гэх мэт богино үгээр цээж бичиг хийдэг болсон.	Хичээлдээ маш их дуртай би чадна гэсэн хүсэл тэмүүлэлтэй болсон
Сурагч Г. М 4-р сургууль 1-р анги	Зүрхний	Дотогшоо тайван огт юм ярихгүй сэтгэлийн хөөрөлгүй	2022-2023	Ангийн найзуудтайгаа ярилцаж, бусдын өмнө тод чанга дуугаар уншдаг болсон. Биеийн тамирын хичээлд өөрт тохирсон дасгал хөдөлгөөн хийдэг болсон.	Баяр хөөртэй зүйлээ илэрхийлж, сэтгэлийн хөөрлөө харуулдаг, хичээлдээ ахиц амжилттай сурч байгаа тул сургуульд дуртай болсон.

Хүснэгт 3. Эцэг эхийн хувьд ганцаарчилсан төлөвлөгөөгөөр ажиллах ад:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

Сурагчдын нэрс	Эцэг эхийн харилцаа хандлага анх	Харилцаа хандлага өөрчлөлт	Хамгийн дутагдалтай тал
Сурагч О. А 2-р сургууль 1-р анги	Аливаа ажилд оролцдоггүй, угаасаа	Өөрийнх нь хүүхэд ангийнхаа түвшинд биш ч гэсэн үзгээ зөв бариад тоогоо нүдлээд, бусадтай харилцдаг болоод ирэхээр ангийн оролцоонд манлайлан оролцдог болсон.	Миний хүүхэд сурахгүй өөрийнхөө хэмжээнд явж байга гэсэн хандлагатай.
Сурагч Н. О 2-р сургууль 1-р анги	Аливаа ажилд оролцоо сул, хүүхдээ хэт өмөөрдөг	Сурах чухал анги сургууль дээрээ илүү ихийг сурч төлөвшил гэх мэт бүх зүйлд ахиц гарсан тул үргэлж өмөөрөх нь багассан аливааг ойлгох гэж хичээдэг болсон.	Ямар ч зүйл тохиолдсон өөрийн хүүхдээ хэт өрөвдөх бусдын буруу болгох
Сурагч Э. Э 4-р сургууль 4-5-р анги	Үргэлж хамт байнга өмнөөс нь хийдэг,	Хүүхэд нь биеэ даагаад ирэхээр үргэлж урдуур нь орж бүх зүйлд оролцохоо больсон. Ээж нь өөртөө ч цаг гаргаад аливаад манлайлан оролцдог, хүүхдэдээ итгэх, бахархах болсон.	Бүх зүйлийг өмнүүр бэлтгэх манай хүүхэд сандраад байдаг багшаа тэгсэн ингээд явууллаа гээд өмнүүр нь ордог. Хүүхдийн орон зай үлдээдэггүй.
Сурагч Н. А 4-р сургууль 1-р анги	Залуу гэр бүл оролцоо сул, цахим хэрэглээ их	Аливаа ажлыг үргэлж дэмжин өөрийн хүүхдээр бахархаж, өдөрт нэг үгийг зөв дуудан хэлүүлдэг болсон.	Сонсголгүй тул харилцаа байхгүй аав, ээжээс өөр зөв дуудлагатай үгүй, гадаад хүүхэд шиг шулганах, хэт өрөвдөж эрхлүүлэх, цахим хэрэглээ их
Сурагч Г. М 4-р сургууль 1-р анги	Ө м ө ө р ө х , х а м г а а л а х , байнга чөлөө авах, бизнесийн хайр	Үргэлж өмөөрдөг тал буурсан, аливааг нухацтай хандаж сурсан Хүүхэд хүүхэд гэдгийг ойлгосон.	Бусдаас өмөөрөх, үргэлж амттан, тоглоомоор амлалт өгөх, амрах, хүүхдийнхээ үгээр

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, асуудал, тандалт

Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын эцэг эх, асран хамгаалагчдын өөрийн хүүхдийн хөгжил төлөвшилд өгөх хандлага, ойрын ба хэтийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө гарган дэлгэрэнгүй судална. Орхон аймгийн Баян -Өндөр сумын ЕБ-ын 2 ба 4 дүгээр сургуулийн 3,5,1-р ангийн 4 сурагчийг хамруулсан судалгааг хийж байлаа. Үүнд: Хүүхдийнхээ сургалтын талд ханддаг нь 27%, мөртөө уралдаан тэмцээний оролцоо 73%, аливаа ажлын оролцоо 47% байгаагаас сургалтын үйл ажиллагааг хэрхэн дэмжиж буй, оролцоо хандлага сул нь сургалтад шууд нөлөөлдөг гэдгийг мэдэрсэн болно. Мөн өөрийн хүүхдийг хөгжлийн бэрхшээл гэдэг үгэнд автсан юу ч хийж чадахгүй өөрийнхөө хэмжээнд л сурахад болно доо илүү зүйл хүсэхгүй ээ гэх мэт маш ахархан бодолтой байсан. Гэтэл хүүхэд бүр өөрийн гэсэн давуу талтай түүнийг түшиглээд хэрхэн ахиц амжилт гарган ажиллах болох талаар мэдлэг хомс байсан.

Дүгнэлт:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх үргэлж өөрийн хүүхдээ хэт бөөцийлөх нэг үгээр байнга өрөвддөг, үргэлж урдуур нь орж муу зан сургадаг. Өөрийн хүүхэд үргэлж зөв гэж өөрийнхөө бодолд бат итгэлтэй байдаг. Харилцаа хандлага, оролцоо маш сул миний хүүхэд энэ зэрэгтэй сурч байгаа нь болно гэсэн бодолтой байдаг. Гэтэл тухайн хүүхэд өөрийн гэсэн үзэл бодолтой, өөрийн гэсэн чадварт суурилсан бусдын адил сурах бүрэн боломжтой байна. Хөгжлийн бэрхшээлтэй болон тэгш хамруулан сургах шаардлагатай хүүхдүүдийн эцэг эхийн сөрөг хандлагыг судалж, эерэг хандлага төлөвшүүлэхэд хамгийн гол нь хүүхдийнх нь ахицыг судлан, сайжруулах нь сургалтын амжилтад нөлөөлөх хүчин зүйлийн нэг тул үүнд анхаарлаа хандуулан, ганцаарчилсан байдлаар ажиллах нь үр дүнд хүрнэ. Тиймээс ийм хүнд байдлаас гарч, эерэг байдалд орж буй багшийг урамшуулах тал дээр бодох цаг хэдийнээ иржээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг өөрийнх нь байгаагаар хүлээн авч хөгжүүлж, эцэг эхийн хандлагыг эерэг тал руу чиглүүлснээр сургалтын чанар сайжирч, ХБ-тэй хүүхэд бүр энгийн сургуульд тэгш суралцах боломжтой гэдгийг сургууль бүр анхаарч ажиллавал зохино.

Түлхүүр үг: Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, харилцаа хандлага, нөлөөлөх хүчин зүйл.

Ашигласан материал:

- 1.Норжхорлоо,Н. (2021).*Вивеи.Вивеи.тн*
- 2."Хүүхдийн хөгжил төлөвшилд багшийн үүрэг роль". УБ., хуу 28 [6].Мягмар,О.(1998).
3. "Харилцааны сэтгэл зүйн зарим асуудал", УБ., хуу 5

ХӨГЖЛИЙН ОНЦЛОГТОЙ СУРАГЧДЫГ МЭДЛЭГ ЧАДВАРЫН АХИЦАД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ НЭМЭГДҮҮЛСЭН ТУРШЛАГА, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Х.Алтанцэцэг¹

¹8-р сургуль, Нийгмийн багш

Үндэслэл:

Хөгжлийн онцлогтой сурагчдын сургуульд хамруулан сургах боломжийг хангахын тулд дэлхий төдийгүй Монгол улсад тэгш хамруулах сургалтын тогтолцоог боловсролын талаар хууль тогтолцоо боловсруулагдсан байдаг. Гэвч тэгш хамруулах боловсролын дөрвөн үзүүлэлтийн нэг тэгш хамруулсан материаллаг орчинд тэр бүр анхаарал хандуулах асуудал нь тулгамдаж байна. Сургуулийн бага дундын багш нарын 89% хөгжлийн онцлогтой сурагчидтай ажиллах талаарх мэдлэг ойлголттой, ганцаарчилсан төлөвлөгөөг бага ангийн 4 багш болон дунд ахлах ангийн багшийн 75% ээлжит хичээлийн төлөвлөгөөнд тусгаж 12 сурагчидтай ажиллаж байна. 2023-2024 оны хичээлийн жилийн хугацаанд сургуулийн дэмжлэгийн баг хөгжлийн онцлогтой сурагчдад таатай орчин бүрдүүлж, багш ганцаарчилсан төлөвлөгөөний дагуу сурлагын ахиц, нийгэмших, зөв хандлагыг бий болгоход нөлөөлсөн эсэхийг хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, туршлага дээр тулгуурласан.

Судалгааны зорилго:

Хөгжлийн онцлогтой сурагчдтай харилцах хандлагад өөрчлөлт гаргахад таатай орчин бүрдүүлж, олон нийтийн дунд аюулгүй харилцах хандлага төлөвшилд суралцах нөлөөлсөн хүчин зүйлсийг судалж, хэрэгжүүлэх.

Судалгааны арга зүй:

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хүрээнд нөхцөл байдлын судалгаануудын тайлан, Задлан шинжилж, нэгтгэн дүгнэх замаар тандалт, баримтын судалгаа хийж, ганцаарчилсан сургалтын явцын үр дүн, сургуулийн орчинд тулгарах бэрхшээлийг арилгах шийдлийг олж, эерэг боломжийг судлан, бодит үйлд тоон ба чанарын үнэлгээ хийх аргуудыг туршин хэрэгжүүлсэн болно.

Үр дүн:

Хөгжлийн онцлогтой хүүхдийг сургуулийн орчинд дасан зохицох болон нийгэмшүүлэх, хөгжүүлэх, тэгш хамран суралцахад сургалтын хэрэглэгдэхүүн болон сургалтын танхимын хэрэгцээ шаардлага гарсан. “Хөгжлийн онцлогтой сурагчдын танхим байгуулж, ном гарын авлага, хэрэглэгдэхүүний дэмжлэг авсан. Шатаар гарахад тулгуур болох бариулыг хананд суурилуулсан, ариун цэврийн өрөөг тохижуулж, унахаас сэргийлэн халтирдаггүй хулдаас дэвсэж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлсэн нь хөгжүүлэх, нийгэмшүүлэхэд чухал ач холбогдолтой бодит үйл ажиллагаа болсон.

Дүгнэлт:

Сургалтын үйл ажиллагаа гэдэг хамтран хичээж, зүтгэсэн хэн бүхний хамтын бүтээлийн үр дүн юм. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй сурагчдын ахиц, амжилтыг хамтран үнэлж, эцэг эхийн хандлагыг өөрчилснөөрөө хүүхдийг үе тэнгийнхэн, найз нөхөдтэйг нь хамт дэвшин суралцаж, боловсролын тухай хуульд заасны дагуу ерөнхий боловсролыг эзэмшүүлэх эрхийг нь зөрчихгүй байх маш том ажил юм.

- Бүх шатны сургуульд олон нийтийн дэмжлэг, төрийн болон төрийн бус байгууллагын санаачилга, хандлага, санхүү зэргээр хүртээмжтэй орчныг бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд саадгүй суралцах боломжийг санаачлан хэрэгжүүлэх нь чухал.
- Бага ангийн багш, анги удирдсан багшийн ачааллыг хэд дахин нэмсэн шийдвэрүүд нь үндэслэлгүй. Жишээлбэл туслах багшийн дэмжлэг байхгүй байх, 40-50 хүүхдийн дунд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хоцрогдолгүй хөгжүүлэн сургах шийдвэрүүд нь бодит байдалд нийцэлгүй байна.
- Анги хамт олон тэдний эцэг эх асран хамгаалагчдыг хөгжлийн онцлогтой сурагчдын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, хэрхэн харилцах сургалтад хамруулбал нэгэндээ туслах, ойлгох дэмжих хүмүүжлийг олж авч байгааг эцэг эх, анги удирдсан багш нарын

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

судалгаагаар дүгнэсэн.

Түлхүүр үг: Тэгш хамран сургах хөтөлбөр, ганцаарчилсан төлөвлөгөө, орчин, өөрчлөлт.

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан
2. Хөгжлийн бэрхшээл ба олон нийт 2016
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах бодлогыг хэрэгжүүлэх нь нээлттэй нийгэм форум 2020
4. МОНГОЛ УЛСАД ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ НЬ Карин Шелциг, Кирсти Ньюман 2020
5. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах ойлголт, хандлага, нөхцөл боломж” судалгаа 2023

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ “ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХАД” БАГШИЙН ТУСЛАЛЦАА, ДЭМЖЛЭГ

Б.Гэсэрмаа¹

¹СЭЗИС, Боловсролын сургуулийн ахлах багш, докторант
gesermaa.b@ufenu.edu.mn

Үндэслэл:

Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчдийн боловсрол эзэмших, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээ авах эрхийг хамгаалах бодлого, хууль эрх зүйн орчин сайжирч, тодорхой үр дүнд хүрч байна. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийг 2016 оны 2 дугаар сард Улсын их хурлаар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор тус тус баталсан. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн 16.1. дүгээр зүйлд “Багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах агуулга, арга зүйг тусгана”, 16.2. дугаар зүйлд “Бүх шатны боловсрол олгох сургалтын байгууллагын багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн заах арга зүй, арга барилыг эзэмшсэн байна” гэж заасан. БСШУС-ын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журам” баталсан нь багш, оюутнуудын тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна. Монгол улсын Засгийн газар 2020 оны 12-р сарын 23-ны өдөр “Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай” 235- 2020 р тогтоолыг баталсан бөгөөд тус тогтоолын 1.3-т Хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүүхэдтэй ажиллах арга зүй эзэмшүүлэх хичээлийг багш мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад заавал судлуулах зохицуулалт хийх. 2022 оны 12 сарын 21 А/553 тушаалаар Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэлийн тавдугаар бүлэгт заасан хууль, тушаал, эрх зүйн баримт бичгийн заалтыг үндэслэн СЭЗИС-ийн Боловсролын сургууль нь багш мэргэжлээр сурч буй оюутнуудад “Тэгш хамруулах боловсрол” хичээлийг 3 кредит цагаар зааж байна.

Судалгааны зорилго:

Монголын боловсролын өөрчлөлт шинэчлэлийн болон тулгамдсан асуудлыг оновчтой мэдэрч, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг” ердийн сургуульд сургах болсонтой холбогдуулан тэдэнтэй ажиллах багшийн ур чадварыг нэмэгдүүлэхэд оршино. Багш бэлтгэх сургууль төгсөж байгаа оюутнууд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд”-тэй ажиллах онол, арга зүйг мэдлэг эзэмшин тэднийг нийгэмшүүлэх, өөрсдийн чадварт нь тохирсон ганцаарчилсан хөтөлбөрөөр сургалтыг зохион байгуулах чадвартай болно.


Судалгааны арга:

Анализ хийж, харьцуулан жиших, нэгтгэн дүгнэх, сургалтын үр дүнг ажиглалт, асуулгын аргаар судлах, чанарын судалгааны аргууд мөн тоон судалгааны зарим аргуудыг хэрэглэсэн болно.

Үр дүн:

Судалгаанд нийт танхим, онлайн хосолсон 73 оюутан-багш оролцлоо.

Зураг 1.



Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

Зураг 2.






График 1.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд туслалцаа дэмжлэг үзүүлэхэд танд ямар мэдлэг дутагдаж байна вэ?(2-4 хариулт сонгоно уу.)
73 responses



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар юу мэдэхийг хүсэж байна вэ? (2-4 хариулт сонгоно уу.)
73 responses



Дүгнэлт:

Багш бэлтгэдэг Их, дээд сургуулиудад “Тэгш хамруулах боловсролын” хичээлийг оруулах нь зайлшгүй шаардлагатай нь байна. Тэр дундаа “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд”-тэй ажиллах багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, суралцахуйн түгээмэл загвар, сургалтын ганцаарчилсан хөтөлбөр, дохионы хэл, брайл үсгийн анхан шатны ойлголт мэдлэгтэй байх нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Санал зөвлөмж:

- Сургалтын гарын авлага, зөвлөмжийг боловсруулах, энэ чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслүүдийн уялдаа холбоо, нэгдсэн зохицуулалт, мэдээллийн солилцоог сайжруулах.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурч, хүмүүжих орчин бүрдүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг урлаг, спортоор хичээллэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, уралдаан тэмцээнд оролцуулах

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэгш хамруулах боловсрол, хандлага.

Ашигласан материал:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хууль., (2016,2019), Улаанбаатар
2. Баттуяа,Ц. Гэрэлтуяа,Ц. (1998). Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийг ердийн сургуульд хамруулан сургах нь. Улаанбаатар.
3. Батцэнгэл,Г. ба бусад. (2006). Хөгжлийн бэрхшээл тэдгээрийн онцлог. Улаанбаатар.
4. Цэвээнлхазал,Я. Алтанхуяг,Ц. (2005). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд сургах арга зүй. Улаанбаатар.
5. Батцэнгэл,Г. (2007). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурган сэтгэл зүйн зарим үндэс. Улаанбаатар.

АУТИЗМТАЙ ХҮҮХДИЙН НИЙГЭМШИХҮЙН ҮЙЛИЙГ НЬ ДЭМЖИХ НЬ

Б.Өлзий-Аюуш¹

¹ ЧД, 221-р цэцэрлэгийн багш

ulziayush93@gmail.com

Үндэслэл:

Хүүхдийн хүрээлэн буй орчин, нийгэмшихүйн байдал хийгээд оюун ухааны хөгжилд томоохон үсрэлт гарч орчин тойрондоо болж буй үйл явдлыг тоглоомоороо тусган харуулж байдаг. Орчин үед эрдэмтэд хүний хөгжлийн эгзэгтэй үе нь сургуулийн өмнөх нас гэж тогтоожээ. Эгзэгтэй хөгжлийн энэ үед хүүхдийн онцлогийг танин мэдэх нь тэдний цаашдын хөгжил, төлөвшилд чухал нөлөө үзүүлэх тул аутизмын хүрээний эмгэг гэж юу вэ? Яагаад, ямар учраас, гэсэн маш олон асуулт бидний өмнө тулгамдаж олон олон бэрхшээл тулгарч байдаг. Багш бидний эргэн тойронд ч энэ асуудал байгаа учир өөрийн цэцэрлэгийн аутизмтай хүүхэдтэй ажиллаж ажиглалт хийж, ахиц гарна гэж үзэн энэхүү сэдвийг сонгон авсан.

Судалгааны зорилго:

- Аутизмтай хүүхдийн суралцах үйлийг нь дэмжиж, давуу талыг илрүүлэх, хөгжүүлэх
- Аутизмтай хүүхэдтэй ажиллах, зан төлөвийг тодорхойлох, ахицыг илрүүлэх
- Нийгэмшихэд дэмжлэг үзүүлэх
- Хүүхдийн хөгжилд хэрхэн нөлөөлж, ахиц гарч байгаад дүн шинжилгээ хийх





Хүүхдийн тал бүрийн хөгжлийн боломжид тулгуурлан сургалтын олон хувилбарыг ашиглан сонгон авснаар тэдний нийгэмшихүйн хөгжлийн түвшинд хүрч болох алхмыг бодитоор харуулж байгаагаараа шинэлэг болно. Одоогоор аутизмыг эдгээдэг эмчилгээний арга байхгүй ч тухайн хүүхдийн онцлогт тохирсон сургалт үйл ажиллагааг оновчтой, хүртээмжтэй явуулснаар гарах боломжийг судлахыг эрмэлзлээ.

Судалгааны арга зүй:



Асуулгын арга хэрэглэн аутизмтай хүүхдийн бодит байдал түүний ахиц өөрчлөлтийг ажиглаж, нэгтгэн дүгнэж дүн шинжилгээ хийлээ.

Үр дүн:

Хүснэгт 1. Ахиц өөрчлөлт

Чиглэл	Тэмдэглэл	Зураг
Нийгэмшихүй	Өөрөө гараа угаах оролдлого хийж гарын алчуураа таних тэмдэгтэй өлгүүрт өлгөдөг. Аяга халбага зөөж хоолны ширээгээ засдаг болов.	
Математик	Гараараа тоо тоолж даган дуурайж давтаж сайн хэлдэг . Аливаа зүйлийг өнгө болон өндөр намаар жагсаах, эгнүүлэн өрж чаддаг.	1-10 хүртэл тоолдог болов. 
Дүрслэх урлаг	Сараачих үйл хийж байгаа -1-2 минут л болдог. Анхаарлын хугацаа маш богино. Сууж дугуй дүрсийг багшийн дэмжлэгтэй хийв.	
Хэл яриа	Дохио зангаагаар ойлгуулдаг. Зураг харж ойлгохдоо сайн. Үг яриаг маш сайн даган хэлдэг болсон нь маш том ахиц болсон. Багш юу хэлнэ түүнийг дуурайж хэлнэ. Авиан дуудлага дутуу хөгжсөн. Баяртай, багшаа гэх мэт үгсийг хэлдэг болов .	

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

<p>Байгаль нийгэм</p>	<p>Найзтайгаа хамтран тоглохыг эрмэлздэг болов. Хөдөлгөөн эрүүл мэндийн сургалт үйл ажиллагаагаар бумаа гүйгээрээ гэхэд гүйж багшийн гарын алган дээр цохин тойрог болон гүйлээ.</p>	
<p>Хөгжим</p>	<p>Маш сайн дасгал дагаж хийнэ. Бүжиглэнэ. Аяыг сонсож бүжиглэж хараахан чаддаггүй</p>	<p>Хөгжмийн зэмсгийг цохиж үзсэн, сонирхож тоглосон.</p> 

Судалгаанд Чингэлтэй, Сонгино хайрхан дүүргийн нийт 44 багш хамрагдлаа. Судалгаанд хамрагдсан багш нарын 52 хувь нь аутизмтай хүүхэдтэй ажилладаг гэсэн байна. Судалгаанаас харахад аутизмтай хүүхэд их байлаа. 93% нь нийгэмшихүйн чадвар нь илүү хөгждөг гэж үзжээ. Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллахад ямар бэрхшээл тулгардаг вэ? гэсэн асуултад хүүхдийн сонирхол, хэрэгцээ тулгуурлан ажиллахад хүндрэлтэй гэж хариуллаа. Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилласнаар аль чадвар илүү нэмэгдэх боломжтой вэ? гэхэд нийгэмшихүйн чадвар гэж 94% хариулсан. Хүүхэд тань хийж буй үйлдлийг дуурайдаг уу? гэхэд 24% нь багш болон найз нөхдөө дуурайдаг. Хүүхэд хийж буй зүйлдээ таны анхаарлыг татахыг хичээдэг үү? гэхэд 26% нь тийм гэж хариулсан.

Аутизмтай хүүхэд нь: Нийгмийн харилцаа болон бусадтай харилцах чадвар сул, аливаа өөрчлөлтөд тавгүйтэж хямардаг, өвөрмөц зан үйлээр илэрдэг гэсэн онолын дүгнэлт судалгаагаар батлагдаж байна. Аль ч төрлийн аутизмтай хүнд дараах гурван бэрхшээл байдгийн нийгмийн харилцааны бэрхшээл бусад хүнтэй хэрхэн яаж биеэ зохистой авч явж харьцахаа төдийлөн сайн ойлгодоггүй. Хүмүүсийг сонирхдоггүй, хүмүүстэй харилцаа тогтоож, хадгалах чадваргүй, хариу үйлдэл үзүүлэх чадваргүй, хүмүүс хоорондын харилцааны утга учрыг сайн ойлгодоггүй, нэрээр дуудахад хариу үйлдэл үзүүлдэггүй, зан үйлийг буруу хэрэглэдэг зэрэг шинжүүд онол, судалгааны явцад батлагдаж байна.

Ийнхүү хүүхдийн төлөвшлийн эерэг хандлагыг олж илрүүлж хүүхдийн онцлогт тохирсон сургалт үйл ажиллагааг оновчтой уйгагүй явуулснаар хүүхдийн хөгжилд ахиц гарна гэсэн бидний таамаглал нотлогдож байна. Хөл хорионд байгаа хүүхдүүдэд ганцаардлаа даван туулах сэтгэл зүйн мэдлэг мэдээллийг түгээх, мэргэжлийн зөвлөгөө, тусламж үзүүлэх, сурч боловсрох ээлтэй, таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн компьютер, гар утас, интернэтээр хангах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, сурагчдын хүсэл, сонирхол хэрэгцээнд тулгуурлан нэмэлт дугуйлан секцэд хамруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, сургуулиудаар нь дамжуулан хүүхэд бүрд хэрэгцээтэй цар тахлаас урьдчилан сэргийлэх багцыг улсаас хангах, хүүхэд, залуучуудын чөлөөт цаг өнгөрөөх дасгал хөдөлгөөн хийх ногоон байгууламжийг шинээр бий болгох, малчдын хүүхдийн зайны сургалтын хүртээмжийн асуудлыг шийдвэрлэх, эцэг эхэд хичээл заах арга барил, хүүхэдтэйгээ харилцах зөвлөгөө, контентуудыг өргөнөөр нэвтрүүлэх шаардлагатай байна. Хамгийн гол нь энэ цар тахлын үед боловсролын эрх тэгш байдлыг хангах нь зөвхөн боловсролын салбарын асуудал биш салбар дундын, тэр дундаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэмжлэг, туслалцааг шаардсан асуудал юм гэдгийг ойлгох хэрэгтэй байна.

Дүгнэлт:

Судалгаанаас харахад ганцаарчлан ажиллах, тэдэнд дэмжлэг үзүүлэх нь хөгжих боломж байгааг олж харлаа. Аутизмтай хүүхдийг нийгэмшүүлэхэд мэдрэмжээ зөв илэрхийлж сурах, санаснаа хийж чадахгүй үедээ бухимдах үед нь тэврэх, өөрийн дуртай тоглоомыг нь өгөх, зурагт карт зэргийг ашигласан. Аутизмтай хүүхэдтэй ажилласнаар багшид хүүхэдтэй хэрхэн ганцаарчлан ажиллах, эрэл хайгуул хийх, хүүхдээ судлах, олон янзын хувилбараар сургалт, үйл ажиллагаа явуулах, зурагт карт боловсруулах зэрэг багшаас уйгагүй оролдлого, хичээл зүтгэл гарч байж хүүхдэд ахиц өөрчлөлт гарч байгаа нь судалгаагаар нотлогдлоо.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

Түлхүүр үг: Хүүхэд, аутизм, нийгэмшихүй.

Ашигласан материал:

1. Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих арга зүй. УБ., 2021
2. Аутизмын хүрээний бэрхшээлийн тухай ойлголт. УБ., 2018
3. [www.google.mn.blog.huuhed.3214](http://www.google.mn/blog.huuhed.3214)
4. Тэгш хамруулан сургах боловсрол. УБ., 2022
5. <https://www.facebook.com/autismacademymongolia>

**ХҮҮХДИЙН СОНИРХОЛД ТУЛГУУРЛАН СУРГАЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИНТЕГРАЦЛАН
ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУРШИЛТЫН ҮР ДҮН / АУТИЗМТАЙ ХҮҮХДИЙН ЖИШЭЭН ДЭЭР/**

Д.Амаржаргал¹, Т.Нарантуяа², Д.Дэлгэрбаян, Э.Дорждэрэм³

¹Бүлгийн багш, магистр, ²Эрхлэгч, ³Арга зүйч, магистр

Үндэслэл:

Хөгжлийн бэрхшээл нь хувь хүн төдийгүй гэр бүл, нийгмийн амьдралд нөлөөлж байдаг эмзэг асуудал билээ. Дэлхий нийтийн чиг хандлага аутизмтай хүүхдийг өөрчлөх биш, бид өөрсдөө эдгээр хүүхдүүдийн талаар мэдлэг, ойлголттой байж тэднийг нийгэмшүүлэх, хөгжүүлэх үйл явц өрнөж байгаа. Багш бид аутизмтай хүүхэдтэй ганцаарчлан ажиллах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа боловч хэр үр дүнтэй байгаа вэ?

Судалгааны зорилго:

Аутизмтай хүүхдийн сонирхолд тулгуурлан хөтөлбөрийн агуулгыг интеграциар зохион байгуулж туршсан сургалтын үр дүнг тодорхойлох.

Судалгааны арга зүй:

2022оны 09 сараас 2024 оны 11 сарын хугацаанд А....гэдэг аутизмтай хүүхэдтэй ажиллаж байх явцын ажиглалт тэмдэглэл, асуулга, фото зураг бичлэг мөн эцэг эхийн асуулга ярилцлага тэмдэглэл, мэдээлэлд үндэслэн агуулгын шинжилгээ хийн үр дүнг боловсруулав.

Үр дүн:

Судалгаанд оролцсон А... нэртэй хүүхэд маань эхний жилдээ ярьдаггүй өөрийгөө хязгаарласан, нийгэмшээгүй хүүхэд байсан бол эхний хичээлийн жилийн төгсгөлөөс нарны аймаг сонирхож байгаа нь ажиглагдсан тул хоёр дахь хичээлийн жил буюу ахлах бүлэгт нь сонирхолд нь тулгуулан сургалт үйл ажиллагааг интеграцилж явуулж эхлэхэд үр дүн сайн гарсан, дунд бүлгийн сургалтын агуулгыг 28% эзэмшсэн байсан бол ахлах бүлэгт 79%, бэлтгэл бүлгийн эхний улиралд 84% болж өссөн амжилт харагдаж байна.

Ажиглалтын судалгаа

2022-2024	Ажиглалтын судалгаа (цэцэрлэг дээр)	
2022	IX/11	Ярьж чадахгүй үе үе авиа гаргаж орилох үйл хийдэг. - Хивсний давтамжтай хээг хараад тоолох үйлдэл хийж байсан Нэ, Хо.. гэсэн авиа гаргаж байна.
	IX/06	Самбар дээр шохой авч төрөл бүрээр эрээчиж сараачиж зурж байсан (зурсан зургийн ажиглахад зараа хэлбэртэй байсан)
	X/20	Өглөөний дасгал орох үеэр хананы ард зогсож байснаа сүүлдээ аяыг нь сонсож байгаад хөдөлгөөн хийж байна.
2023	X/10	Сургалт үйл ажиллагааны үеэр баримлын шавар өгөхөөр сургалт дундуур босож гүйхгүй нам суудаг болсон. Сургалтын дараа зурган карт дээр нэрлүүлэх дасгал хийлгэхэд мэддэг зургуудаа сайн нэрлэдэг болсон.
	X/07	Баримлын шавраар нарны аймгийн есөн гариг илүү бүтээлч хийсэн. 10 сарын 07-нд (Зураг 1)
	X/24	Нарны аймгийн есөн гариг бөмбөг орлуулж бүтээсэн. (Зураг 2)
2024	II/28	Нарны аймаг пазл тоглоомоор тоглох үед хүүхдүүдэд нарны аймаг нэрлэж хэлж өгдөг.
	IX/12	Нарны аймаг зурахдаа илүү бүтээлч хандаж гаригуудыг том жижиг, харьцааг тааруулж зурсан, нэмэлтээр сансрын хөлөг пуужин зураад будаж чимэглэсэн (Зураг 3)

График 1.



Зураг 1



Зураг 2



Зураг 3

Дүгнэлт:

Багш бидний хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдалд, тулгуурлан суралцагчдад шинжлэх ухаанч мэдлэгийг тэгш хүртээмжтэй олгох үүрэгтэй ч оньсого мэт өөр өөр төрлийн аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүд элбэг болжээ. Энэ аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүд өөр өөр байгаа нь бидний ажилд тулгамдсан асуудал болж байсан.

А... нь 2022 оны 09 сараас гурван настайдаа цэцэрлэгт хамрагдаж эхэлсэн. Эхний байдал бол ярихгүй өөрийгөө бусдаас тусгаарлан хүүхэд байсан. Энэ хүүхдийн хэрэгцээ сонирхлыг 2023 оны 03 сараас нарны аймаг сургалт үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр олж мэдсэн. 2023-2024 оны хичээлийн жил нарны аймагаар дамжуулсан интеграци сургалт үйл ажиллагаа явуулснаар гурван насанд эзэмшсэн 28% -ийн агуулга ахлах бүлэгт 79% болж өссөн. Бэлтгэл бүлэгт бүлгийн багшийн сургалт үйл ажиллагаагаар олгох нийт 32-р чадварын 27-н агуулга эзэмшсэн байна. 27-н агуулгын 16-н нарны аймагтай холбоотой эзэмшсэн бол 11-н агуулга сургалт үйл ажиллагааны явцад эзэмшсэн байна. Үүнээс үзэхэд аутизмтай хүүхдийн сонирхол хэрэгцээг ажиглаж мэдэх, түүн дээрээ тулгуурлан сургалт үйл ажиллагааг төлөвлөн зохион байлгуулах нь зүйтэй гэж үзлээ.

Түлхүүр үг: Альфа үеийнхэн, аутизм, интеграци, сургалт, AR технологи.

Ашигласан материал:

1. АХБ-ны “Эдийн Засгийн Хүндрэлийн үед Боловсролын Чанар, Хүртээмжийг Сайжруулах” төсөл L3594-MON., Сурагч төвтэй, тэгш хамруулах, оролцоонд суурилсан бүтээлч арга зүй., УБ., 2021.,
2. “Багшийн хөтөч” Улаанбаатар, 2023, хуудас 46
3. Р. Нэнсэндэн. Хүүхдийн эмгэг сэтгэл судлалын зарим асуудал., УБ., 2015
4. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөмж, Улаанбаатар, 2019, хуудас 67-88
5. “Хөгжлийн ерөнхий эмгэгүүд” цахим хаяг: <https://erdemed.com/icd10/f84/>

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

П.Чимэддулам¹, Д.Одгэрэл²

¹Сэргээн Засалт, Сургалт, Үйлдвэрлэлийн төв, магистр,

²Монгол Улсын Боловсролын Их сургууль, Ph.D

Abstract:

There are big differences between countries with and without Special and Inclusive education legislation. In a country that has not legislation, we have to develop another strategy to realize related procedures. In this research we have compared procedures for special education services in European countries such as Poland, Belgium, Japan, and Mongolia, in particular focusing on inclusive education legislations.

Inclusive education in Mongolia was based upon medical viewpoints; nowadays we try to change it into social model of special needs and inclusive education. Literature study and actual observation in Mongolia's practice revealed that even today there is no commonly agreed definition for categories of children with special needs and an organizational aspect for assessment procedure according the law statement is very general. Modern inclusive education services required to set scientifically based special education system, suitable for Mongolian context. As a result of this study we propose a model for inclusive education, This study is recommending the necessity of further provision for Legislative framework of Special and Inclusive education with clarification of disability categories definitions, and administrative procedure.

Судалгааны арга зүй:

Тэгш хамруулах боловсролын тухай ойлголт, хуулийн хэрэгжилт хир байгаа талаар бүс нутгийн түвшинд харьцуулан эх сурвалжийн судалгааны аргыг уг судалгааны арга зүйгээ болгон ашигласан болно.

Үр дүн:

НҮБ-д элсэн орсон гишүүн орон бүр НҮБ-аас гаргасан эрх зүйн бичиг баримтуудыг даган мөрдөж хэрэгжүүлэх үүргийг гишүүн орнуудын Засгийн газар хүлээдэг төдийгүй хийж хэрэгжүүлсэн ажлаа НҮБ-д тайлагнадаг.

Тэгш хамруулах боловсролын тухай ойлголт

Хүүхдийн чадвар, хөгжлийн бэрхшээл, нийгмийн гарал, байдал, амьдралын нөхцөл зэрэгтэй холбоотой суралцахуй болон багшлахуйн чиг хандлага бол тэгш хамруулах боловсролтой салшгүй холбоотой ойлголт билээ. Тэгш хамруулах боловсролын зорилго бол дэмжлэгтэй, боломжит, тохируулгатай орчинд чанартай боловсролыг тэгш хүртээмжтэй эзэмших явдал юм. Тэгш хамруулах боловсролын зарчим нь суралцагчдын ялгаатай байдлыг үнэлээд, хувь хүний тусгай хэрэгцээг хангадаг, бусад хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдтэй хамт суралцуулахыг илүүд үзэж онцолдог.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцид хувь хүний онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн боломжит хэрэглэгдэхүүнээр хангагдах тухай заасан байдаг. Тэгш хамруулах боловсролд дараах зүйлүүдийг заавал онцлох шаардлагатай болдог байна.

Адил, тэгш хүртээмжтэй байдал

Суралцагч бүр ялгаатай ч амжилтад хүрэх боломж, арга барилтай байдаг.

Ялгаатай/олон талт байдал

Соёл, чадвар, хэтийн төлвийн ялгааг давуу тал гэж хүлээн зөвшөөрч, тэмдэглэх нь чухал.

Дасан зохицох чадвар

Бүх суралцагчийн онцгой хэрэгцээнд нийцсэн суралцах орчин, сургалтын хөтөлбөр, заах арга барилаа өөрчлөх хэрэгтэй.

Хамтын ажиллагаа

Багш, эцэг эх, асран хамгаалагчид, нийгмийн бүлгүүдийг боловсролын болон нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэхэд татан оролцуулж хамтран ажиллах нь тэгш хамруулах боловсролд чухал үүрэгтэй.

Хүндэтгэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

Хувь хүний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн үзэх нь суурь зарчим болох ёстой.

Тэгш хамруулах боловсролын зорилгыг энгийнээр тайлбарлавал суралцах болон оролцоход саад болж буй зүйлүүдийг багасгах, үгүй болгох, ялгаатай байдлыг онцлон тэмдэглэж суралцагч бүр боломжит дээд түвшинд хүрэх боломжтой зэрэг хандлага нь тэгш хамруулах боловсрол юм. Тэгш хамруулах боловсролын эрх зүйн орчин хүний эрхийн зарчимд үндэслэн гарсан байдлаар нь харьцуулж үзвэл:

Бүс нутгийн хувьд:

- ✓ Европ - Европын Холбооны Улсын тэгш хамруулах боловсролын хүчирхэг хуультай, хэрэгжилт сайтай.
- ✓ Ази, Номхон далайн улс орнууд – Япон, Энэтхэг, Австрали, төрөл бүрээр хэрэгжүүлдэг тэгш хармуулах боловсролын тухай хуультай.
- ✓ Африк, Латин Америк – Тэгш хамруулах боловсролын чиглэлээр олон арван эрх зүйн бичиг баримтууд байдаг ч томоохон саад бэрхшээл тулгамдсаар л байна.
- ✓

Дүгнэлт:

Тэгш хамруулах боловсролын талаар улс орон бүр түүнд хандах хандлага, ойлголтын түвшнээсээ хамаараад тэгш хамруулах боловсролын тухай хуультай улс орны тоо жигд биш, харилцан адилгүй байна. ЮНЕСКО-ийн тайланд бодлого, эрх зүйгээрээ дамжуулаад тэгш хамруулах боловсролын үзэл баримтлалыг дэлхийн улс орнуудын 90 гаруй хувь нь хэрэгжүүлж байдаг гэсэн байна. Ялангуяа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн турхай конвенци, Тогтвортой хөгжлийн зорилт 4-т тэгш хамруулах боловсролыг бүх нийтэд тэгш хүртээмжтэй хүргэхийг дэмжсэн байдаг. Үйл ажиллагааны хувьд хэрэгжилт янз бүр байна. Зарим улс оронд, тухайлбал Финлянд, Канад, Өмнөд Африкийн улс орнуудад хэрэгжилт сайтай, хүчирхэг хуультай байхад бусад улс орнуудад цаасан дээр нэр төдий, дэд бүтэц, нийгмийн хандлага нь тааруу, хэрэгжүүлэх олон олон асуудлууд байсаар байна.

Ашигласан материал:

1. Д.Одгэрэл (2013), Монгол дахь тусгай сургуулийн сурагчдын оюуны чадварыг үнэлсэн судалгаа, “Хөгжлийн бэрхшээл судлал салбар шинжлэх ухааныг хөгжүүлэх нь”, Эрдэм шинжилгээний онол, практикийн хурлын эмхэтгэл
2. МУБИС (2016), Сургуулийн өмнөх болон бага боловсролын асуудал, шийдэл, УБ, 40-44-р тал
3. Хигүчи Казүмэнэ (2016), Боловсролын үнэлгээ, Боловсролын үнэлгээний олон улсын бага хурлын эмхэтгэл, Тусгай хэрэгцээт боловсролын сургуульд элсэн суралцах эсэхийг шийдвэрлэх систем, МУБИС, 209-217-р тал
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016)
5. Тэгш хамруулах боловсролын эрх зүйн үндэс, УБ, 2023



**II. БҮЛЭГ
ДЭД
БҮТЭЦ**

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН ҮР ДҮН, АРГА ТУРШЛАГА

В.Лут-Очир, С.Галсандаш, Д.Сэрчмаа, Г.Байгалмаа, К.Ломбодорж, О.Билгүүн, Г.Батдэлгэр¹
¹“И-Монгол академи” УТҮГ, Сургалт, олон нийттэй харилцах газар

Үндэслэл:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөөс маш олон төрлийн дэмжлэг үзүүлэн олон талын хэрэгцээ шаардлага хангахыг зорьдог. Үүний нэгэн адил нэн тулгамдаж буй асуудлын нэг бол харааны бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах асуудал юм. Харааны бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт нь амьдралд дижитал орчинд бие даан үйл ажиллагаа явуулах боломжийг нэмэгдүүлэх зорилготой байдаг. Эдгээр сургалтууд нь хүний мэдээллийн технологийн хэрэглээг хялбарчилж, харааны бэрхшээлтэй иргэдийн өдөр тутмын амьдралд дасан зохицох, ажил эрхлэх, суралцах, нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох боломжийг бий болгодог. Монгол Улсын хэмжээнд 111,228 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдгаас 12,053 харааны бэрхшээлтэй иргэд байна [1]. Эдгээр иргэдийн мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж нийгмийн оролцоог сайжруулахын тулд тэдний цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг тасралтгүй зохион байгуулах хэрэгцээ шаардлага гарч байна.

Судалгааны зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг судлах, олон улсын туршлага шинжилгээ хийх, сургалт, үйл ажиллагааны үр дүнд үндэслэн харааны бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг дэмжих дүгнэлт гаргахад оршино.

Судалгааны арга зүй:

Баримт бичгийн харьцуулалтын арга, Ажиглалтын арга, Фокус бүлгийн ярилцлагын арга, Статистик шинжилгээний арга зэрэг арга зүйг ашигласан болно.


Үр дүн:

“И-Монгол академи” УТҮГ болон Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоотой 2022 онд байгуулсан “Харааны бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэхэд хамтран ажиллах харилцаа ойлголцлыг санамж бичиг”-ыг байгуулсан бөгөөд харааны бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадвар, мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааг хамтран зохион байгуулахаар болсон. Тус санамж бичгийн хэрэгжилтийг хангах үүднээс 2023 оноос нийт 5 удаагийн сургалтаар 23 иргэнд хүртээмжтэй технологийн сургалтыг зохион байгуулсан [2]. Нэг удаагийн сургалтаар 60 цагийн онол, практик хосолсон сургалтаар дэлгэц уншигч программыг чөлөөтэй ашиглаж сурах, мэдээллийг таньж мэдэх, хэрэгцээт мэдээллээ олох, хэрэглэх боловсруулах, хуваалцах, түгээх чадвартай болгох зорилготой юм.

Сургалтад хамрагдсан иргэдээс асуулга болон фокус бүлгийн аргаар судалгааг авч дараах үр дүн гарсан.


Дээрх судалгаанаас үзэхэд сургалтад хамрагдаж байгаа иргэдийн хүйсийн дийлэнх хувийг буюу 57 хувь эрэгтэйчүүд, 43 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

График 1. Сургалтад хамрагдсан иргэдийн насны ангилал



Цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдсан иргэдийн 15-16 нас 7.1 хувь, 20-29 насныхан 35.7 хувь, 30-39 насныхан 42.8 хувь, 40-50 насныхан 7.1 хувь, 60 ба түүнээс дээш насныхан 7.1 хувь тус тус эзэлж байна. Энэхүү графикаас харахад Цахим ур чадвар дээшлүүлэх сургалтад 20-40 насны иргэдэд сурах хэрэгцээ, шаардлага үүсэж байгаа нь харагдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар



Дүгнэлт:

Гар утасны камерыг ашиглан, объектыг таньж, зайг тооцоолон хэрэглэгчид аудио хэлбэрээр мэдээлэл хүргэх ухаалаг хөтөч системийг нэвтрүүлэхээр зорьсон. Судалгааны явцад туршилтын алдаа болон гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг нарийвчлан судалж, харьцуулалт хийснээр цаашдын хөгжүүлэлтэд хэрэгжүүлэх шаардлагатай шинэ санаанууд тодорхойлогдсон. Объект таних хурд болон зайг зөв тооцоолох чадвар нь системийн бодит үр дүн болон найдвартай байдалд чухал нөлөө үзүүлж байгааг туршилтаар баталлаа. Мөн аудио мэдээлэл дамжуулахад ашигласан API нь ярианы хурд, өнгийг тохируулах боломжийг олгож, мэдээлэл дамжуулах чадварыг 98%-д хүргэсэн нь батлагдсан. Мөн туршилтаар Монгол Улсын явган хүний зам дээрх гол объектуудыг илрүүлэх зорилгоор YOLOv5 загварт суурилсан объект таних алгоритмыг ашиглаж, 20 бодит замын бичлэг дээр туршилт хийсэн. Үүний үр дүнд объект илрүүлэх модуль 98.58%-ийн, зай тодорхойлох модуль 98.36%-ийн нарийвчлалтай болохыг баталгаажуулсан. Эдгээр үр дүн нь судалгааны үр дүнгийн чанарыг дээшлүүлж, цаашдын хөгжүүлэлтийг бодитой болгоход чиглэсэн суурь нөхцөлийг бүрдүүлж өгч байна

Түлхүүр үг: Object distance estimation, object detection, харааны бэрхшээлтэй иргэн, YOLOv5, TTS.

1. Ашигласан материал:

1. *Kuriakose, B.; Shrestha, R.; Sandnes, F.E. DeepNAVI: A deep learning based smartphone navigation assistant for people with visual impairments. Expert Syst. Appl. 2023*
2. <https://mpress.mn/p/2765> - Хараагүй иргэдэд тулгамддаг гол асуудал бол дэд бүтэц
3. *Building_A_Voice_Based_Image_Caption_Generator_with_Deep_Learning, 2021он*
4. *Indoor objects detection and recognition for an ict mobility assistance of visually impaired people, 2020.*
5. *J. Clerk Maxwell, A Treatise on Electricity and Magnetism, 3rd ed., vol. 2. Oxford: Clarendon, 1892, pp.68–73.*

УХААЛАГ ХӨТӨЧ

М.Түмэн-Аюуш, Ч.Мичидгоо, С.Батмөнх, С.Өлзийбаяр¹

¹ШУТИС, Мэдээлэл, холбооны технологийн сургууль

B210930048@must.edu.mn

Үндэслэл:

Монгол Улсад харааны бэрхшээлтэй иргэд болон хараатай иргэд ч аюулгүй байдлын асуудалтай тулгарч байна. Үүнд бид дараах судалгааг хийсэн. Монгол улсад нийт 12053 харааны бэрхшээлтэй иргэд байдгаас 17% нь ажил хөдөлмөр эрхэлж байна. Харааны бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт жил бүр 20%-аар буурч байна. Энэ нь нийгэмд томоохон сорилт болоод байгаа бөгөөд эдгээр иргэд өөрт шаардлагатай хэрэгслүүдээ хүртэл бүрэн хангуулах боломжгүй байна. Жишээлбэл, харааны бэрхшээлтэй иргэдийн 95% нь зөвхөн 70,000 төгрөгийн үнэтэй цагаан таяг ашигладаг. Гэтэл энэ нь тэдний амьдралын чанарыг дээшлүүлэхэд хангалтгүй юм.

Судалагааны зорилго:

Манай төслийн нэр бол Ухаалаг хөтөч. Энэхүү төсөл нь харааны бэрхшээлтэй иргэдийн аюулгүй байдлыг сайжруулах, тэдний өдөр тутмын амьдралыг хөнгөвчлөх зорилготой ухаалаг шийдлийг санал болгож байна. Энэ систем нь замын аюултай нөхцөлөөс сэргийлэх, хэрэглэгчдэд бодит цагийн мэдээллийг хүргэх зорилготой.

Судалгааны арга зүй:

Мэдээллийн технологийн хөгжил нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд дэвшил авчирч байгаа энэ цаг үед харааны бэрхшээлтэй иргэд ч эдгээр дэвшилтэт технологийг хүртэн, өөрт тохирсон шийдлээр хангагдах шаардлагатай. Энэхүү судалгаагаар бид Монгол орны нөхцөлд тохирсон, харааны бэрхшээлтэй иргэдийн аюулгүй байдал, бие даасан байдлыг хангах зорилгоор ухаалаг хөтөч системийг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулсан. Бид гар утасны камерыг ашиглан объект илрүүлэх (object detection), объектын зай тодорхойлох (object distance estimation), текстийг яриа болгон хувиргах (text-to-speech) зэрэг машин сургалтын загвар, техникүүдийг ашиглан харааны бэрхшээлтэй иргэдэд хэрэглэхэд хялбар, үнэ төлбөргүй, орон зайн мэдээллийг аудио хэлбэрээр дамжуулах боломжтой системийг боловсрууллаа. Судалгааны эхний шатанд Монгол улсын явган хүний зам дээрх гол объектуудыг илрүүлэх YOLOv5 загварт суурилсан объект таних алгоритмыг ашиглан 90 - 120 секундйн урттай 20 бодит замын бичлэг дээр туршилт хийж, объект илрүүлэх болон зай тодорхойлох модулиудыг 98.58% болон 98.36%-ийн нарийвчлалтайгаар тус тус баталгаажуулсан. Аудио мэдээлэх чадвар нь шаардлагын дагуу 98%-ийн үнэлгээтэй гарсан бөгөөд ярианы хурд, өнгийг тохируулах боломж бүхий API ашиглан текстийг аудио файлд хөрвүүлэх процессыг амжилттай хэрэгжүүлсэн. Энэ үр дүн нь системийн бодит цагийн туршилтад хэрэглэхэд найдвартай бөгөөд Монгол улсын нөхцөлд хэрэглэгчдийн аюулгүй, бие даасан байдлыг хангахад дэмжлэг болох боломжтойг харууллаа.

Үр дүн:

Туршилтын явцад хийгдсэн үйл явц, ажиллагааг нарийвчлан хянаж, алдааны хувиуд дээр үндэслэн харьцуулалтыг хийсэн. Энэ харьцуулалтаас цаашид анхаарах шаардлагатай зүйлс болон ирээдүйн хөгжүүлэлтэд хэрэгжүүлэх шаардлагатай шинэ санаанууд тодорхой болсон юм. Туршилтын харьцуулалтыг хийхдээ хэд хэдэн үндсэн атрибутуудыг сонгон авч, тэдгээрийг хувиар тооцоолон гаргаж, үр дүнг график хэлбэрээр харуулсан болно. Туршилт нийт 100 бичлэг дээр хийгдэж, тэдгээрээс дараах үндсэн харьцуулалтуудыг гаргаж ирсэн.

График 1. Харьцуулалт

График 2. Технологи, тоног төхөөрөмжийн хэрэглээ



Дэлгэц унших программыг ашигладаг иргэд 42.8 хувь, дэлгэц унших программыг огт ашигладаггүй иргэд 57.1 хувь эзэлж байна. Харин ухаалаг төхөөрөмж зарим тохиолдолд ашигладаг иргэд 85.7 хувь, ухаалаг төхөөрөмж огт ашигладаггүй иргэд 14.2 хувь эзэлж байна. Дээрх асуулгаас дүгнэхэд иргэд ухаалаг гар утсыг идэвхтэй ашигладаг ч дэлгэц унших программ ашиглал муу байгаа нь харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн төрийн үйлчилгээ авч ямар хэлбэрээр авдаг вэ? гэсэн асуултад веб сайтаар 50 хувь, гар утасны аппликейшнээр 10 хувь, биечлэн 40 хувь тус тус хариулсан байна. Дээрх судалгааг үзвэл иргэдийн ихэнх хувь нь ухаалаг гар утсыг ашигладаггүйн харагдаж байна.

Сургалтын дараах фокус ярилцлага

Сургалтад хамрагдсан иргэдээс сургалтын үр дүнг тодорхойлох зорилгоор фокус ярилцлага авч дараах нийтлэг хариултыг өгч байна. Үүнд:

Суралцаж буй сургалтаа сонгоход нөлөөлсөн гол хүчин зүйл вэ? гэсэн асуултад:

- Сургалтад өмнөх мэдлэг чадвартаа үндэслэн дахин ур чадвараа нэмэгдүүлэхийг зорьсон мөн найз нөхөд, гэрийнхнийхээ зөвлөгөө, хандлагыг дагасан.
- Шинэ зүйл сурах хүсэл эрмэлзэлдээ хөтлөгдөөд хөдөлмөрийн зах зээлийн цаашдын эрэлтийг тооцсон
- Өмнөх мэдлэг чадвартаа үндэслэн дахин ур чадвараа нэмэгдүүлэхийг зорьсон мөн шинэ зүйл сурах хүсэл эрмэлзэлдээ хөтлөгдсөн.

Дүгнэлт:

Монгол улсын хэмжээнд харааны бэрхшээлтэй 12,696 мянган хүн байгаагаас 6000 нь хөдөлмөрийн насны иргэд байна. Тухайн иргэд харааны эрхтний гэмтэл, согогийн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх боломжгүй, 97 хувь нь ажил эрхэлдэггүй гэсэн судалгааг Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооноос 2022 онд гаргасан байдаг. Харааны бэрхшээлтэй иргэдийг өөртөө итгэлтэй, нийгмийн идэвхтэй гишүүн болгож хөгжүүлэх, бусдын адил амьдрах боломж нөхцөл, нийгэмд оролцох оролцоо, хөдөлмөр эрхлэхэд дэм болж, эдийн засгийн нөхцөл байдал болон ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх үүднээс дэлгэц уншигч программыг чөлөөтэй ашиглаж сурах, мэдээллийг таньж мэдэх, аливаа мэдээллээс хэрэгцээндээ тохируулан ашиглах, хэрэглэх, боловсруулах, хуваалцах, түгээх зэрэг мэдээллийн технологийн хэрэглээний мэдлэг, чадварыг дэмжих сургалтыг тогтмол зохион байгуулах хэрэгтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй холбоотой бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах, тэдний цахим ур чадварыг дээшлүүлэхэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа чухал гэдгийг сургалтад хамрагдсан иргэд илэрхийлсэн.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүртээмж, дижитал, МХХТ, цахим.

Ашигласан материал:

1. УСХ, “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан,” [Online]. Available: <https://1212.mn/>
2. “И-Монгол академи” УТҮГ, “И-Монгол академи” УТҮГ,” [Online]. Available: www.ema.gov.mn
3. ASIAN DEVELOPMENT BANK, Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангах нь, 2019-02.
4. Иргэдийн төсөв онлайн платформ, “Иргэдийн төсөв онлайн платформ,” 2022. [Online]. Available: <https://irged.ulaanbaatar.mn/>.
5. Эрх зүйн нэгдсэн мэдээллийн систем, “Эрх зүйн нэгдсэн мэдээллийн систем,” [Online]. Available: www.legalinfo.mn.



III. БҮЛЭГ ХӨДӨЛМӨР

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ НЬ (НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН)

Н.Мөнхнаран, Э.Баярсайхан¹

¹Монгол Улсын Их Сургууль, Хууль зүйн сургууль
munkhnaran@gmail.com

Үндэслэл:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь нийгмийн оролцоог нэмэгдүүлж, эдийн засгийн бие даасан байдлыг хангах чухал ач холбогдолтой. Гэсэн хэдий ч Монгол Улсад энэ асуудалд хангалттай анхаарал хандуулахгүй байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг хязгаарлаж, ядуурал, ажилгүйдлийн түвшинг нэмэгдүүлэхэд хүргэж байна. Энэхүү судалгаа нь Монгол Улсын хууль эрх зүйн орчин, бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг олон улсын жишигтэй харьцуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих боломжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн болно.

Зорилго:

Судалгааны гол зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хууль эрх зүйн орчны хэрэгжилтэд үнэлгээ өгч, сайжруулах боломжит арга хэмжээг тодорхойлох явдал юм. Мөн олон улсын туршлагыг судалж, Монгол Улсад хэрэгжүүлэх боломжийг тодорхойлохыг зорьсон болно.

Судалгааны арга зүй:

Судалгааны ажлын хүрээнд дараах эх сурвалжуудад агуулгын шинжилгээ хийсэн. Үүнд:

- Монгол Улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд.
- Үндэсний Статистикийн Хороо, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамны тайлангууд.
- Олон улсын хөдөлмөрийн байгууллагын тайлан болон АНУ, Герман, Япон зэрэг орнуудын хөдөлмөр эрхлэлтийн туршлага.
- Судалгааны мэдээллийг статистик болон чанарын аргаар боловсруулж, харьцуулсан судалгаа хийсэн болно.

Үр дүн:

Судалгааны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг Монгол Улсад нэмэгдүүлэхэд тулгарч буй гол бэрхшээлүүдийг дараах байдлаар тодорхойллоо:

1. Дэд бүтцийн хүртээмжгүй байдал

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байранд шаардлагатай дэд бүтэц хангалтгүй байна. Тухайлбал, албан байгууллагууд болон нийтийн үйлчилгээний газрууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн налуу зам, өргөн хаалга, лифт, тусгай тэмдэглэгээ зэрэг стандартыг хангахгүй байгаа нь хөдөлмөр эрхлэх боломжийг хязгаарлаж байна. Үндэсний статистикийн хорооноос 2022 онд гаргасан судалгаагаар нийт 103,600 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагаас тэдний 73,285 нь хөдөлмөр эрхлэх боломжгүй гэж бүртгэгдсэн нь энэ асуудалтай шууд холбоотой юм (Үндэсний статистикийн хороо, 2022).

2. Ажил олгогчдын ялгаварлан гадуурхах хандлага

Ажил олгогчдын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авах нь нэмэлт зардал гэж үзэх, ажиллах чадварын талаар эргэлзэх зэрэг сөрөг хандлага хэвээр байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны судалгаагаар 2021 онд нийт ажил олгогчдын 60 гаруй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авахдаа тэдний ажиллах чадварыг дутуу үнэлдэг болохыг тогтоожээ (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, 2021).

3. Боловсрол, мэргэжлийн сургалтын хязгаарлагдмал байдал


Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд мэргэжлийн болон техникийн ур чадвар эзэмших боломж хязгаарлагдмал байна. Ихэнх сургуулиуд болон мэргэжлийн сургалтын байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хэрэгцээнд тохирсон хөтөлбөр, дэд бүтцээр хангагдаагүй байдаг. Жишээлбэл, 2022 онд Монгол Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын 15 орчим хувь нь сургуулийн дэд бүтцийн бэрхшээлээс болж сургуулиа орхисон байна (UNESCO, 2022).

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

4. Ажил эрхлэх боломжийн хязгаарлагдмал байдал

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 41.7% нь хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа нь тэд албан байгууллагад бус, хувийн жижиг бизнес эрхлэх замаар ажил эрхлэхийг илүүд үздэгийг харуулж байна. Энэ нь албан байгууллагуудын тэдэнд зориулсан ажлын байр хангалтгүй байгаагийн илрэл юм (ҮСХ, 2022).

График 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, 2022 он



Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хэлбэрүүд

№	Ажил эрхлэлтийн төрөл	Хувь (%)
1	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	41.7
2	Цалин хөлстэй ажиллагч	35.7
3	Өрхийн үйлдвэрлэлд оролцогч	20.1
4	Ажил олгогч	1.6
5	Нөхөрлөл, хоршооны гишүүн	0.3

Дүгнэлт:

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийн тулд төр, хувийн хэвшил хамтран ажиллах шаардлагатай байна. Ажил олгогчдын хандлагыг өөрчлөх, ажлын байрны хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөдөлмөр эрхлэлт, ажлын байр, дэд бүтэц, нийгмийн оролцоо.

Ашигласан материал:

1. *Хөдөлмөрийн тухай хууль (2021 он).*
2. *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016 он).*
3. *Үндэсний Статистикийн Хорооны 2022 оны тайлан.*
4. *Үндэсний статистикийн хороо, “Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт,” 2022 он.*
5. *Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Ажил олгогчдын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах хандлага,” 2021 он.*

ТӨВИЙН ДЭРГЭДЭХ “БҮЛГИЙН ТӨСӨЛ”-ИЙН АРГА ЗҮЙГЭЭР ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ НЬ

Д. Цолмон¹

¹ Хөвсгөл аймаг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв
tsolmon.bata@gmail.com

Үндэслэл:

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль эдгээрийн хэрэгжилтийг судлах, хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжийг тодорхойлох, ажил идэвхтэй хайж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг чадавхжуулах, сургалт мэдээллээр хангах асуудлууд чухал хэвээр байна. Иймээс ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн өөрийн хүсэл сонирхол, онцлог нь тулгуурлан амьдрах арга ухаанд суралцуулах, тулгарч буй хүндрэлүүдийг багасгах, эдгээр иргэдийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулах, төрийн болон төрийн бус, хувийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр манай төв нь “Бүлгийн төсөл”-ийн загвар арга зүйг боловсруулан туршин хэрэгжүүлж, сайжруулалт хийн ажиллах зайлшгүй хэрэгцээ шаардлага үүссэн юм.

Зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхол, хэрэгцээнд тулгуурлан олон талд арга замыг зөв тодорхойлон орлого олох, хүн бүрийг утга учиртай амьдрахад нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

Судалгааны арга зүй:

Хөвсгөл аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны иргэдэд дэлгэрэнгүй судалгааг хийж ажил хөдөлмөр эрхлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлон ICF үнэлгээний аргачлалыг ашиглан үнэлгээ хийж өөрийн хүсэл сонирхолд нь тулгуурласан төлөвлөгөөг боловсруулж ажиглалт асуумжийн аргад тулгуурлан дүн шинжилгээ хийж үр дүнг тооцов.

Үр дүн:

Манай төв нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Бүлгийн төсөл” арга зүйгээр дамжуулан 4 бүлэгт 16 иргэнийг хамруулан хүн тус бүрийн хүсэл зорилгыг тодорхойлон төлөвлөгөө боловсруулж, чадавхжуулах олон талт сургалт үйл ажиллагаанд хамруулснаар өнөөдрийн байдлаар 12 хүнийг тохируулгатай орчин хэрэглэгдэхүүнээр ханган цалин урамшуулал олгон амжилттай ажиллаж байна. Мөн лааны урлал, давсан урлал, саван урлал, шүр урлал, бэлэг дурсгал гэсэн 5-н төрлийн амьдрах ухааны дугуйланд нийт 29 хүүхдийг хамруулан хөдөлмөрт бэлтгэн сургах зэрэг бодит үр дүнд хүрч, сайжруулалт хийн ажиллаж байна. Төвийн дэргэдэх цаасан болон даавуун урлалын бүлэгт 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд иргэнийг асардаг 4 ээж нийт 6 хүн ажиллаж байна. Тус бүлэгт шаардлагатай тохируулгатай хэрэглэгдэхүүн орчныг сайжруулахад Тайваны хүүхдийг ивээх сангаас төсөл хэлбэрээр, хувь хүн албан байгууллагаас хандив тусламжаар нийт 20 гаран сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж бүлгийн 5 гишүүнд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний худалдан борлуулалтаас 5 сая гаруй төгрөгийн мөнгөн урамшуулал, цалинг олгон ажилласан байна.



Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

Зураг 1. Төвийн дэргэдэх цаасан болон даавуун урлалын бүлэг

Зураг 2. Гар урлалын бүлэг



Зураг 3. Төвийн дэргэдэх хүүхэд харах үйлчилгээ



Дүгнэлт:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн дэргэдэх “Бүлгийн төсөл”-ийг туршин хэрэгжүүлэхэд хүн бүрд харилцан адилгүй байсан ч төсөлд хамрагдсан нийт иргэдийн 90 гаруй хувийн хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхолд нийцэж буй нь дараах үйлээр илэрч байлаа.

- ✓ Тухайн иргэдийн эрүүл мэнд, амьдралын хэв маягт эерэг өөрчлөлт гарсан.
- ✓ Өөртөө итгэх итгэл нэмэгдэж амьдралын чанар нь өдрөөс өдөрт сайжирч байна.
- ✓ Би бусдын адил хөдөлмөрлөж чадна гэсэн урам зориг нь нэмэгдсэн.
- ✓ Өөрийгөө хөгжүүлэх, бусдаас суралцах, бусадтайгаа хуваалцах зэрэг хүсэл тэмүүлэл, хандлага сайжирсан.
- ✓ Гэр бүл, асран хамгаалагч цаашлаад олон нийтийн хандлагад эерэг өөрчлөлтүүд бий болсоор байна.

Эцэст нь дүгнэхэд улс орнуудын сайн туршлага, арга зүйг сайтар судлан шинжилж өөрийн орон нутгийн нөөц боломж, онцлогт тохируулан туршин хэрэгжүүлэх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо, хөгжил, хөдөлмөр эрхлэх үндэс суурь, утга учиртай амьдрах зэрэг нөхцөлүүдийг бүрдүүлж чадна гэсэн таамаглалаа баталлаа. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн байдлыг “Бүлгийн төсөл” арга зүйгээр дэмжих боломж буйг судалгааны ажлаараа нотлон харууллаа.

Түлхүүр үг: Хүсэл, сонирхол, онцлог, хүртээмж, гүйцэтгэл.

Ашигласан материал:

1. Олон улсад мөрдөгддөг үйл ажиллагааны ангилал (icf)-ыг ашиглан хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн агуулга, үр дүнгийн үнэлгээ 2023 он
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй дэд бүтэц
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль, эрх зүйн орчин, стандартын хэрэгжилтийн өнөөгийн байдал
5. Хөдөлмөрийн тухай хууль



**IV. БҮЛЭГ
ЭРҮҮЛ МЭНД**

ТАРХИНЫ ГЭМТЛИЙН ДАРААХ БАЙДАЛД ЦОГЦ СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭГ УРТ ХУГАЦААНД ХИЙСЭН ҮР ДҮН

Н.Золзаяа, Б.Хандсүрэн, Т.Оюунбилэг, Б.Урангоо, Х.Отгонбилэг¹, Ц.Наранцэцэг²

¹Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв

²Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль

b.khandaa0410@gmail.com

Үндэслэл:

Тархины гэмтлийн өвчин нь гавал- тархины гэмтлийн дараах ерийн үлдэц биш, хувирамтгай өөрчлөлт бүхий даамжрах эмгэг процесс юм.

Тархины гэмтлийн дараах эхний саруудад эргэн сэргэлт явагдах бөгөөд энэ үед мэргэшсэн багийн эрт үеийн сэргээн засах эмчилгээ маш чухал юм. Гэмтлийн дараах эхний жил нь тархины гэмтлийн дараа нөхөн сэргээх үйл явцад ач холбогдолтой үе гэж үздэг. Тархины гэмтэл нь нас баралт, хөгжлийн бэрхшээлийн хамгийн түгээмэл шалтгаан болдог. Тархины гэмтлийн дараах жам ёсны эдгэрэлттэй харьцуулахад сэргээн засахын олон мэргэжилтний багийн хамтарсан хөтөлбөрийн үр дүнтэй байдлын нотолгоо улам бүр нэмэгдэж байна.

Эмнэлзүйн тохиолдол

10 настай эрэгтэй, 2022 оны 6 сарын 30-нд Дорнод аймагт мориноос унаж гэмтэн, ухаангүй болсон. 7 сарын 6 –нд онгоцоор тээвэрлэн ГССҮТ-д ирж гавал тархины хүнд гэмтэл, менингит, уушгины хатгалгаа оношоор 20 хоног хэвтэн эмчлүүлж, 7 сарын 27-нд ЭХЭМҮТ-ийн МЭСТ-т шилжин посттравматическая энцефалопатия, спастический тетрапарез оношоор 3 сар ухаангүй байж 9 сарын 12 хүртэл хэвтэн эмчлүүлсэн.

2022 оны 10 сарын 25-нд ХБХСЗХТөвд хэвтэх үеийн зовуурь нь толгой даахгүй, юм ярихгүй, авиа гаргахгүй, 4 мөч саажсан, тавхай унжсан, Бартел индекс 0 оноотой буюу бусдын бүрэн хараат байсан.

Хүснэгт 1. Олон улсын үйл ажиллагааны ангилал(ICF)

БИЕМАХБОДИЙН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА	ИДЭВХ ОРОЛЦОО
<p>Харахад: Хэвтрийн байдалтай толгойгоо бүрэн даахгүй</p> <p>Үений далайц: тохой тэнийлгэх, тавхай ээтийлгэх үений далайцууд хязгаарлагдсан, контрактур үүссэн.</p> <p>Булчингийн хүч: булчингийн хүч буурсан.</p> <p>Рефлекс: DTR мөчдөд ихэссэн.</p> <p>Эмгэг рефлекс: Бабинский +/-</p> <p>ЭЭГ: Хэсэгчилсэн гемиконвульсив таталт</p> <p>Тархины СТ: гэмтлийн шалтгаант тархины баруун талын суурийн зангилаа, таламус хамарсан шимэгдэж буй цусан хураа. Тархины аксоны тархмал гэмтлийн дараах үлдэц</p>	<p>Чадаж байгаа зүйл: Хоол зажилж, залгина. Шээх, баахаа дохиогоор ойлгуулна. Хүний үгийг ойлгоно, толгойгоо дохиж хариулна</p> <p>Чадахгүй байгаа зүйл: Бие даан суух Бие даан зогсох, явах Бие даан хооллох Бие даан 00 орох Ярих</p>
ОРЧНЫ ХҮЧИН ЗҮЙЛ	ХУВЬ ХҮНИЙ ХҮЧИН ЗҮЙЛ
<p>Хөдөө гэрт амьдардаг.</p> <p>Эерэгээр нөлөөлж байгаа зүйл: Ээжийн асаргаа маш сайн, хүүхдийн бага зэргийн ч өөрчлөлт ахицад их урамшдаг, хүүхдээ бас урамшуулдаг, хүүхдийн эмчилгээг эмчилгээний бус цагаар ч маш сайн хийлгэдэг.</p>	<p>Нас: 8 Хүйс: Эрэгтэй Ам бүл 6 BMI - 15.9 ЕБС-ийн сурагч</p>

Судалгааны зорилго:

Богино хугацааны зорилго:

1. Ачаалал даах чадвар сайжруулах, толгой даалгах
2. Баруун гарын оролцоог сайжруулах
3. Өөрийгөө илэрхийлэх чадвар сайжруулах

Урт хугацааны зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

1. Өдөр тутмын үйл ажиллагаанд бусдын хараат бус болох
2. Ачаалал даах болон өөрийн насанд тохирсон боловсролын үйлчилгээг тасралтгүй авах, эзэмших чадварыг эзэмшүүлэх
3. Сургуульд эргэн орж нийгмийн харилцааг нэмэгдүүлэх

Судалгааны арга зүй, хийгдсэн эмчилгээ:

2022 оны 10 сараас 2024 оны 04 сарын хооронд 1 удаагийн эмчилгээ тус бүр 14 – 21 хоног үргэлжлэн, эмчилгээ хоорондын хугацаа 1-3 сар, нийт 7 курс Эрүүл мэнд болон Тэгш хамруулах нийгмийн сэргээн засах нийт 14 нэрт төрлийн эмчилгээн 129 хоногийн хугацаанд хамрагдсан.

Үр дүн:

Эхний хэвтэх үед үг хэлдэггүй, авиа гардаггүй байсан бол аяархнаар үг хэлнэ, идэх уух болон бусад хэрэгцээгээ үгээр илэрхийлдэг болж улмаар 3 сарын дараа хүүхдийн танин мэдэхүй, хөдөлгөөний үйл ажиллагаа мэдэгдэхүйц сайжирсан. Тархины гэмтэл авч тус төвд сэргээн засах цогц эмчилгээнд 1,6 жил хамрагдсанаар хөдөлгөөн, танин мэдэхүй, өөртөө үйлчлэх чадвар сайжирсан. Үүнд: бие даан өөрөө алхдаг болсон, хичээлдээ буцаж орсон, хоолоо өөрөө идэж чаддаг болсон. Бартел индекс 0-ээс 70 болж өдөр тутмын үйл ажиллагаанд “дунд зэргийн бусдын хараат” болж сайжирсан. Энэхүү тохиолдолд мориноос унаж тархины хүнд гэмтэл авсан 10 настай, хүүд сэргээн засах эмчилгээг багаар урт хугацаанд тасралтгүйгээр цогцоор хийснээр хүүхдийг нийгмийн харилцаанд эргүүлэн оруулсан үр дүн гарсан.

Дүгнэлт:

- Тархины гэмтлийн дараах сэргээн засах эмчилгээ нь нарийн төвөгтэй хэдий ч цогц байх ёстой. Тиймээс бидний судалгаагаар олон мэргэжилтний хамтарсан сэргээн засах цогц, тасралтгүй үргэлжлэх эмчилгээ нь тархины гэмтлийн дараах үйл ажиллагааны сэргэлтийг сайжруулж байгааг нотолж байна.
- Хүүхдэд тохиолдох эмгэгүүдэд цочмог үеийн сэргээн засах эмчилгээг багаар хийж байх нь хүүхдийн чадвар алдагдлыг богино хугацаанд бууруулах болон эмчилгээнд зарцуулах хугацаа, санхүүг бууруулах боломж бүрдэнэ.

Түлхүүр үг: Үл ашиглах хам шинж, чадвар алдагдал, эргэн сэргэлт, сэргээн засахын баг, бартелын индекс, тархины сэргэлт.

Ашигласан материал:

1. *Г.Цагаанхүү Мэдрэл судлал 498-499 хуудас*
2. *О.Батгэрэл. Тархины гэмтлийн сэргээн засал. Сэргээн засах анагаах ухаан сэтгүүл Vol 8 №2, September 2018, 11 хуудас*
3. *ЭМХТ Эрүүл мэндийн үзүүлэлт 2021. 134-137 хуудас*
4. *Christiaan Gmelig Meyling, Olaf Verschuren, Ingrid R Rentinck, Raoul H H Engelbert, Jan Willem Gorter. Physical rehabilitation interventions in children with acquired brain injury: a scoping review. DMCN Volume 64, Issue1 January 2022*

АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ ХҮҮХДҮҮДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТОЙМ ӨГҮҮЛЛЭГ

Д.Адъяа, Э.Долгорсүрэн, Э.Цогтбаатар, Б.Долгормаа, О.Наран, Э.Хулан, М.Түвшинзаяа, Г.Баяржаргал,
Ч.Амгаланбаяр, Э.Чимэдцогзол, Э.Энхчимэг¹
¹АШУҮИС Өрхийн Анагаах Ухаан судлалын тэнхим резидент эмч
Kotokoенxee414@gmail.com

Үндэслэл:

Аутизмын хүрээний эмгэг нь нийгмийн харилцаа холбоо, нийгмийн харилцааны байнгын дутагдалтай, зан үйл, сонирхол, үйл ажиллагааны хязгаарлагдмал, хэвшмэл хэв маягаар тодорхойлогддог олон хүчин зүйлээс үүдэлтэй мэдрэлийн хөгжлийн эмгэг юм. Энэ оношны тархалт сүүлийн хэдэн арван жилд нэмэгдэж байна [1]. Өнөөдөр дэлхийн хүн амын 1% буюу 70 сая хүн Аутизмын хүрээний эмгэгтэй байна. (ДЭМБ, 2023 он) АНУ-д 8 настай хүүхдүүдийн дундах судалгааны тайлангаар АХЭ-тэй хүүхдийн тоо 2016 онд 54-д 1, 2023 онд 36-д 1 болжээ. (CDC, 2023 он). Монголын Аутизмын Холбоонд бүртгүүлсэн АХЭ-тэй 785 хүүхдээс эрэгтэй 627 (79.87%), эмэгтэй 158 (20.13%), насанд хүрсэн аутизмтай хүн 23, 6-15 нас буюу ЕБС насны 387, СӨБ буюу 3-5 насны 375 хүүхэд бүртгэлтэй байжээ, (2019), [2]. Аутизмын хүрээний эмгэгийг хүний амьдралын 4 мөчлөг хуваан хэрэгцээ шаардлага тодорхойлж багаар тусламж үйлчилгээ үзүүлж байна. Зан үйлийн шинжилгээ эмчилгээг хийх нь дэлхий нийтэд үр дүнтэй арга болох нь тогтоогдсон байна. Зонхилон тохиолдох эмгэгийг хавсарч эмчлэх шаардлагатай байна. Бүх шатны байгууллага болон хүмүүст боловсрол, сэтгэлзүйг бэлтгэх нь тусламж үйлчилгээний тулгуур асуудал болж байна.

Судалгааны зорилго:

Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдэд зарим улс оронд амжилттай хэрэгжиж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг судлах

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй:

<https://pubmed.ncbi.nlm.nih.gov/> сайтаас аутизмын талаар хийгдсэн сүүлийн 5 жилийн доторх 3210 илэрцээс аутизмын хүрээний эмгэгийн эмчилгээ тусламж үйлчилгээний менежмент бүхий өгүүллэгийг сонгон авч, уншиж танилцан багаараа орчуулан оюун дүгнэлт хийж хүргэж байна.

Үр дүн:

Аутизмын хүрээний эмгэгтэй үйлчлүүлэгчийн амьдралын мөчлөг бүрт тохирсон тусламжийг хэрхэн хүргэх вэ?

1. Нялх, балчир нас: Хүүхдэд Аутизмын хүрээний эмгэг гэж оношлогдвол тэдний асран хамгаалагчид аутизмын хүрээний эмгэгийг иж бүрэн **ойлгоход** нь туслах гарын авлага, ухуулах хуудас, холбогдох байгууллагын найдвартай цахим хуудас зэрэг бэлэн нөөцийг нэвтрүүлэх ёстой. **Сэтгэлзүйн боловсрол** олгох нь асран хамгаалагчдын эргэлзээг тайлдаг. АХЭ өвчтэй хүмүүст **хоол боловсруулах эрхтний эмгэг, нойрны эмгэг, бодисын солилцооны эмгэг, шүдний өвчин зэрэг** [8] хавсарсан эмгэгүүд байнга тохиолддог тул зохих ёсоор эмчлэх шаардлагатай.

2. Сургуулийн насны үе: АХЭ-тэй хүүхэд цэцэрлэг, сургуульд орох насанд хүрсэн үед боловсролын хуваарилалтад асуудал үүсэж болно. АНУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролыг сайжруулах тухай хууль (IDEA)-тай адил хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай боловсролын тухай хуульд АХЭ өвчтэй хүмүүс ижил насны бусад хүмүүстэй **энгийн сургуульд нэгдсэн боловсрол эзэмших** ёстой гэж заасан байдаг. Хувь хүн бүрийн боловсролын хэрэгцээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэдний гэр бүл хүүхдүүдээ энгийн сургуульд сураасай гэж хүсдэг. Гэсэн хэдий ч жирийн **багш нар** АХЭ-тэй хүүхдийг үр дүнтэй удирдах тусгай боловсролыг **ховор** авдаг. Тиймээс байнгын болон тусгай ангиудыг хамтад нь явуулдаг хэсэгчлэн хамруулсан сургууль эсвэл тусгай сургуулиуд нь АХЭ-тэй хүүхэд болон тэдний гэр бүлийн хувьд бодит хувилбар байж болно. Хүртээмжтэй боловсролын хувьд АХЭ-тай хүмүүс нийгэмтэй харилцах боломжуудыг эзэмшиж, олж авсан ур чадвараа өдөр тутмын орчинд хэрэгжүүлэх ерөнхий чадварыг хөгжүүлэх боломжтой. Үүний эсрэгээр, хөгжлийн түвшин, шинж тэмдгүүдийн хүнд байдал, зан үйлийн бэрхшээлтэй зэргээс шалтгаалан ийм ур чадвар нь тэлэх төлөвгүй байгаа хүүхдүүдэд зориулсан тусгай боловсрол нь ашигтай байдаг. Жишээлбэл, юу болохыг мэдэхгүйгээс болж сэтгэл түгшсэн

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

үедээ хэвшмэл зан үйл нь улам хүндэрдэг хүүхдүүдэд дараагийн цагийн хуваарийг мэдээлэхийн тулд зураг, зургийг ашиглан цагийн хуваарь гаргаж, тэдний хэвшмэл зан үйлийг бууруулж, тэдэнд туслах болно.

3. Насанд хүрсэн хүн рүү шилжих: Судалгаанаас харахад АХЭ өвчтэй олон хүмүүс бие дааж, найз нөхөдтэй болж, сайн компанид сайн цалинтай ажилд орох боломжгүй байдаг энэ нь тэднийг гэр бүлээсээ хамааралтай болгодог. АХЭ-ийн үндсэн шинж тэмдгүүд нь насанд хүрэх шилжилтийн үед үргэлжилдэг; Тиймээс **ярианы эмчилгээ, хөдөлмөрийн эмчилгээ, нийгмийн ур чадварын сургалт** шаардлагатай байж болно. Үүнээс гадна, бие даасан байдлыг жигд байлгахын тулд өөрийгөө удирдах ур чадварын сургалт, амьдрах ур чадварын сургалт, мэргэжлийн ур чадварын сургалт, ажил мэргэжлийн болон хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг, зөвлөн туслах хөтөлбөр, кейс менежмент, сэтгэлгээний зэрэг ганцаарчилсан дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлэх шаардлагатай. Хөдөлмөр эрхлэлтийн орчин нь АХЭ-тэй хүмүүст тийм ч таатай биш байгаа нь тэднийг нийгмээс илүү тусгаарлаж, сэтгэлээр унасан, түгшүүртэй байдалд хүргэдэг бөгөөд энэ нь амиа хорлох оролдлого хийхэд хүргэдэг. Тиймээс АХЭ өвчтэй хүмүүс болон тэдний гэр бүл ийм бодит байдалд бэлэн байх ёстой.

4. Насанд хүрэгчдийн амьдрал: АХЭ өвчтэй хүмүүсийн дундаж наслалт тодорхойгүй байна. Осол, биеийн өвчний улмаас нас барсан тохиолдлоос бусад тохиолдолд дундаж наслалт хэвийн байх боломжтой. Ганцаараа байхыг илүүд үздэг гэсэн нийтлэг буруу ойлголт байдаг ч АХЭ өвчтэй хүмүүс дотно харилцаа, харилцан ойлголцол, сэтгэл хөдлөлийн бүрэн байдал дутмаг ажил хэрэгч харилцааны улмаас хүчтэй ганцаарддаг. Чанартай хөдөлмөр эрхлэлтийн орчин нь АХЭ-ийн үндсэн шинж тэмдгүүдийг хөнгөвчлөх, танин мэдэхүйн үйл ажиллагааг сайжруулж, эрүүл мэнд, өөрийгөө үнэлэх чадварыг сайжруулахад тусалдаг. Түүгээр ч зогсохгүй санхүүгийн бие даасан байдлыг бий болгож, орон сууцны тав тухтай орчин, чөлөөт цагаа өнгөрөөх боломжийг нэмэгдүүлнэ. Чанартай орон сууцны орчныг анхаарч үзэх нь АХЭ өвчтэй хүмүүст хамгийн бага хязгаарлалттай орчинд орон нутгийн нийгэмлэгийн гишүүн байх боломжийг олгодог. Хөршүүдтэйгээ ойр дотно харилцаа тогтоох, үүрэг гүйцэтгэх, тусламжаар амьдрах нь ганцаардлыг бууруулдаг. Цаашилбал, дээр дурдсан бие махбодийн болон сэтгэцийн хавсарсан өвчнийг эмчлэх, чөлөөт цаг, өдөр тутмын амьдралын ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрүүд нь амьдралын чанарыг сайжруулж чадна [4].

Аутизмын хүрээний эмгэгтэй хүмүүст ямар эмчилгээ хийгдэж байна вэ?

Одоогийн практикт санал болгож буй эмчилгээнд зан үйлийн шинжилгээ, хэл ярианы эмчилгээ, мэдрэхүйн эмчилгээ зэрэг орно. Зан үйлийн шинж тэмдгүүдэд эм хэрэглэж ирсэн. Үүдэл эсийн эмчилгээ, гипербарик хүчилтөрөгчөөр хангах зэрэг аргуудыг туршиж байна. Зан үйлийн гол дутагдлыг арилгах цорын ганц эмчилгээ бол зан үйлийн болон боловсролын эрт үеийн эрчимтэй эмчилгээ юм. Аутизмтай хүүхэдтэй ажиллахад хүүхдийн хөдөлгөөн засалч эмч, хүүхдийн сэтгэл зүйч, хөдөлмөр, зан үйлийн мэргэжилтэн, хэл засалч, сэтгэл зүйч, мэргэжлийн багш, нийгмийн ажилтан зэрэг мэргэшсэн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн баг шаардлагатай. Аутизмтай хүүхдүүдэд эрт (4 наснаас өмнө эхлүүлсэн) зан үйлийн болон хүмүүжлийн эрчимтэй эмчилгээ хийсний дараа танин мэдэхүй, харилцаа холбоо, дасан зохицох, нийгмийн үйл ажиллагаа сайжирч, түрэмгийлэл, хэт идэвхтэй байдал, уур хилэн зэрэг зохисгүй зан үйлүүд буурч байна. Эрт, эрчимтэй хэрэглээний зан үйлийн шинжилгээ (ЗҮШ) нь гайхалтай үр дүнд хүргэж болзошгүй бөгөөд үүнд ийм эмчилгээ хийлгэж буй хүүхдүүдийн бараг тал хувь нь оюун ухааны коэффициентын (IQ) сайн оноо авч, ердийн ангиудад суралцах боломжтой болно. **Зан үйлийн мэргэжилтэн нар нь анхаарал сарниулахгүй орчинд ганцаарчилсан эмчилгээг хийдэг.**

Эмчилгээний үндсэн зорилго: (Руттер, 1985)

1. Танин мэдэхүй, хэл яриа, нийгэмшлийн хэвийн хөгжлийг аль болох хөнгөвчлөх, идэвхжүүлэх.
 2. Хатуу байдал, хэвшмэл байдал, уян хатан бус байдал зэрэг аутизмтай холбоотой дасан зохицохгүй зан үйлийг бууруулах
 3. Хэт идэвхтэй байдал, цочромтгой байдал, импульсив зэрэг өвөрмөц бус дасан зохицох зан үйлийг багасгах эсвэл бүр арилгах.
 4. Гэр бүлийн стресс, ачааллыг хөнгөвчлөх.
- Эдгээр бүх эмчилгээг эрт эхлүүлсэн тохиолдолд үр дүн нь илүү сайн байдаг.

Аутизмын спектрийн эмгэгтэй хүүхдүүдэд шинж тэмдгийн эмчилгээнд глутатион

хэрэглэх нь

Өтгөн хаталт, цочромтгой гэдэсний хамшинж зэрэг АХЭ-ийн нийтлэг GI асуудлууд нь гэдэсний хэвийн бус ургамал, дархлааны тогтолцооны зохицуулалтаас үүдэлтэй байдаг. АХЭ өвчтэй хүүхдүүд глутатион зэрэг антиоксидант багатай тул исэлдэлтийн стресс ихтэй байдаг. Кетоген, өндөр антиоксидант, цавуулаг, казеин агуулаагүй, пробиотикоор баялаг хоолны дэглэм зэрэг эмчилгээний хоолны дэглэмүүд нь зан төлөв, харилцаа холбоо, GI асуудал, исэлдэлтийн стресс зэрэг АХЭ шинж тэмдгүүдийг удирдах боломжтой боловч нотлох баримт хязгаарлагдмал байдаг. [5]

Дүгнэлт:

1. Аутизмын хүрээний эмгэгийг хүний амьдралын 4 мөчлөг хуваан хэрэгцээ шаардлага тодорхойлж багаар тусламж үйлчилгээ үзүүлж байна.
2. Зан үйлийн шинжилгээ эмчилгээг хийх нь дэлхий нийтэд үр дүнтэй арга болох нь тогтоогдсон байна. Зонхилон тохиолдох эмгэгийг хавсарч эмчлэх шаардлагатай байна. Бүх шатны хүмүүст боловсрол, сэтгэлзүйг бэлтгэх нь тусламж үйлчилгээний тулгуур асуудал болж байна.

Түлхүүр үг: Аутизмын хүрээний эмгэг(АХЭ), хүүхэд, тусламж үйлчилгээ.

Ашигласан материал:

1. *Manjiri Deshpande Shenoy¹, Vishal Indla¹, Harish Reddy¹ Comprehensive Management of Autism: Current Evidence PMID: PMC5733418 PMID: 29284801 © 2017 Indian Psychiatric Society | Published by Wolters Kluwer - Medknow*
2. <https://autism.mn/what-is-autism/statistics/>
3. <https://autism.mn/what-is-autism/>
4. *Jung-Woo Son¹ and Seok-Hyun Nam² 1 Department of Neuropsychiatry, College of Medicine, Chungbuk National University, Cheongju, Korea 2 Department of Psychiatry, Jeonbuk National University Hospital, Jeonju, Korea Basic Management Strategies by Life Cycle for Treatment of the Persons With Autism Spectrum Disorder SPECIAL ARTICLE: Korean Practice Guideline for Autism Spectrum Disorder J Korean Acad Child Adolesc Psychiatry 2024;35(1):22-28 <https://doi.org/10.5765/jkacap.230011>*
5. *Karam Radwan¹, Gary Wu², Kamilah Banks-Word¹, Ryan Rosenberger¹ An Open-Label Case Series of Glutathione Use for Symptomatic Management in Children with Autism Spectrum Disorder PMID: 37987328 PMID: PMC10660524 DOI: 10.3390/medsci11040073 Med Sci (Basel) 2023 Nov 15;11(4):73. doi: 10.3390/medsci11040073.*

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ӨСВӨР НАСНЫ ОХИДЫН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Х.Хулан¹

¹Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын мэргэжилтэн

Үндэслэл:

Өсвөр үе, залуучуудын хөгжил төлөвшилд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал чухал нөлөөтэй. Нөхөн үржихүйн эрүүл мэнд гэдэг нь хүний нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо, түүний үйл ажиллагаа хэвийн байх төдийгүй, хүн бие махбод, оюун санаа, нийгмийн талаар бүрэн төгс, эрүүл саруул байх тухай ойлголт юм. Олон улсад хүүхдийг бага наснаас нь эхлэн хүлээн авах, ойлгох байдалд нь тохируулан өөрийнх нь бие махбодтой танилцуулах, хувийн ариун цэвэртээ анхаарах, нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэг ойлголтуудыг олгож байдаг. Иймд өсвөр насны тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй охидын нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэг, ойлголтыг судлах нэн хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Судалгааны зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй өсвөр насны охидын нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролын талаарх мэдлэг ойлголтыг судалж, дүн шинжилгээ хийхэд оршино.

Судалгааны арга зүй:

Хүснэгт 1. Судалгааны судлах зүйл, аргачлал

№	Судлах зүйл	Судалгааны арга	Дүн шинжилгээ хийх мэдээлэл
1	Нөхөн үржихүйн эрүүл мэндийг тодорхойлох үзүүлэлтүүд судлах	Баримт бичгийн судалгаа	Ном, судалгаа, тайлангууд
2	ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн сурах бичгийн агуулга, үндэсний хэмжээнд хэрэгжсэн хөтөлбөрт дүн шинжилгээ хийх	Баримт бичгийн дүн судалгаа	ЕБС-ийн 5-12 дугаар ангийн эрүүл мэндийн хичээлийн сурах бичиг
3	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэг, ойлголтыг тодорхойлох	Асуумж арга ашиглах	Судалгааны мэдээлэл
4	Үр дүнг боловсруулах	IBM SPSS statistics 26 программ	Судалгааны мэдээлэл


Үр дүн:

Нөхөн үржихүйн эрүүл мэнд гэж нөхөн үржихүйн тогтолцоо болон нөхөн үржихүйн чадавх, үйл явцтай холбоотой бүх асуудлаар аливаа өвчин, эрүүл мэндийн доройтлыг боломжит хамгийн өндөр хэмжээнд сэргийлсэн, хувь хүний бие физиологи, сэтгэл санаа болон нийгмийн амьдрал бүрэн хэмжээгээр сайн байх нөхцөлийг ойлгоно. 1998 онд анх Эрүүл мэнд хичээл ЕБС-ийн хичээлийн төлөвлөгөөнд орж эхэлсэн. БСШУ-ны сайдын 2014 оны наймдугаар сарын 26-ны А/335 тушаалаар Эрүүл мэндийн хичээлийг хасаж бусад хичээлтэй интеграцчилах тухай шийдвэр гарч байсан. БСШУСЯ-аас эрүүл мэндийн боловсролын агуулгыг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн бие даасан хичээлийн хэлбэрээр судалдаг болгохоор шийдвэрлэсэн. “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/491 дүгээр тушаалаар батлагдаж ЕБС-д өнөөдрийг хүртэл судалж байна (БСШУ, 2019). Эрүүл мэндийн хичээл бага ангийн сургалтын хөтөлбөрт 64 цаг, дунд ангийн хөтөлбөрт 132 цаг, ахлах ангийн хөтөлбөрт 99 цаг тусгаж өгсөн ба тус хичээлийг нийт 295 цаг зааж байна. Дүн шинжилгээний хүрээнд уншсан 5-12 дугаар ангийн “Эрүүл мэнд” хичээлийн сурах бичгүүд 2019 онд БШУЯ-ны зөвшөөрлөөр хэвлэгдэн өнөөг хүртэл ЕБС-д хэрэглэгдэж байна.

ЕБС-ийн “Эрүүл мэнд” хичээлийн сурах бичгийн агуулга хөтөлбөрт шинжилгээ хийхэд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан. Гэхдээ олон талт ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, зураг дүрслэл бага охид, эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй, эрэгтэй эмэгтэй хүний жендэрийн үүрэг, ажил мэргэжил, шинж чанарын хувьд хэвшмэл, өрөөсгөл, тогтсон гадуурхлаар илэрхийлэгдсэн тусгасан байна.


Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

График 1. Бэлгийн болон НҮЭМ-ийн талаарх ойлголт



Бэлгийн болон НҮЭМ-ийн талаарх ойлголтын хувьд 33 хувь нь сарын тэмдэгийн эрүүл ахуй, 24 хувь нь аюулгүй бэлгийн харилцаа, 14 хувь нь гэр бүл төлөвлөлт гэдэг 3 зүйлийг бусад хариултуудаас илүү сонгосон байна (График 1).

График 2. Бэлгийн болон НҮЭМ-ийн талаар мэдээллийн эх сурвалж болон анги



Судалгаанд оролцогчдын 38 хувь нь бэлгийн болон НҮЭМ-ийн талаарх мэдээллийг гэр бүлээсээ, 14.2 хувь найз нөхөд, 2.3 хувь нь телевиз, радио, 7.1 хувь нь эмч, эмнэлгийн ажилтан, 2.3 хувь нь интернэт, 21.4 хувь нь багш, 7.1 хувь нь сургалт, ном сурах бичиг, 7.1 хувь нь бусад эх сурвалжаас мэдээллийг олж авдаг байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй өсвөр насны охидын нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдээллийг суралцаж буй ангиас хамаарч, харилцан адилгүй эх сурвалжаас олж авч байна. (График 2).

Хүснэгт 2. Бэлгийн болон НҮЭМ-ийн бүрэлдэхүүн хэсгүүдийн талаарх ойлголт

№	Ойлголтууд	Дундаж /Mean/	Стандарт хазайлт /Std.deviation/
1	Гэр бүл төлөвлөлт	3.00	1.189
2	Үр хөндөлт	2.81	1.234
3	Цэвэршилт	2.57	1.151
4	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин	2.76	1.322
5	Үргүйдэл	2.36	1.165
6	Өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэнд	2.81	1.110
7	Эсэн мэнд амаржихуй	2.52	1.110
8	Жендэр ба хүйсийн асуудал	2.57	1.233
	Дундаж	2.67	1.189

Бэлгийн болон НҮЭМ-ийн бүрэлдэхүүн хэсгүүдийн талаарх мэдлэг, ойлголтыг илрүүлэх асуулга нь өгөгдөл бүрийг хэр зэрэг мэдэж байгаагаас хамаарч 1-5 оноогоор үнэлэхээр боловсруулагдсан. Судалгаанд оролцсон суралцагчдын үнэлгээний дундаж $x=2.67$ гэсэн үр дүн гарав. Өгөгдөл бүрээр үзвэл “Гэр бүл төлөвлөлт” гэсэн 1 дүгээр өгөгдлийн дундаж $x=3.00$, үзүүлэлттэй байгаа нь бусад өгөгдөлтэй харьцуулахад хамгийн өндөр оноотой байна (Хүснэгт.2.). Энэ нь судалгааны өгөгдөл бүхий хандах зүйлээс шалтгаалан суралцагчдын ойлголт ялгаатай байгааг харуулж байна.

Дүгнэлт:

НҮЭМ гэдэг ойлголтод хүний сэтгэл ханамж бүхий аюулгүй бэлгийн амьдралтай байх, нөхөн үржихүйн чадавхтай байж хэзээ, хэдий хугацаанд хэдэн хүүхэд төрүүлэхээ өөрсдөө шийдвэрлэх эрх чөлөөг багтааж үздэг. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд нь гэр бүл төлөвлөлт, жирэмслэлт, үр хөндөлт, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, өсвөр насны нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүйс ба жендэр зэрэг багтдаг. Эрүүл мэндийн хичээл бага ангийн сургалтын хөтөлбөрт 64 цаг, дунд ангийн хөтөлбөрт 132 цаг, ахлах ангийн хөтөлбөрт 99 цаг тусгаж өгсөн ба тус хичээлийг нийт 295 цаг зааж байна. Бэлгийн болон НҮЭМ-ийн талаарх мэдлэг ойлголтын хувьд 33 хувь нь сарын тэмдгийн эрүүл ахуй үзсэн байна. Энэ нь 3 охин тутмын 1 нь бэлгийн болон НҮЭМ гэдгийг сарын тэмдгийн эрүүл ахуй гэж ойлгодог байна. Гэвч нөхөн үржихүйн эрүүл мэнд гэдэг бол зөвхөн сарын тэмдгийн эрүүл ахуй гэдгээр хязгаарлагдахгүй юм. Судалгаанд оролцогчдын 57.1 хувь нь бэлгийн болон НҮЭМ-ийн талаар нэмэлт сургалт мэдээлэл авах хүсэлтэй байна.

Түлхүүр үг: Нөхөн үржихүйн эрүүл мэндийг тодорхойлох үзүүлэлтүүд, өсвөр насны охид, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд.

Ашигласан материал:

1. *Үндэсний статистикийн хороо. (2022). Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо. Монгол Улс, улаанбаатар хот.*
2. *Эрүүл мэндийн сайдын тушаал. (2019). Үр хөндөлтийг зохицуулах журам.*
3. *Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын сайд. (2019 оны 08 01). Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай.*
4. *Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан. (2019). Өсвөр наснаас залуу на хүртэлх үе. Монголын өсвөр үеийнхний цогц хөгжлийг ойлгох нь, 105.*
5. *Хүний эрхийн комисс. (2021). Нөхөн үржихүйн эрх хүний эрх болох нь. Монгол улс, Улаанбаатар хот.*

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН 0-16 НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН ӨВЧЛӨЛ БОЛОН БОЛОВСРОЛЫН ТЭГШ ХҮРТЭЭМЖИЙГ СУДАЛСАН НЬ

О.Уранчимэг, Б.Цолмонгэрэл, Б.Даваасүрэн, М.Азжаргал¹,
¹Дорноговь аймаг Агатова ӨЭМТ
Urnaa4931@gmail.com

Үндэслэл:

ДЭМБ-ын сүүлийн судалгаагаар дэлхийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 15 хүртэлх насны 93 сая орчим хүүхэд байна. НҮБ-ын Хүүхдийн сангаас “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сайн боловсрол эзэмшүүлж, нийгмийн харилцаанд оролцуулахын тулд тэднийг бусдаас тусгаарлаж буй саадыг арилгах ёстой” гэж зөвлөж, үйл ажиллагааныхаа нэг чиглэл болгожээ. Хөгжингүй орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх, нийгэмшүүлэх загвараа хэдийн бий болгожээ. Ингэхдээ хүртээмжтэй боловсролд түлхүү анхаардаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тулгардаг нийгмээс гадуурхагдахад хүргэдэг олон шалтгааныг үүгээр арилгах боломжтой гэж үздэг байна. Манай улсын хувьд ч ГБХНХЯ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхийн холбоо, Монголын дауны болон аутизмын холбоо, БШУЯ, ЭМЯ, Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл, Боловсролын хүрээлэн зэрэг байгууллага хүүхдийн хөгжлийн төлөө тогтмол хамтран ажиллаж ирсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн олонх нь үл хайхрах хүчирхийлэлд өртөж, сурах эрхээ хязгаарлуулж байгаагийн илрэл нь 18 хүртэлх насны 11 мянга гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 65 хувь нь албан болон албан бус боловсролд хамрагддаг гэсэн статистик байна. Харин бусад хүүхэд сургууль завсардаж, сурах эрхээ эдэлж чадахгүй байгаа нь асран хамгаалагчдын шийдвэр, дэд бүтэц, зам, тээврийн хүртээмжгүй байдалтай холбоотой. Хөгжлийн ялгаатай суралцагчидтай ажиллах мэргэжлийн боловсон хүчний дутагдал, тусгай хэрэгцээт боловсролын арга зүйн шинэчлэл, эрүүл мэндийн салбар /эрт илрүүлэлт/, -ын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Судалгааны зорилго:

Сайншанд сумын хэмжээнд байгаа 0-16 насны Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг гаргаж хяналтыг сайжруулах, сурч боловсрох орчин бүрдсэн эсэхийг судлах.

Судалгааны арга зүй:

Дорноговь аймгийн Сайншанд сумын 11 дүгээр цэцэрлэг болон насан туршийн боловсролын багштай фокус ярилцлагын аргын хүрээнд судалгаа боловсруулав.

Үр дүн:

Дорноговь аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 0-16 насны 311 хүүхэд байгаагаас Сайншанд суманд 106 хүүхэд /34,1%/ амьдарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй 0-16 насны хүүхдийг хүйсээр /хувиар/ авч үзвэл 70% нь эрэгтэй, 30% нь эмэгтэй байна.


Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн нас

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг насаар задалбал		
1	0-1 нас	10
2	2-5 нас	16
3	6-9 нас	28
4	10-13 нас	37
5	14-16 нас	15

График 1. Бэрхшээлийн төрөл

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар


ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ 0-16 НАСНЫ ХҮҮХДИЙН ӨВЧЛӨЛИЙГ ОУӨ-НИЙ АНГИЛЛЫН БҮЛГЭЭР БОДИТ ТООГ ХАРУУЛБАЛ



Дорноговь аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан 11-р цэцэрлэгийн 1 анги байдаг ба тус ангид 12 хүүхэд бүртгүүлснээс 5 хүүхэд хүмүүждэг. Бусад хүүхдүүд ямар нэг шалтгааны улмаас ирдэггүй. /эмчилгээ хийлгэх шаардлагатай, гадаа хүйтэн болоход, гэртээ харах хүнтэй г.м/. 9-р цэцэрлэгт 2 хүүхэд, 1 болон 5-р цэцэрлэгт тус бүр нэг хүүхэд хүмүүждэг. Үүнээс харахад цэцэрлэгийн насны бүртгэлтэй 16 хүүхдээс 7 хүүхэд /43.7%/ цэцэрлэгт хамрагдаж 9 хүүхэд /56,3%/ гэртээ байна.

График 2. Өвчний тэргүүлэх 5 оношийг ОУӨ-ний код олон тоо

ӨВЧНИЙ ТЭРГҮҮЛЭХ 5 ОНОШИЙГ ОУӨ-НИЙ КОД БОЛОН ТООГООР ХАРУУЛБАЛ



Хүснэгт 2. Хөгжлийн бэрхшээлтэй цэцэрлэгийн насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтын байдал

№	Нэр	Хүүхдийн тоо
1	1-р цэцэрлэг	1
2	5-р цэцэрлэг	1
3	9-р цэцэрлэг	2
4	11-р цэцэрлэг	5
5	Бусад шалтгаанаар гэрт байдаг	7

Сургуулийн насны 80 хүүхдээс ЕБС-д хамрагдалт: Насан туршийн боловсролд 25 хүүхэд бүртгүүлсэн ба 5 хүүхэд, 2-р сургуульд-10, 6-р сургуульд-4 хүүхэд суралцдаг.

График 3. Хөгжлийн бэрхшээлтэй сургуулийн насны хүүхдийн сургуульд хамрагдал

Хөгжлийн бэрхшээлтэй сургуулийн насны хүүхдийн сургуульд хамрагдалт бодит тоогоор



Дүгнэлт:

Сайншанд суманд Хөгжлийн бэрхшээлтэй 80 хүүхэд буюу 75,5% нь сургуулийн насны хүүхдүүд дийлэнх хувь нь эрэгтэй хүүхдүүд байна. Өвчлөлийн байдлаар авч үзэхэд эхний 5 байранд Хүүхдийн тархийн саа /ДЦП/, Зүрхний гажиг, Уналт таталт /Эпилепси/, Аутизм, Даун ээрэг өвчлөл эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, цаашид гарах хүндрэлээс сэргийлэх нь чухал байна. Эрүүл мэнд, Боловсролын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах хүүхдүүдийн өвчлөлд анхаарал хэт хандуулахаас илүүтэй бие даах чадварт сургах, дасгах, хүрч үйлчлэх хэрэгцээг нэн түрүүнд тавих хэрэгцээтэй байна.

Түлхүүр үг: Боловсролын тэгш хүртээмж, өвчлөл, эрүүл мэнд, эрт илрүүлэг.

Ашигласан материал:

1. *Дорноговь аймгийн Сайншанд сумын 3 өрхийн эрүүл мэндийн төвүүдийн “ 0-16 насны Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 2023 оны судалгаа, статистик мэдээлэл, Монгол улс, Дорноговь аймаг.*
2. *H-info3 программд 2023-2024 онд бүртгэгдсэн 0-16 насны хүүхдүүдийн нийт үзлэг, өвчлөлийн мэдээлэл, Монгол улс, Дорноговь аймаг.*

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ХҮРГЭХ ХӨДӨЛГӨӨН ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНИЙ ТЭГШ ХҮРТЭЭМЖ

Ц.Даш-Өлзий¹

¹Сэргээн засалт сургалт, үйлдвэрлэлийн төв

Dashulzii119@gmail.com

Үндэслэл:

Сэргээн засах анагаах ухаанд хөдөлгөөн засалч мэргэжилтэн голлох үүрэг гүйцэтгэж байна. Сэргээн засах эмчилгээнд хөдөлгөөн засал эмчилгээний үүрэг, хүртээмжийг тодорхойлно.

Хөдөлгөөн засалч гэдэг нь:

- Хөдөлгөөний эмгэгт тохирсон үнэлгээ хийнэ.
- Оношилж эмчилнэ
- Амьдралын чанарыг дээшлүүлнэ
- Хөдөлгөөний чадвар алдалтыг бууруулна
- Хөдөлгөөний үйл ажиллагааны чадварыг хамгийн дээд түвшинд хүргэнэ гэсэн зорилгоор олон улсад судалгаа шинжилгээгээр нотлогдсон эмчилгээ үйлчилгээний аргад суурилсан тусламж үйлчилгээ юм.

Хөдөлгөөн засалчийн мэргэжлийн ур чадвар нь үйлчлүүлэгчтэй холбоотой хүлээгдэж буй мэргэжлийн үүрэг хариуцлага, шинж чанар, харилцан үйлчлэл, хандлага үнэ цэнийн нийлбэр юм.

Хүснэгт 1. Мэргэжлийн тайлбар

Хөдөлгөөн засалч	Бариа засалч	Сувилагч
Хөдөлгөөний эмгэгт тохирсон үнэлгээ хийж, оношилж эмчлэх бөгөөд амьдралын чанарыг дээшлүүлж, чадвар алдалтыг бууруулан, үйл ажиллагааны чадварыг хамгийн дээд түвшинд хүргэх зорилгоор олон улсад судалгаа шинжилгээгээр нотлогдсон эмчилгээ үйлчилгээний аргад суурилсан тусламж үйлчилгээ үзүүлнэ. Хөдөлгөөн засалчийн мэргэжлийн ур чадвар гэдэг нь үйлчлүүлэгчтэй холбоотой хүлээгдэж буй мэргэжлийн үүрэг хариуцлага, шинж чанар, харилцан үйлчлэл, хандлага үнэ цэнийн нийлбэр.	Хүний биеийн гадаргуу дээр байх сувгийн дагуу илэх, үрэх, нухах, чичиргээн, доргиох аргаар арьсан доорх өөхөн эд булчин, холбооснуудад сэдээлт өгч улмаар мэдрэлийн ширхгүүдийг тайвшруулах, бичил цусны эргэлтийг сайжруулах тунгалгийн зангилааг нэвтрүүлэх арьсны тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх булчин сулруулах, өвдөлт намдаах засал юм.	Түгээмэл болон зонхилон тохиолдох өвчин эмгэгүүдийн эмчилгээ оношилгоо, урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээнд сувилахуйн чиглэлээр анхан шатны тусламж үзүүлэх чадвартай эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр сувилахуйн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэхэд шаардагдах сувилахуйн ухааны онолын мэдлэг, чадвар хандлага эзэмшсэн мэргэжилтэн юм.

Судалгааны зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Хөдөлгөөн засал эмчилгээний тэгш хүртээмжийг судлах хэрэгцээг тодорхойлох

Судалгааны арга зүй:

Санамсаргүй түүврийн аргаар нийт 79 оролцогчоос google form ашиглан судалгааг авч үр дүнг тооцсон.

Үр дүн:

Монгол улсад 2023 оны байдлаар 111,228 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг бөгөөд үүнээс тулгуур эрхтний хөдөлгөөний бэрхшээлтэй 20,018 хавсарсан оноштой 7,409 иргэн байна. Энэ нь нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 24,6% ийг эзэлж байна. Хөдөлгөөн засалч мэргэжлийн хүний нөөц: 2007 онд АШУУИС Японы Гүнма их сургуулийн мэргэжилтнүүдтэй хамтран хөдөлгөөн засалчийн ангийг нээн 263 хөдөлгөөн засалч бэлтгэж, тус мэргэжлээр 129 оюутан суралцаж байна. Олон улсын жишигт 8 хүн тутамд 1 хөдөлгөөн засалч оногддог судалгаа байгаа бөгөөд АНУ, Солонгос, Япон зэрэг орнуудад түүнээс ч бага тоон үзүүлэлт байна. Харин Монгол Улсад 111228 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 263 хөдөлгөөн засалч эмчилгээ үйлчилгээ үзүүлж байгаа нь тэгш хүртээмжтэйгээр эмчилгээ үйлчилгээг үзүүлэхэд ачаалал ихтэй байгааг харуулж байна. Хувийн болон улсын эмнэлгүүдэд нэг хөдөлгөөн засалч нэг өдөрт 20-40 иргэнд

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

үйлчилгээ үзүүлж байна. Эмнэлгийн ачааллаас хамааран нэг хөдөлгөөн засалчид ногдох эмчлүүлэгчийн дундаж тоо 20-40 байгаа нь эрэлт хэрэгцээ их байгааг (82.3%) илтгэж байна. Хөдөлгөөн засалчаас хүлээж буй гол үр дүн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даах чадварыг нэмэгдүүлэх чадвар юм.

Дүгнэлт:

1. Сэргээн засах төвүүдэд хөдөлгөөн засалчийн ажлын байранд сувилагч, бариа засалч ажиллаж байгаа нь хөдөлгөөн засалч мэргэжилтнүүдийг хүрэлцээтэй мэт харагдуулж байна.
2. Монгол улсад нэн шаардлагатай мэргэжлийн жагсаалтад хөдөлгөөн засалч орж тухайн мэргэжлээр суралцагчдын тоо нэмэгдсэн боловч мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгчид цөөн байна.
3. Үндсэн цалингаас гадна үр дүнгийн урамшуулал бодит биш байдаг.
4. Ажлын байранд үл хамаарах мэргэжлийн болон харилцааны дарамт ихтэй.
5. Эмчилгээнд зориулагдсан аппарат тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байдаг.
6. Хөдөлгөөн засалч мэргэжлийн тусламж үйлчилгээг бодитоор үнэлж, хүртээмжийг нэмэгдүүлэх нэн шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. Статистикийн хорооны 2023 оны тоон мэдээлэл ашигласан
2. 2024 оны МБХЗХ-ны 14-р чуулганы илтгэлээс

ТАРХИНЫ СААТАЙ ХҮҮХДЭД SPIDER CAGE БУЮУ ААЛЗНЫ ТОР АРГЫГ НЭВТРҮҮЛЖ ЭМЧИЛГЭЭНД АШИГЛАСАН ҮР ДҮН

Н.Цэсэнжав, Б.Оюунсүрэн¹, Э.Баасанхүү², Д.Билгүүн³

¹Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв,

²ХУД-ийн эрүүл мэндийн төв,

³АШУҮИС, Бие бялдар судлалын тэнхим

tsesenjavnaranaabaatar@gmail.com

Үндэслэл:

Тархины саа (ТС) нь пренаталь эмгэгийн дотор хамгийн элбэг тохиолддог ба тархины хөгжлийн эрт үеийн гэмтлээс үүдсэн байршлын болон хөдөлгөөний өөрчлөлтийн бүлэг хамшинжээр илэрдэг эмгэг. Дани улсын эрдэмтэн Мэтт Янке 2014-2015 онд spider cage буюу аалзны тор эмчилгээний төхөөрөмжийг зохион бүтээсэн байна. Энэ арга нь тархины төвүүд болон булчингийн үйл ажиллагаа, хөдөлгөөний чадварыг боломжит түвшин хүртэл хөгжүүлэх зорилготой хөдөлгөөн засал эмчилгээний нэг төрөл юм. Бид орчин үеийн эмчилгээний аргуудыг нэвтрүүлж ХБХСЗХ төвийнхөө эмчилгээ үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах улсын хэмжээнд хүртээмжтэй, үр дүнтэй хөдөлгөөн засал эмчилгээний тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилготой байгаа тул **spider cage** эмчилгээний аргыг нэвтрүүлж ямар үр дүнтэй болохыг судлах үндэслэл болсон.

Судалгааны зорилго:

Тархины саатай хүүхдүүдэд “**SPIDER CAGE БУЮУ ААЛЗНЫ ТОР**” эмчилгээний зарчмаар хийсэн хөдөлгөөн засал эмчилгээний үр дүнд дүн шинжилгээ хийж харьцуулан судлах.

Судалгааны арга зүй:

2024 оны 02 сараас 2024 оны 8 сар хүртэл хугацаанд тус төвөөр хэвтэн эмчлүүлж хөдөлгөөн засал эмчилгээнд хамрагдаж байсан үйлчлүүлэгчдээс 2-17 насны (эрэгтэй 30, эмэгтэй 20) нийт 50 оролцогчдыг хамруулсан. Судалгаанд хамрагдсан хүүхдүүд 14 хоног хөдөлгөөн засал эмчилгээнд хамрагдсан. Иймд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг 7 хоногийн 5 өдөр нэг удаад 1 цагийн хугацаатай хөдөлгөөн засал эмчилгээг spider cage буюу аалзны тор зарчмаар хийсэн. Эмчилгээний өмнө болон дараа нь хөдөлгөөний хөгжлийн шалгуур (GMFM-88), өдөр тутмын үйл ажиллагаа (WeeFIM), GMFCS үнэлгээгээр ангилж үнэлсэн. Уг судалгааг нэг агшны загвараар явуулж, статистик боловсруулалтыг SPSS 25 paired программаар боловсруулсан.

Үр дүн:

Нийт судалгаанд хамрагдсан оролцогчид хөдөлгөөний хөгжлийн шалгуур (GMFM-88) болон өдөр тутмын үйл ажиллагааны үнэлгээ (WeeFIM)-ээр хөдөлгөөн засал эмчилгээний өмнө ба дараа үнэлсэн. Хөдөлгөөн засал эмчилгээний өмнө ба дараах хөдөлгөөний хөгжлийн шалгуурыг харьцуулахад хөдөлгөөн засал эмчилгээний дараа GMFM-88 шалгуур $p < 0,0001$, WeeFIM үнэлгээ $p < 0,0001$ нь статистик ач холбогдол бүхий зөрүүтэй байна.

Хөдөлгөөн засал эмчилгээ хийлгэснээр II түвшний хүүхдүүд GMFM-88 шалгуурын алхах, гүйх ба үсрэх гэсэн хөдөлгөөний чадвар сайжирсан. III, IV түвшний хүүхдүүд GMFM-88 шалгуурын мөлхөх ба өвдөглөх, зогсох, алхах ба гүйх гэсэн хөдөлгөөний чадваруудад хөдөлгөөн сайжирсан бол V түвшний хүүхдүүд хэвтэх ба эргэх, суух гэсэн хөдөлгөөний чадварууд сайжирсан.

GMFCS II, III, IV, V бүлгүүдийн хүүхдүүдийг spider cage буюу аалзны тор зарчмаар хөдөлгөөн засал эмчилгээ хийсний дараах өдөр тутмын үйл ажиллагаа (WeeFIM) үнэлгээний үр дүнг хооронд нь харьцуулахад IV бүлэг бусад түвшний хүүхдүүдээс илүү сайжирсан.

Дүгнэлт

Тархины саатай хүүхдэд **spider cage буюу аалзны тор** эмчилгээний зарчмыг хөдөлгөөн заслын эмчилгээнд хэрэглэх нь ($p < 0.05$) үр дүнтэй байна.

Түлхүүр үг: Бэхэлгээ, тор, хувцас, үнэлгээ, хөдөлгөөний хөгжил

Ашигласан материал:

1. Цагаанхүү Г. Мэдрэл судлал. 2 дахь хэвлэл. Улаанбаатар: Адмон; 2011.х.547-553. 2. Ferriera OM. Cerebral palsy: diagnosing something that is not one thing. Curr Opin Pediatr 1999; 11(6):485-486.
2. Ellenberg JH, Nelson KB. Cluster of perinatal events identifying infants at high risk for death or disability. J Pediatr 1988;113:546-552.
3. Papile L, Munsick-Bruno G, Schaefer A. relationship of cerebral intraventricular hemorrhage and early childhood neurologic handicaps. J Pediatr 1983;103:273-277.
4. Freeman JM, Nelson KB. Special articles: intrapartum asphyxia and cerebral palsy. Pediatrics 1988; 82:240-241.

АНХАН ШАТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙГ ХАМТ ОЛОНД ТҮШИГЛЭН СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ

Б. Батцэрэн¹

¹ “Эрхэмжаргалан” ӨЭМТ-н эрүүл мэндийн нийгмийн ажилтан
erhemjargalan@gmail.com

Үндэслэл:

Сэргээн засалт гэж хөгжлийн бэрхшээлтэй хүний алдагдсан ба хязгаарлагдсан үйлдлийг сэргээх болон хүний бие даасан байдал, бусдаас хамааралгүй байдлыг боломжит дээд хэмжээнд хүргэхийг хэлнэ гэж тусгасан байдаг. Хамт олонд түшиглэсэн сэргээн засах хандлага нь гарал угсаа, арьс өнгө, шашин шүтлэг, нас хүйс, улс төрийн итгэл үнэмшил, эдийн засаг болон нийгмийн байдлаас үл хамааран хөгжлийн бэрхшээлтэй хүний үндсэн хэрэгцээнд нийцүүлэх, ойлголт, ухамсрыг дээшлүүлэх, тэгш хамралтыг дэмжих, эрүүл мэнд, боловсролын хүртээмжийг сайжруулах үндсэн зорилготой. Сэргээн засах тусламж үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулж, бие даах байдлыг нь нэмэгдүүлэхэд тусалдаг. Биеийн нөхөн сэргээлт, хэл ярианы сургалт, туслах хэрэгсэл ашиглах дадлага, сэтгэл зүйн эмчилгээ, нийгмийн ур чадварын сургалт, асран хамгаалагч нарыг чадваржуулах зэрэг орно. Олон нийтэд түшиглэсэн сэргээн засалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдийн амьдралын чанар болон өөрийгөө үнэлэх үнэлэмжид үзүүлэх нөлөөллийн талаар Нигерь улсад хийсэн судалгаагаар хамт олонд түшиглэн сэргээн засах төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрийгөө үнэлэх үнэлэмж, амьдралын чанарт эергээр нөлөөлсөн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын чанар нь гэр бүлийн гишүүдийн амьдралын чанартай хамааралтай байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн даатгалаар гүйцэтгэлээр санхүүжилт авдаг болсонтой холбоотойгоор сэргээн засах тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн боловч нэр төрөл харьцангуй бага байсаар байна. Бүх нийтийн эрүүл мэндийн хамрагдалт, хэнийг ч орхихгүй байх зарчмыг хэрэгжүүлэхэд ахиц гарч байгаа боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэдээлэл авч чадахгүй, эрүүл мэндийн ажилчидтай ойлголцоогүйн улмаас эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ авч чадахгүй тохиолдлууд гарсаар байна.

Судалгааны зорилго:

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамт олонд түшиглэн сэргээн засах тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдсан асуудлыг тодорхойлох.

Судалгааны арга зүй:

Энэхүү судалгааг дескриптив судалгааны агшны загвараар явуулж, мэдээллийг чанарын (ганцаарчилсан ярилцлага) аргаар цуглуулсан. Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлийг компьютерт текст хэлбэрээр бичиж агуулга, утга санаа, ижил төстэй санаа, агуулгын харилцан хамаарал зэргээр нь дугаарлан нэгтгэн дүгнэлт хийж матрицын аргаар мэдээллийг боловсруулсан.

Үр дүн:

Судалгаанд нийт 42 анхан шатны эрүүл мэндийн байгууллага хамрагдсанаас 15 сумын эрүүл мэндийн төв, 27 өрхийн эрүүл мэндийн төв хамрагдсан. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын хувьд сэргээн засах судлалын мэргэжлийн эмчтэй 2,3%, эмчгүй 26%, уламжлалт анагаах ухааны эмч хавсран хийдэг 47,6% байна. Сэргээн засахын мэргэжил эзэмшсэн сувилагч 33%, сэргээн засах тусламж үйлчилгээг хавсран гүйцэтгэж байгаа ерөнхий мэргэжлийн сувилагч 67%-г тус тус эзэлж байна. Хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч ажиллуулдаг өрх, сумын эрүүл мэндийн төв байгаагүй бол сэтгэл зүйч мэргэжил эзэмшсэн ажилтан ажиллуулдаг байгууллага 2 буюу 5% байна. Дохионы хэл мэддэг ажилтан 7% байгаа бөгөөд нийт ажилчдын 0,6% эзэлж байна. Брайл үсэг уншиж чаддаг эрүүл мэндийн ажилтан байхгүй байна. Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн 93% нь сэргээн засахын өрөөтэй бөгөөд 5-12 төрлийн физик эмчилгээний аппаратуудыг тогтмол ажиллуулдаг байна. Сэргээн засах

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

тусламж үйлчилгээ үзүүлэхдээ оношилгооны хэрэгслүүдээс өвдөлтийн үнэлгээг 45% нь хийдэг бол булчингийн тонус, булчингийн хүчийг гараар үнэлэх, үений далайц туузан метрийн аргаар үнэлдэг 4%, үений далайцын гониометрийн үнэлгээ, мэдрэл яс булчингийн тогтолцооны хэвийн өсөлт хөгжлийн үнэлгээ хийдэг 7%, яс булчин тулгуур эрхтний мэдрэхүй, рефлекс, тэнцвэрийн чадварын Боргийн сорил хийдэг 9% тус тус хийдэг байна.

График 1. Сэргээн засах тусламж үйлчилгээнд хэрэглэж буй оношилгооны аргууд



Эмчилгээний дасгалыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын 71% нь хийдэг байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах хэрэгсэл ашиглах заавар, зөвлөгөөг 76% нь өгдөггүй гэж хариулсан байна. Судалгаанд хамрагдсан өрх, сумын эрүүл мэндийн байгууллагууд 100% дулааны эмчилгээ, гэрлийн эмчилгээг хийдэг байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамт олонд түшиглэн сэргээн засах тусламж үйлчилгээг нийт судалгаанд оролцогчдын 33% нь үзүүлдэг, 37% нь үзүүлдэггүй байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гэрийн асаргаа, өдрийн эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт хамруулах, гэрээр үзлэг хийх, эрүүл мэндийн боловсрол олгох зөвлөгөө мэдээлэл өгөх зэрэг үйлчилгээг үзүүлдэг байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамт олонд түшиглэн сэргээн засах тусламж үйлчилгээний тулгамдсан асуудалыг тодруулахад судалгаанд оролцогчдын 67% нь хүний нөөцийн дутагдал гэж хариулсан бөгөөд эдгээр нь сэргээн засахын мэргэжлийн эмч ажилладаггүй, уламжлалт анагаах ухааны эмчтэй боловч амбулаторийн үзлэг хийдэг, сэргээн засах мэргэжлээр нарийн мэргэжил эзэмших, сургалтад хамрагдах боломжгүй зэрэг асуудлууд байна.

Дүгнэлт:

1. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн дутагдалтай байгаа бөгөөд одоо ажиллаж байгаа мэргэжилтнүүдийг сургах шаардлагатай байна.
2. Анхан шатны байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамт олонд түшиглэн сэргээн засах тусламжийг цаашид хөгжүүлэхэд бодлогоор дэмжих шаардлагатай бөгөөд дүүргийн засаг даргын тамгын газар, эрүүл мэндийн төвийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрүүл мэндийн ажилчидтай харилцах, ойлголцох, өөрийн хэрэгцээг эмч мэргэжилтнүүдэд ойлгуулах, нийгмийн амьдралд тэгш оролцох үүднээс эмнэлгийн мэргэжилтнүүдэд дохионы хэл, брайл үсгийн хичээлийг тогтмол явуулах, анагаахын чиглэлээр суралцаж буй оюутнуудад заадаг болох, сайн дурын ажилтнуудыг ажиллуулдаг болох.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хамт олонд түшиглэн сэргээн засах тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

тусламж үйлчилгээ үзүүлэхдээ оношилгооны хэрэгслүүдээс өвдөлтийн үнэлгээг 45% нь хийдэг бол булчингийн тонус, булчингийн хүчийг гараар үнэлэх, үений далайц туузан метрийн аргаар үнэлдэг 4%, үений далайцын гониометрийн үнэлгээ, мэдрэл яс булчингийн тогтолцооны хэвийн өсөлт хөгжлийн үнэлгээ хийдэг 7%, яс булчин тулгуур эрхтний мэдрэхүй, рефлекс, тэнцвэрийн чадварын Боргийн сорил хийдэг 9% тус тус хийдэг байна.

График 1. Сэргээн засах тусламж үйлчилгээнд хэрэглэж буй оношилгооны аргууд



Эмчилгээний дасгалыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын 71% нь хийдэг байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах хэрэгсэл ашиглах заавар, зөвлөгөөг 76% нь өгдөггүй гэж хариулсан байна. Судалгаанд хамрагдсан өрх, сумын эрүүл мэндийн байгууллагууд 100% дулааны эмчилгээ, гэрлийн эмчилгээг хийдэг байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамт олонд түшиглэн сэргээн засах тусламж үйлчилгээг нийт судалгаанд оролцогчдын 33% нь үзүүлдэг, 37% нь үзүүлдэггүй байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гэрийн асаргаа, өдрийн эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт хамруулах, гэрээр үзлэг хийх, эрүүл мэндийн боловсрол олгох зөвлөгөө мэдээлэл өгөх зэрэг үйлчилгээг үзүүлдэг байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамт олонд түшиглэн сэргээн засах тусламж үйлчилгээний тулгамдсан асуудалыг тодруулахад судалгаанд оролцогчдын 67% нь хүний нөөцийн дутагдал гэж хариулсан бөгөөд эдгээр нь сэргээн засахын мэргэжлийн эмч ажилладаггүй, уламжлалт анагаах ухааны эмчтэй боловч амбулаторийн үзлэг хийдэг, сэргээн засах мэргэжлээр нарийн мэргэжил эзэмших, сургалтад хамрагдах боломжгүй зэрэг асуудлууд байна.

Дүгнэлт:

1. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн дутагдалтай байгаа бөгөөд одоо ажиллаж байгаа мэргэжилтнүүдийг сургах шаардлагатай байна.
2. Анхан шатны байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамт олонд түшиглэн сэргээн засах тусламжийг цаашид хөгжүүлэхэд бодлогоор дэмжих шаардлагатай бөгөөд дүүргийн засаг даргын тамгын газар, эрүүл мэндийн төвийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрүүл мэндийн ажилчидтай харилцах, ойлголцох, өөрийн хэрэгцээг эмч мэргэжилтнүүдэд ойлгуулах, нийгмийн амьдралд тэгш оролцох үүднээс эмнэлгийн мэргэжилтнүүдэд дохионы хэл, брайл үсгийн хичээлийг тогтмол явуулах, анагаахын чиглэлээр суралцаж буй оюутнуудад заадаг болох, сайн дурын ажилтнуудыг ажиллуулдаг болох.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хамт олонд түшиглэн сэргээн засах тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ.

ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСАГТ ТАРХИНЫ ЦОЧМОГ ХАРВАЛТТАЙ ЭМЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРТ ҮЕИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ЧАДВАРЫГ ICUMS-ЭЭР ҮНЭЛЭХ НЬ

П.Мөнхжаргал, Т.Мөнхзаяа¹, Х.Ариунаа²

¹Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг,

²АШУУИС, Сувилахуйн сургууль, Бие Бялдар Судлалын Тэнхим

Үндэслэл:

Тархины харвалтын эрт үед хөдөлгөөний чадварыг бие даасан байдлын хэмжүүр, бартелийн индексээр үнэлсэн судалгаанууд элбэг. Эрчимт эмчилгээний тасагт эмчлүүлэх хугацаанд хөдөлгөөний чадварыг үр дүнтэй үнэлж чадах хэмжүүрийг ашиглаж дүн шинжилгээ хийх чухал юм. Тиймээс бид харвалтын цочмог үед эрчимт эмчилгээний тасагт байх хугацаанд хөдөлгөөнд эрт оруулж, хөдөлгөөний чадварт дүн шинжилгээ хийх шаардлагатай байна.

Судалгааны зорилго:

Эрчимт эмчилгээний тасагт тархины цочмог харвалтын үед хөдөлгөөнд эрт оруулсан үр дүнг үнэлэх.

Судалгааны арга зүй:

Энэхүү судалгааг 2023 оны 12 сараас 2024 оны 02 сар хүртэл хөдөлгөөн засал эмчилгээнд (ХЗЭ) хамрагдсан 30 эмчлүүлэгчийн эмчилгээний хуудсыг сонгон авч дүн шинжилгээ хийсэн. Эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлэгчийн ерөнхий мэдээлэлд үүнд: амин үзүүлэлт, ХЗЭ-ний дундаж хоног, ХЗЭ эхэлсэн өдөр, эрчимт эмчилгээний тасгийн хөдөлгөөний чадварын үнэлгээ 0-10 оноо (Intensive care unit mobility scale ICUMS) зэргийг тодорхойлж үр дүнг тооцов. Хөдөлгөөнд эрт оруулсан (1-10 хоног) үр дүнг статистик боловсруулалтыг T paired test ашиглан тооцов.

Үр дүн

Хөдөлгөөн засал эмчилгээнд хамрагдаж эхэлсэн дундаж хоног 2.70(2.78) байв. Хөдөлгөөнд эрт оруулсан байдлыг Intensive care unit mobility scale-р үнэлэхэд эмчилгээний өмнө оноо нь 0.57(0.9) эмчилгээний дараах оноо нь 3.2(2.3) болж нэмэгдсэн. Статистик ач холбогдол бүхий үр дүн ($p < 0.00$) байв (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Статистик үзүүлэлт

Утга	($p < 0.00$)	Эмчилгээний өмнө	Эмчилгээний дараа	P
ICUMS		0.57(0.9)	3.2(2.3)	< 0.00

Дүгнэлт:

Тархины цочмог харвалтын эрт үед (1-10 хоног) хөдөлгөөнд хяналттайгаар оруулах нь хөдөлгөөний чадварыг дээшлүүлж байна.

Түлхүүр үг: Тархины цочмог харвалт, хөдөлгөөн засал эмчилгээ.

Ашигласан материал:

1. Батгэрэл.О (2019). Эрчимт эмчилгээн дэх нотолгоонд суурилсан эрт үеийн сэргээн засах. *Mon.J.Rehabil.Med.Vol9. No.28.*
2. Батгэрэл.О (2011).Сэргээн засах ангаах ухаан сэтгүүл. №1, хуудас 14-17
3. Janne M.Veerbeek & MSc, Gert Kwakkel, PhD (2011). *Early Prediction of Outcome of Activities of Daily Living After Stroke:A Systematic Review. American Heart Association*
4. Claire J.Tipping & Michael J.Bailey (2016). *The ICU Mobility Sclae Has Construct and Predictive Validity and Is Responsive. Ann Am Thorac Soc Vol 13, No6, PP887-893.*

АУТИЗМТАЙ ХҮҮХДИЙГ МОРИН ЭМЧИЛГЭЭГЭЭР СУВИЛАХ НЬ

Ц.Пагма¹, Б.Ууганзаяа²

¹Увс аймгийн Улаангом сумын 5-р цэцэрлэгийн эрхлэгч,

²Арга зүйч

pagma0502@gmail.com

Үндэслэл:

Аутизмтай хүүхдэд яагаад морин эмчилгээ сонгох болсон бэ?

- ✓ Европын холбооны улсуудад туршин хэрэгжүүлсэн үр дүнтэй байгаа нь нотлогдсон.
- ✓ Адуунаас дамжих импульс нь унаач хүүхдийн бүх биеэр дамждаг. Энэ нь юуны түрүүнд адуу сургагчийн адууг сургасан байдал ба эмчилгээний үйлдлийн командаас шууд шалтгаалдаг.
- ✓ Морь нь тэнцвэрийн 3 чиглэлтэй вектортой (урд-арын, дээш-доош, баруун-зүүн) эргэх нь адууны байгалийн био механикаас шалтгаалдаг.
 - ✓ Морины хөдөлгөөний зөв хэв маягийг бий болгох нь тухайн нөхцөлд нэгэн зэрэг дагаж мөрдөх боломжийг бүрдүүлдэг учир энэ үйлчилгээг эхлүүлсэн.

Судалгааны зорилго:

Аутизмтай хүүхдийг морин эмчилгээнд хамруулж, үр дүнг илэрхийлэх.

Судалгааны арга зүй:

Морин эмчилгээний тухай

Бэлтгэл ажлууд: .

1. Адууг сонгох, сургах , бэлтгэх үе:

- Адууны алхалт нь янз бүрийн хэм алдагдалгүй байх, түүний дотор анатомийн согоггүй байх, жишээ нь ташаан толгой хэвийн, доголохгүй, алхалт жигд гэх мэт
- Адууны нас бас чухал, хэт бага насны морь тэнцвэргүй, сул дорой уналга эдэлгээнд гүйцэт ороогүй тул догшин, мөн хөгшин морь алхах уян чанараа алдаж, насжилттай холбоотой булчингийн тогтолцооны асуудлуудтай байх магадлал өндөр, 6-18 хүртэл насны залуу морь тохиромжтой.
- Адууг уналга эдэлгээнд оруулж номхруулж бэлтгэх, хүүхэд аль ч талаас нь очиход үргэж бусгахгүйгээр адууг сургасан байна
- Сургагч багш / цэцэрлэгийн биеийн тамирын багш/, морь сургагч нарын сэтгэл зүй, аюулгүй ажиллагаанд бэлтгэгдсэн байх
- Морины багаж хэрэгсэл, /зөөлөн бариултай олом, хатуу бариултай олом, хавсарсан тохомтой олом, 2 бариултай олом, шилбүүр, хондлой дарагч, хазаар, ногт гэх мэтээр хэрэглэлүүд бэлтгэж, адууг уналгад бэлтгэнэ.
- Бид Увс аймгийн Сагил сумын “Өндөр мод” багийн иргэн аймгийн аварга малчин Санжаагийн 10 настай хээр морь сонгож, морин эмчилгээндээ бэлтгэсэн.

2. Морин эмчилгээ явах тойруулга бэлтгэх

Улаангом сумын төвөөс 6км газар байрлах тэгш гадаргуутай, зүлгэн дээр морин тойруулгаа 300м*200м талбайд гортиглон цэвэр агаарт алхуулах сонголт хийсэн. Биеийн тамирын мэргэжлийн залуу багш нар удирдаж явуулсан.

Морин эмчилгээний үед ямар процесс явагддаг вэ?

Зураг 1. Сувиллын зуслан- морин эмчилгээний зураглал



Морь унах үед 4 хэмжигдэхүүнт тэгш хэмтэй алхалтад түдгэлзүүлэх үе шат байхгүй бөгөөд энэ бол морины хамгийн удаан, тогтвортой алхалт юм. Мориноос унаач хүүхэд рүү импульсийг гажуудахгүй дамжуулахад тохом, бариултай олом зэрэг тохируулга хийх нь чухал.

Үр дүн:

Морин эмчилгээний үр дүн

Хүүхдүүд морин эмчилгээнд орсны дараа булчингийн чангарал суларч тайвширдаг тул зайлшгүй амраах шаардлагатай иймээс гэр цэцэрлэг бариад шим тэжээлтэй хоолоо идээд амардаг. Морин эмчилгээг өдөр бүр 11-12 цагийн хооронд үдээс урагш явуулсан.



Зураг 2. Морин эмчилгээний үед

Аутизмтай хүүхдийг морин эмчилгээнд хамруулсан үр дүн:

- Морин эмчилгээнд ангийн бүх хүүхдийг хамруулсан: Учир нь хүүхэд хүүхдээсээ суралцах, даган баясах, би бас морь унаж болох юм байна гэсэн сэдэл төрүүлэх, хүүхдүүдийн хийж буй үйлдлийг харуулах, дасгах ингэснээр айдас арилах, би бас морь унаж болно гэдэг хүсэл тэмүүлэл төрдөг
- Ижил хувцсаар жигдрэх: Морин эмчилгээний болон зуны сувиллын зуслангийн хүүхдүүдийг ижил хувцсаар жигдрүүлэх нь бусад оролцогчдоос ялгарах боломж олгодог, мөн хүүхдийн нас багадаа 3.5 дээш байх, учир нь морин дээр тогтвортой суухад тохиромжтой байв.
- Цагийн сонголт чухал: Морин эмчилгээнд орсны дараа хүүхэд маш их тайвширч, амраах шаардлагатай тул өдрийн 11-12 цаг хамгийн тохиромжтой, хүүхэд хоолоо идээд амраах боломж гарна.
- Адууны сонголт маш чухал, морин эмчилгээнд адууг сонгож бэлтгэсэн байх шаардлагатай.
- Багш ажилчдын сэтгэл зүйг бэлдэх: Багш, туслах багш, эмч, арга зүйч нарын сэтгэл зүйг засах, морьтой харьцах арга ажиллагааны талаар ойлголт өгч бэлтгэсэн байх.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

- Эцэг эхийн сэтгэл зүйг бэлдэх: энэ бол зугаатай үйл гэхдээ эмчилгээ гэдгийг ойлгуулах, хүүхдийг хоцроохгүй, тасралтгүй явуулах, эрчимжүүлсэн сургалтын бусад үед тасралтгүй явуулж байж үр дүн гарахыг ойлгуулах
- Ганцаарчилсан хөтөлбөр гаргах: Хүүхдийн ажиглалт тэмдэглэл хөтлөх, ахицын талаар мэдээлэл цуглуулах, хувийн хавтас хөтлөх, үр дүнг тооцох
- Сургалтын орчин бүрдүүлэх: Морин эмчилгээний гол үр дүн адууны сонголт, олом, тохомын тохируулга, морин тойруулгын гортиг зайлшгүй шаардлагатай
-

Дүгнэлт:

- Адууны сонголтоос морин эмчилгээний сургалтын чанар шууд шалтгаална.
- Судалгаанд оролцогчид 100 хувийн саналаар сувиллын үйлчилгээг дэмжсэн нь эцэг эх асран хамгаалагч, хүүхдийн хэрэгцээг хангасан гэж үзэж байна.
- Г.О 4 настай эрэгтэй, уйлахдаа хүртэл зовуурьтай уйлдаг, шөнө унтдаггүй инээдэг байсан үзэгдэл бүрэн арилсан нь гэж ээж Батцэцэгтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс харахад зуны сувиллын үйлчилгээний морин эмчилгээний үр дүн гарч байна.
- Морин эмчилгээг бусад нэмэлт үйлчилгээгээр дэмжин цогц байдлаар зохион байгуулсан нь хүүхэд хүүхдээсээ суралцах, хамтарч тоглох, туслах, хайрлах боломж бүрдүүлсэн нь тэгш хамруулан сургах сургалтын зорилготой нийцэлтэй байна.
- АХЭ хүүхэд хэт хөдөлгөөнтэй болох, өөрийнхөө хийж буй үйлийг хянаж чаддаггүй тохиолдол байдаг. Иймээс бусад хүүхдийн дунд хамтдаа үйлдэн суралцуулах, нийгэмшихүйлэх, дасан зохицох, бусдын үйлдлээс даган дуурайж суралцуулах боломж олгох нөхцөлийг бүрдүүлсэн.
- Морин эмчилгээнд орсноор хүүхдийн булчингийн чангарал суларч, биеийн тэнцвэрийн баланс хэвийн болдог ач холбогдолтой, адууг сонгон бэлтгэх туйлын чухал, давтамжтай, тасралтгүй явуулж байж үр дүн илүү гарна.

Түлхүүр үг: Сувилалын зуслан, морин эмчилгээ, эрчимжүүлсэн сургалт.

Ашигласан материал:

1. Вера Дмитриевна Еланская: INVACON.ru, “Инвакон” Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгэмлэгийн байгууллагын удирдагч, ОХУ-ын морин эмчилгээ дасан зохицлын морин спортын холбооны удирдах зөвлөлийн гишүүний илтгэл.
2. Мингалова Маргарита Станиславовна “Өвөр байгалийн хязгаарын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм эрүүл мэндийн сэргээн засах “Росток” төвийн багшийн илтгэл
3. Ирина Вишневская: “Сакт- петербург” ОХУ-ын дасан зохицлын морин спорт, морин эмчилгээний үндэсний холбооны шинжээчдийн зөвлөлийн гишүүний илтгэл.
4. Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмж 2022, 2023 илтгэлийн эмхэтгэл

ТӨРӨЛХИЙН МАЙГА ТАВХАЙН ЭМГЭГИЙН ҮЕД ГӨЛТГӨНӨН БООЛТ БА ИЛЛЭГ МАССАЖ ХИЙСЭН ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Б.Анужин, П.Норовням¹

¹ЭХЭМҮТ, Хүүхдийн эмнэлэг, Сэргээн засах эмчилгээний тасаг
Anujinb354@gmail.com

Үндэслэл:

Майга тавхай (МТ) нь нэг болон хоёр хөлийн тавхай шагайгаар дотогш эргэх төрөлхийн гажиг юм. Дэлхий дахинд 800 амьд төрөлтийн 1-3 тохиолддог. Доод мөчдийн гаж хөгжлийн 40%-ийг МТ эзэлж, түнхний дутуу хөгжлийн 10% МТ хавсарч тохиолддог байна. Энэ гажиг хүүхдийн хөлийн булчин, хальс, холбоос, шөрмөсний багц богиносож, чангарснаар шагайн үений хэлбэр алдагдаж өлмий унжиж, бүтцийн өөрчлөлтөд орсноор тавхайн үйл ажиллагааны алдагдалд хүргэдэг эмгэг юм. МТ нь өдөр тутмын үйл ажиллагаа, амьдралын чанарыг бууруулдаг. Нэг талын майга тавхайн үед 40%, 2 талын үед 60% нь бусад гажгуудтай хавсарсан байна. Олон улсад майга тавхайн үеийн эмчилгээг понсети арга, функциональ эмчилгээний арга, мэс заслын эмчилгээний арга гэсэн эмчилгээний аргууд байна. Понсети арга нь бага насны хүүхдийн майга тавхайг байнгын болон мэс заслын бус аргаар засдаг системчилсэн цуврал гипс болон ортофикс эмчилгээ юм. Функциональ эмчилгээ нь булчингийн кинезис ба шөрмөсний таталтад ажилладаг. Мэс засал нь шөрмөс сулрах, шөрмөс булчинг шилжүүлэхээс гадна остеоартулярын хэв гажилтыг засдаг. Мэс заслын эмчилгээг консерватив эмчилгээг дагалддаг бөгөөд энэ нь үлдэгдэл хэв гажилтыг засах жишиг хэвээр байна. Гэсэн хэдий ч Понсети аргыг функциональ эмчилгээтэй хослуулан хэрэглэснээр илүү сайн үр дүн гарч, мэс заслын хэрэгцээ багасдаг байна.

ЭХЭМҮТ-ийн Тавхай майжгийн сэргээн засах эмчилгээний эмнэлзүйн зааварт эмчилгээнд эмийн ба эмийн бус эмчилгээ, мэс заслын эмчилгээний талаар тусгажээ. Эмийн бус эмчилгээнд гар засал, гар заслын дараах гөлтгөнөн боолт эмчилгээ, гөлтгөнөн боолтыг авах, гутал өмсгөх, иллэг массаж, эмчилгээний дасгал, дулаан эмчилгээ байна. Гөлтгөнөн боолт, сэргээн засах эмчилгээг эрт эхлүүлэх нь хүүхдийг хоёрдогч хүндрэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. ЭХЭМҮТ-д энэ өвчний үед гөлтгөнөн боолт эмчилгээ ба массаж эмчилгээг хавсран хийгдэж байна. Энэхүү хавсарсан эмчилгээ өвчтөний амьдралын чанарт эергээр нөлөөлөх ба эмчилгээний үр дүн илүү сайн байдаг тул бид бүхэн энэхүү судалгааг хийх үндэслэл болов.

Судалгааны зорилго:

Төрөлхийн майга тавхай үед гөлтгөнөн боолт ба иллэг массаж эмчилгээний үр дүнг үнэлэх.

Судалгааны арга зүй:

Судалгааг проспектив судалгааны аргаар хийсэн. ЭХЭМҮТ-ийн сэргээн засах эмчилгээний тасагт майга тавхай оноштой 20 хоногоос-2 сартай 15 хүүхдийг хамруулсан. Эмчилгээний өмнө болон дараа Димеглео үнэлгээний аргын дагуу үнэлж гөлтгөнөн боолт эмчилгээг хийв. Гөлтгөнөн боолт эмчилгээг 7 хоногийн зайтай 1курс нийт 5-10 удаа хийж, гөлтгөнөн боолтыг солих болгонд иллэг массаж хийв. Статистик боловсруулалтыг IBM-SPSS26 программ ашигласан. Тоон хувьсагч хоорондын хамаарлын кореляцийн шинжилгээний аргаар, категори хувьсагчдын хоорондын хамаарлыг хи-квадрат тестийн аргаар хийж гүйцэтгэв. Эмчилгээний өмнөх болон дараах хэмжилтийг үр дүнг рaired тестийн аргаар хийв. Бүлэг хоорондын ялгааг үнэлэхдээ Р утга 0.05-аас бага тохиолдолд статистик ач холбогдол бүхий ялгаатай гэж үнэлэв.

Үр дүн:

Судалгаанд хамрагдагсдын насны дундаж 29.8 ± 11.3 хоног, БЖ-ийн дундаж 3180 ± 270 гр байв. Хүйсийн хувьд 66.7% (n=10) эрэгтэй, 33.3% (n=5) эмэгтэй байв. Димеглео үнэлгээний аргаар эмчилгээний өмнө болон дараа МТ байрлалыг статистик ач холбогдол бүхий ялгаатай байв (p=0.001). Судалгаанд хамрагсдын нас нь ТЖШҮ-байрлал (r=0.704, p=0.0003), ТДХДЭ- байрлалд (r=0.559, p=0.03), ӨД-байрлалд эерэг хүчтэй хамааралтай (r=0.816, p=0.001) байв. ӨДЭМ-байрлалд хамааралтай (r=0.498, p=0.059) байж, харин МТ градус настай харьцуулахад сөрөг хамааралтай (r=-0.736, p=0.002) байв.

Зураг 1. Майга тавхайтай хүүхдэд гөлтгөнөн боолт хийсэн байдал



Дүгнэлт:

Майга тавхайтай хүүхдүүдэд гөлтгөнөн боолт эмчилгээний өмнөх ба дараах байдал нь ач холбогдол бүхий ялгаатай байна. Мөн ТЖШҮ-ӨДЭМ-ТДХДЭ-ӨД үзүүлэлтүүд сайжирсан ач холбогдолтой байна. Демеглио үнэлгээгээр эмчилгээ хийхийн өмнө хөнгөн хэлбэр $n=2$, дунд хэлбэр $n=9$, хүнд хэлбэр $n=4$ байсан бол гөлтгөнөн боолт эмчилгээний дараа үнэлэхэд хөнгөн хэлбэр $n=9$, дунд хэлбэр $n=6$ болж сайжирсан бөгөөд гөлтгөнөн боолт эмчилгээ нь үр дүнтэй байна. Майга тавхайтай хүүхдэд эрт үед гөлтгөнөн боолт эмчилгээ ба массаж эмчилгээг хавсран хийхэд ТЖШҮ байрлал, ӨДЭМ, ТДХДЭ ӨД үзүүлэлтүүд сайжирсан үр дүнтэй байна. Хүүхдийн хөлийн хэлбэр засагдаж, явах чадварт эергээр нөлөөлж байна.

Хэлцэмж: Төрөлхийн майга тавхайг эмчлэхэд мэс заслын бус хоёр арга (Понсети ба Францын функциональ арга) нь мэс заслын хэрэгцээг багасгахад амжилттай байна. Аль ч аргыг хэрэглэснээр өвчтөнүүдийн 95% -д нь хөлний гажиг засах боломжтой байдаг. Дараа нь хаалт (гутал, баар) хэрэглэхэд тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэхийн тулд хэв гажилтыг бүрэн засах нь зайлшгүй шаардлагатай. Зарим өвчтөнд дахилт үүсэж, засаж залруулахын тулд дахин дахин оролдох шаардлагатай болдог. Понсетийн арга нь хөлийг аажмаар засахын тулд хөлийг дараалан цутгаж, дараа нь цутгах аргыг ашигладаг арга юм.

Түлхүүр үг: Майга тавхай, гөлтгөнөн боолт эмчилгээ, иллэг массаж.

Ашигласан материал:

1. Suzanne Steinman et al. A comparison of two nonoperative methods of idiopathic clubfoot correction: the Ponseti method and the French functional (physiotherapy) method. *Surgical technique. J Bone Joint Surg Am.* 2009 Oct 1:91 Suppl 2:299-312. doi: 10.2106/JBJS.I.00369.
2. <https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC9371522/pdf/medi-101-e29910.pdf>
3. Abdoli, A., Dalimi, A., Arbabi, M., Ghaffarifar, F., 2014. Neuropsychiatric manifestations of latent toxoplasmosis on mothers and their offspring. *J. Matern. Fetal Neonatal. Med.* 27, 1368–1374.
4. Adebisi, O.E., Adigun, K.O., Folarin, O.R., Olopade, J.O., Olayemi, F.O., 2020. Administration of *Erythrophleum ivorense* to male Wistar rats alters brain areas involved in motor coordination, behavior and memory. *J. Ethnopharmacol.* 253.
5. Adeyemi, S., Akanji, M.A., Ekanem, J.T., 2012. Ethanolic extract of *Psidium guajava* influences protein and bilirubin levels in *Trypanosoma brucei brucei* infected rats. *J. Bio. Sci.* 12, 111–116.

**ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ СУДАЛСАН НЬ
(ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР)**

Н.Солонго¹

¹Гэрэлт андаган ТББ-ын тэргүүн, Этүгэн их сургуулийн боловсрол судлалын багш, боловсрол судлалын магистр
n.solongo0509@gmail.com

Үндэслэл:

Тэгш хамруулах боловсролын талаар НҮБ-аас гарсан бодлого чиглэл, түүнийг Монгол улсын ерөнхий боловсролын сургуульд авч хэрэгжүүлж байгаа бодлого, тэгш хамруулах боловсролын бодлоготой холбоотой Монгол улсын хэмжээнд хийсэн дээрх судалгааны үр дүн, статистик тоо баримт нь тус судалгааны ажлыг хийх үндэслэл болж байна.

Судалгааны зорилго:

Ерөнхий боловсролын сургуульд хэрэгжиж буй тэгш хамруулах боловсролын бодлогын зарим баримт бичгийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг судлахад оршино.

Судалгааны арга зүй:

Ерөнхий боловсролын сургуульд хэрэгжиж буй тэгш хамруулах боловсролын бодлогын зарим баримт бичгийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг:

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /2016/
- ✓ Боловсролын ерөнхий хууль /2023/
- ✓ Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, боловсруулах аргачлал/ Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2018 оны А/155 дугаар тушаал/
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам/Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаал/
- ✓ Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш, туслах багшид нэмэгдэл хөлс олгох заавар /Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/296 дугаар тушаал/
- ✓ Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр суралцаж буй суралцагчийг үнэлэх чиглэл / Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/325 дугаар тушаал/ зэргийг үндэслэн боловсруулсан.

Үр дүн:

Тус судалгаанд тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлж буй нийслэлийн сургууль, орон нутгийн сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, багш нарын төлөөлөл нийт 50 хүн хамрагдлаа. Хүн ам зүйн цуглуулсан мэдээлэлд боловсруулах боломжгүй алдаатай мэдээлэл байгаагүй.

Дүгнэлт:

1. Энэхүү судалгаанд тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлж буй нийслэлийн сургууль болон орон нутгийн сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, багш нарын төлөөлөл нийт 50 хүн хамрагдлаа.
2. Нийт судалгаанд оролцсон багш нарын 50 хувь нь “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар боловсруулах аргачлал” А/155 дугаар тушаалын талаар маш сайн мэднэ буюу сургалтын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлдэг, 2.6 хувь нь тус журам, зааврын талаар сонсож байгаагүй огт мэдэхгүй байна. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам” А/292 дугаар тушаалын талаар 52.6 хувь нь маш сайн мэднэ сургалтын үйл ажиллагаандаа тусган ажилладаг байна. А/296 дугаар тушаалын талаар судалгаанд хамрагдагчдын 55.3 хувь маш сайн мэднэ сургалтын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлдэг, 7.9 хувь нь сонсож байсан боловч нарийвчлан мэдэхгүй, 2.6 хувь нь тус журмын талаар огт мэдэхгүй гэж үзжээ. Түүнчлэн А/325 дугаар тушаалын талаар 44.7 хувь нь маш сайн мэднэ сургалтын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлдэг, 2.6 хувь нь сонсож байсан боловч нарийвчлан мэдэхгүй, 10.5 хувь нь тус журмын талаар огт мэдэхгүй гэж үзсэн байна. Тиймээс тухайн журам, зааврын талаар мэдлэг, ойлголтгүй байгаа багш нарт энэ ялгаатай хэрэгцээтэй

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

хүүхдийн онцлог хэрэгцээнд тулгуурлан ажиллах, ахицын үнэлгээг хийх чиглэлийн арга зүйн дэмжлэг үзүүлэх онол, дадлага хосолсон сургалтыг зохион байгуулах хэрэгтэй.

2. Судалгааны үр дүнд тулгуурлан тэгш хамруулах боловсролын үйлчилгээ, тогтолцоог сайжруулахын тулд 4 дүгээр бүлэгт дэвшүүлсэн саналын дагуу төрийн захиргааны төв байгууллага, сургуулийн удирдлага, дэмжлэгийн багийнхан үйл ажиллагааны төлөвлөлтдөө тусган ажиллах шаардлагатай.

Түлхүүр үг: Ерөнхий боловсролын сургууль, тэгш хамруулах боловсрол, баримт бичиг.

Ашигласан материал:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/155 дугаар тушаал
2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2018 оны А/425 дугаар тушаал
3. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/249 дүгээр тушаал
4. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/184 дүгээр тушаал
5. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/325 дугаар тушаал
” УБ.,



**V. БҮЛЭГ
ХУУЛЬ,
ЭРХ ЗҮЙ**

ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ КЕЙС /ТОХИОЛДОЛ/ ХЭЛБЭРТ ОРУУЛЖ, АУДИО ТАЙЛБАРТАЙГААР ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ХҮРГЭСЭН ҮР ДҮН

А. Ариунаа, Б. Ахерке, А. Жанерке, М. Мадина, Л. Аззаяа, Ц. Юмчинсүрэн¹

¹ МУИС, Хууль зүйн сургуулийн оюутнууд болон “Legal Vision” төслийн багийн гишүүд

Үндэслэл:

Хүн бүр эрх зүйн этгээд бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс иргэний улс төрийн, нийгмийн, эдийн засгийн, соёлын бүхий л эрхийг алагчлалгүйгээр эдлэх эрхтэй. Монгол Улсын хувьд хууль тогтоомжийг аудио хэлбэрт оруулж, харааны бэрхшээлтэй иргэд болон бусад бүлгийн хүмүүст хүргэхээр зорьж байгаа ч хуулийн хэллэгийн ойлгомжгүй байдал, цахим ур чадварын дутмаг байдал зэргээс үүдэн хүн болгонд тэгш хүрч чадахгүй байна.

Судалгааны зорилго:

Судалгааны зорилго нь харааны бэрхшээлтэй иргэдийн хууль, эрх зүйн мэдээлэл олж авах боломжийг сайжруулахад чиглэгдсэн юм. Тодруулбал, Монгол Улсын хууль тогтоомж болон эрх зүйн мэдээллийг аудио болон кейс хэлбэрт оруулж, харааны бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн хүргэх нь хэрхэн үр дүнтэй болохыг судлах явдал болно.

Судалгааны арга зүй:

Баян-Өлгий, Өвөрхангай, Дорнод аймаг болон Улаанбаатар хотод оршин суудаг 40 гаруй харааны бэрхшээлтэй иргэдээс (сул хараатай, бүрэн хараагүй) танхим, цахим хосолсон хэлбэрээр ярилцлагын арга ашиглан мэдээлэл цуглуулсан. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийг кейс хэлбэрт шилжүүлж, Ц8 дэйзи-ярьдаг таблет ашиглан туршиж, үр дүнг боловсруулсан. Чанарын мэдээллийг дүн шинжилгээнд ашигласан болно.

Үр дүн:

График 1. Харааны бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн мэдлэг олж авах эрх сурвалж




График 2. Харааны бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн мэдлэг олж авах эрх сурвалжийн хүртээмж





График 3. Харааны бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн эрх зүйн мэдээллийг хүргэх хэлбэр



Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо болон түүний дэргэдэх Мэргэжлийн Сургалт Үйлдвэрийн төвийн 21 харааны бэрхшээлтэй иргэдээс судалгаа авч, Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлтэй холбоотой мэдээллийг:


1. Хуулийн аудио хэлбэрийг шууд сонгох.
2. Кейс хэлбэрт оруулан дэйзи-ярьдаг таблет ашиглан хүргэж үр дүнг харьцуулсан.

Судалгааны үр дүнгээс үзэхэд

- Хуулийн заалтын ойлгомжтой байдал: Дундаж оноо 3.65 (5-аас).
- Кейс хэлбэрийн ойлгомжтой байдал: Дундаж оноо 4.4 (5-аас) гарсан нь

Судалгааны үр дүнгээс харахад, хуулийг тойм байдлаар шууд хүргэхээс илүүтэй кейс хэлбэрээр, амьдралтай ойр байдлаар танилцуулах нь илүү ойлгомжтой, үр дүнтэй байна. Иймд харааны бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэхийн тулд кейс хэлбэр бүхий, тэдний онцлогт нийцсэн аудио материалуудыг хөгжүүлэх шаардлагатай гэж үзэв.

График 4. Хуулийн заалт ба кейсийн ойлгомжтой байдлын харьцуулалт



Дүгнэлт:

Монгол Улсын хууль тогтоомжийг аудио хэлбэрээр хүргэх зорилго нь сайн боловч хуулийн хэллэгийн төвөгшил, цахим ур чадварын дутагдал зэрэг саад бэрхшээлүүдээс болж харааны бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг тэгш хүргэхэд хүндрэлтэй байгааг судалгааны үр дүн харуулж байна. Энэ нь Үндсэн хуулиар олгогдсон мэдээлэл олж авах эрхийг хангах шаардлагыг улам тодотгож байна. Судалгаанаас үзэхэд, “Хуулийн зохицуулалтыг кейс хэлбэрээр боловсруулж, Ц8 дэйзи-ярьдаг таблет ашиглан хүргэх” арга нь эдгээр бэрхшээлийг багасгах үр дүнтэй арга зам болох нь батлагдсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

Санал, зөвлөмж:

- Харааны бэрхшээлтэй иргэдэд тохирсон хэлбэрээр мэдээлэл хүргэх: Хууль, эрх зүйн мэдээллийг аудио болон брайль хэлбэрээр хүргэх.
- Тэгш хүртээмжийг хангах: Нийслэл болон хөдөө, орон нутгийн иргэдэд тэгш мэдээлэл хүргэхийн тулд мэдээллийн эх сурвалжийг өргөжүүлэх.
- Кейс хэлбэрийн материал хөгжүүлэх: Харааны бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн кейс хэлбэрийн хялбар, ойлгомжтой материалыг хөгжүүлэх.

Түлхүүр үг: Брайль, дэйзи, эрх, хэрэгцээ, шийдэл

Ашигласан материал:

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний Хөгжлийн ерөнхий газар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний статистик мэдээ - 2022” Үндэсний статистикийн хороо
2. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооны зөвлөмж, 2023 он
3. Монгол Улсын Үндсэн Хууль, 1992
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦДАГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДАДЛАГЫГ ҮР ДҮНТЭЙ БОЛГОХОД ТӨР, НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН ЗОХИЦУУЛАЛТ

М.Ууганцэцэг¹, Б.Лхамсүрэн²

¹Төв аймаг дахь Политехник коллеж, нийгмийн түншлэл, үйлдвэрлэл сургалт хариуцсан арга зүйч, Сургалтын албаны менежер, Арга зүйч

Telmenesuhe10717@gmail.com

Lhamsuren78@gmail.com

d.moogii82@gmail.com

Үндэслэл:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуусыг бусдын нэгэн адилаар боловсрол эзэмших, хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх, тэр дундаа суралцаж буй мэргэжлээрээ онолын мэдлэгийг танхимаар хангалттай олж авдаг ч, үйлдвэрлэлийн дадлага хийх үед тэдэнд тулгардаг асуудлуудыг тодруулах, төгсөөд мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх арга замыг ажил болгон, үр дүнд хүрэхэд хувь нэмэр оруулах зорилгоор энэхүү сэдвийг сонгон судлав. Сүүлийн жилүүдэд Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагыг сонгон суралцан, мэргэжилтэй боловсон хүчин болж улс эх орныхоо хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад гар бие оролцох залуусын тоо тогтмол өсөж байна. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын эцсийн зорилго нь нийгмийн хөгжил, эдийн засгийн бүтээмжийг дэмжих, хөдөлмөрийн зах зээл, ур чадварын эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжлийн ур чадвар бүхий иргэн бэлтгэж, мэргэшлийн түвшин ахиулах, тасралтгүй хөгжих хэрэгцээг хангахад оршино гэж салбарын хуулийн 4-р зүйлд заасан байдаг.

Судалгааны зорилго:

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуус суралцаж, мэргэжил эзэмших, суралцах хугацаандаа бусад суралцагчдын адил үйлдвэрлэлийн дадлагад гарах, төгсөөд мэргэжлээрээ ажиллах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх явцад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, үүнд төр нийгмийн түншлэлийн харилцааны бодлогын зохицуулалтыг нэмэгдүүлэхэд санал дэвшүүлэхэд оршино.

Судалгааны арга зүй:

1. Баримт бичиг боловсруулах арга
2. Асуулгын арга
3. Өмнө хийгдсэн судалгаа, дүн шинжилгээ
4. Математик, статистикийн арга
5. Ярилцлагын арга


Үр дүн:

Судалгааны нэгтгэл:

- 2024 оны байдлаар Монгол улсын хэмжээнд нийт 69 Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс төрийн өмчийн 41, төрийн өмчийн бус 28 байна.
- МБТБ-ын сургалтын байгууллагад суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо


График 1. МСҮТ-дэд сургалтын байгууллагын хэмжээнд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоон судалгаа

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар




2023 оны Мэргэжлийн боловсролд суралцаж хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг сургуулиар нь ангилан харуулбал,

График 2. Суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын сургуулийн харьяалал



Нийт 2023 оны 38294 суралцагчийн 638 суралцагч нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байна. Үүний 281 эмэгтэй, 357 эрэгтэй суралцагч юм. Энэ нь мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа нийт суралцагчдын 1.6 хувийг эзэлж байна.

График 3. МСҮТ-дэд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг бэрхшээлийн төрлөөр нь ангилвал



Хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөрийн чадвартай, тэднийг ажилд авч ажиллуулснаар нийгмийн хариуцлагаа биелүүлээд зогсохгүй ажил олгогчийн урамшуулал, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, тогтвор суурьшилтай ажилчдаар хүний нөөцөө хангах гэх мэт олон боломж, давуу тал байдгийг сурталчлан таниулах, мэдээллийг хүртээмжтэй болгох хэрэгцээ их байна. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн нийгмийн харилцааны боловсрол манай улсад тэр дундаа Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарт амин чухал асуудлын нэг болоод байна. Дээрх судалгаанд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг үйлдвэрлэлийн дадлага хийхэд тулгарч буй асуудлыг дараах байдлаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын тухай хуулийн 6.10 дахь заалт Сургалтын байгууллага нь суралцагчийн ялгаатай хэрэгцээ, ур чадварын түвшинг харгалзан 6.7-д заасан сургалтын хөтөлбөрт тохируулга хийж болно гэсэн заалтыг баримталж ажиллах
2. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг ААНБ дээр үйлдвэрлэлийн дадлага хийх бололцоогоор хангаж ажиллах заалтыг салбарын хуульд тусгах /19-р зүйл/
3. Сургууль бүр үйлдвэрлэлийн дадлагын гурвалсан гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг ААНБ дээр дадлагад гаргах эрхзүйн үндэслэл бүхий заалт оруулах /Төв аймаг дахь ПК сүүлийн 3 жилд ийм байдлаар ажиллаж байгаа/МБТБ-ын салбарын төгсөгчдийн

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

ажил эрхлэлтийн мөшгөх судалгаанд “Хөгжлийн бэрхшээлтэй эсэх”, тийм бол ямар төрлийн бэрхшээлтэй, одоо ямар ажил эрхэлж байгаа зэрэг асуулгуудыг оруулж хөгжлийн бэрхшээлтэй төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг тодорхойлох, дэмжин ажиллах /ТМ 5.1/.

4. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын дунд “Ур чадвар”-н тэмцээнийг зохион байгуулдаг байх

Түлхүүр үг: Хамт олонд түшиглэн хамруулах хөгжүүлэх, нийгмийн хариуцлага, хөдөлмөрийн бүтээмж.

Ашигласан материал:

1. Хөдөлмөрийн тухай хууль 2022,2024 он
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай хууль 2023 он
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ийн конвенц /2006 он/
4. Төв аймгийн статистик мэдээ 2023он
5. Ази номхон далайн бүс нутгийн орнуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн IV конгресс /илтгэлүүд/

ОЛДМОЛ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ, АНХААРАХ АРГА ЗАМ

Б. Оюунсүрэн¹

¹Мандах их сургууль, Эдийн засаг, бизнесийн сургууль, ахлах багш
oyunsuren.b@mandakh.edu.mn

Үндэслэл:

Монгол Улсад 2023 оны байдлаар нийт 115.1 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаагийн 40 хувь нь төрөлхийн, 60 хувь нь олдмол шалтгаантай байна. Мөн 0-18 насны 11.8 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Энэ нь 39.3 хувь нь төрөхөөсөө хөгжлийн бэрхшээлтэй бол үлдсэн 69848 иргэний 55519 нь ердийн өвчний улмаас, 3711 нь мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас, 2830 нь зам тээврийн ослын улмаас, 1411 нь үйлдвэрийн ослын улмаас, 6377 нь ахуйн ослоос шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй болжээ. Хувь хүний санхүүгийн асуудал нь нийгэм эдийн засгийн байдал, оршин суугаа бүс нутаг, тухайн хүний санхүүгийн боловсролоос ихээхэн хамаардаг. Иргэн хүн санхүүгийн хувьд чадамжтай, түүнийгээ зөв зарцуулах, хадгалах, төлөвлөх, хувийн болон өрхийн санхүүгээ оновчтой удирдахад санхүүгийн боловсрол чухал болоод байна. Судалгааны ажилд олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санхүүгийн тулгамдсан асуудлыг тодруулан судлах, улмаар эдгээр иргэдэд чиглэсэн санхүүгийн боловсрол олгох хүртээмжтэй хөтөлбөрийг боловсруулах хэрэгцээ, шаардлага байгааг тодруулан гаргав. Олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд санхүүгийн боловсрол олгох үндсэн хэрэгцээнд тулгуурлан цаашид хэрэгжүүлэх боломжтой хувилбаруудыг дэвшүүлэн гаргахыг оролдлоо.

Зорилго:

Олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санхүүгийн боловсролын тулгамдсан асуудлыг тодруулан судалж, цаашид анхаарах арга замыг тодорхойлоход оршино.

Судалгааны арга зүй:

Судалгааны ажлын хүрээнд олдмол хөгжлийн бэрхшээлтэй 60 иргэдээс асуулгын аргаар 33 асуумжаар, чанарын судалгааны арга, аргачлалд үндэслэн авсан болно. Судалгааны үндсэн арга зүйн хувьд зорилтот бүлгийн иргэдээс санаатай түүвэрлэлт хийж авах нь цаг хугацаа, асуулгын оновчтой байдал, судлаачийн ур чадварыг ихээхэн шаардсан ажил байв.

Асуумж доорх 3 үндсэн хэсгээс бүрдсэн.Үүнд:

- Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээллийг тодруулах асуумж 1-10 дугаартай асуумж-Тухайн судалгаанд оролцогчийн нас хүйсийн бүлэг, боловсролын түвшин, үндсэн захиргаа, хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан ба хувь хэмжээ, амьдарч буй сууцны байдал зэргийг тусгаж өгсөн болно.
- Санхүүгийн өнөөгийн төлөв байдлыг тодруулах асуумж 11-22 дугаартай нийт 12 асуумж-Ажил эрхлэлт, орлого зарлага, орлогын хүрэлцээ, хэмнэлт, санхүүгийн боловсролын мэдлэг байгаа эсэх, санхүүгийн боловсролоо дээшлүүлэх хэрэгцээ бий эсэх, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх асуумжууд авсан болно.
- Санхүүгийн тулгамдсан асуудал ба санхүүгийн боловсролын асуудлуудын талаар үнэлгээ өгөх асуумж 23-32 дугаартай 10 асуумж- Хөдөлмөрийн чадвараа алдсанаас үүссэн санхүүгийн болон бие сэтгэл зүйн асуудал, санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдлэг ба хэрэглээ болон хандлагыг тодруулах асуумжууд оруулан судалгааг авлаа.

Үр дүн:

Судалгаанд олдмол хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэд нь 18-65 насны, 1 жилээс дээш хугацаагаар, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчин, ахуйн ба үйлдвэр, зам тээврийн ослын улмаас зэрэг шалтгаанаар 40-100% хөдөлмөрийн чадвараа алдсан олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байлаа. Судалгаанд оролцогчид нь 100% хөдөлмөрийн чадвартай үедээ 92% нь ажил хөдөлмөр, бизнесийн тогтмол орлоготой байсан бол хөдөлмөрийн чадвараа алдсаны дараа 17,2 % хувь нь тогтмол ажил эрхэлж, 6,9% нь хувийн бизнес эрхэлж байгаа нь санхүүгийн

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

чадамж маш их буурсныг илтгэж байна. Судалгаанд оролцогчдын боловсролын хувьд 44,8% нь бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй, 44,8 % нь бүрэн дунд боловсролтой, 10,4% нь коллежийн буюу техник мэргэжлийн боловсролтой байв. Бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй оролцогчдын 39 % нь санхүүгийн боловсролоо маш сайн ба сайн, 50% нь дунд, 11% нь муу гэсэн үнэлгээг өгсөн байна. Бүрэн дунд боловсролтой оролцогчдын хувьд 15% нь маш сайн ба сайн, 54% нь дунд%, 31% нь муу ба маш муу гэж үнэлсэн нь санхүүгийн мэдлэг **дунд ба түүнээс доош** байгаа нь анхаарах шаардлагатай байгааг харуулж байна. Техник мэргэжлийн боловсролтой иргэдийн хувьд 11% нь сайн, 8% нь дунд, 4% нь муу үлдсэн 77% нь мэдэхгүй байна гэсэн хариулт өгсөн нь санхүүгийн мэдлэгийг зайлшгүй сайжруулах шаардлагатайг илэрхийлж байна.


График 1. Хөдөлмөрийн чадвараа алдсанаас таны санхүүд үүссэн тулгамдсан асуудлууд

Тулгамдаж буй асуудлууд

- **84,5% нь эм эмнэлгийн зардал өссөн**
- 51,7% нь цалин хөлс, тогтмол орлого алдагдсан
- 39,7% нь нэмэлт орлого олох боломж нь багассан
- 13,8% нь хуримтлал буурсан,
- Мөн бизнесийн орлого алдагдсан, даатгалын хувь хэмжээ буурсан гэсэн ба мэдэхгүй байна гэж хариулжээ.

Та хөдөлмөрийн чадвараа алдсанаас таны санхүүд үүссэн бэрхшээлтэй асуудлууд?(чухал гэж үзсэн 2 хариултыг)

58 responses




Дүгнэлт:

Манай улсын хувьд санхүүгийн боловсрол олгох үндэсний хөтөлбөр 2016-2021 хэрэгжиж сургалтыг албан ба албан бус боловсролоор олгож байгаа ч зорилтот бүлгийн хувьд хязгаарлагдмал хүрээнд байсныг илтгэж байв. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээнд таарсан санхүүгийн чадамжийг сайжруулах хөтөлбөр, модулийг тэдний хэрэгцээ шаардлагад тулгуурлан боловсруулж илүү хүртээмжтэй, өгөөжтэй болгоход анхаарах нь зүйтэй юм.

Түлхүүр үг: Хувь хүний санхүү, санхүүгийн боловсрол, санхүүгийн тулгамдсан асуудал, хүчин зүйл, олдмол хөгжлийн бэрхшээл

Ашигласан материал:

1. Монгол Банк (2022). "Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа" судалгааны тайлан.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
3. <http://www.gadpwd.gov.mn/index.php/page/79>
4. Азийн хөгжлийн банк https://www.adb.org/sites/default/files/publication/533481/integrating-persons-disabilities-mongolia-society-mn_0.pdf



**VI. БҮЛЭГ
НИЙГЭМ
ХАМГААЛАЛ**

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН ОРОЛЦОО, ДЭМЖЛЭГ (НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН)

М.Саулегүл¹, Т.Нурболат²

¹Баян-Өлгий Эмпати сургуулийн Түүх нийгмийн ухааны багш, ²Нийгмийн ухааны багш
saulegulmasaa@gmail.com

Үндэслэл:

Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамааруулна. Орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн оролцоо хязгаарлагдмал байгааг нийгэм, эдийн засгийн орчны судалгаанд үндэслэн гаргалаа. Хүүхдүүд оролцоотой байснаар тал бүрээр хөгжих боломж байгааг олон улсын жишээгээр харж болно.

Хүүхдүүд ямар оролцоог хүсдэг вэ?

Өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, Өөрийн чадах зүйлд оролцох, хөгжих, Өөрийгөө таньж мэдэх, үнэлэх, Сонирхож буй зүйлдээ сайн дураараа, ямар нэгэн шахалт дарамтгүйгээр оролцох, Өөрийгөө чадваржуулах, бусдаас суралцах, Найз нөхөд, хамт олонтой байх, Ямар нэгэн ялгаваргүйгээр тэгш оролцох, Аюулгүй байдлаа мэдэрсэн оролцоог туйлаас хүсдэг байна. Хүүхэд оролцсоноор:

Өөртөө итгэлтэй бие хүн болж төлөвшинө, Бусадтай харилцаж, өөрийгөө чөлөөтэй илэрхийлж сурна, Асуудалд өөрийн гэсэн байр сууриас ухамсартай хандаж сурна, Бие даан шийдвэр гаргах чадвар нь сайжирна, Аливаа үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, манлайлах чадвартай болно, Шаардлагатай тохиолдолд өөрийгөө ямар нэгэн эрсдэлээс хамгаалж сурна, Олон талын мэдлэгтэй болж, аливаа зүйлд өөрийн гэсэн дүгнэлт, шийдвэр гаргахад суралцана.

Судалгааны зорилго:

Монгол Улсын Засгийн Газраас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хүүхдүүдийн сурч боловсрох эрхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийв.

Судалгааны арга зүй:

Үндсэн хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль, тогтоомжийн бусад актаас, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал Бодлого, үйл ажиллагаа 2019 зэрэг эх сурвалжуудыг судалж гаргалаа.

Үр дүн:

Практик судалгаанаас авч үзэхэд манай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн өмнө нийгэм, эдийн засгийн оролцоо нэлээд сул байдаг нь харагдаж байна. Тэдний дуу хоолойг сонсох тал дээр манай багш нар, хамгааллын байгууллагууд сул ажиллаж байна уу хэмээх дүгнэлт төрж байна. Эх сурвалжийг нэгтгэн дүгнэж үзэхэд МУ-д байгаа нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд 15000-20000 орчим тооны хувьд хэлбэлзэж байна. Манай орон нутагт гэхэд сургуулийн насны хүүхэд 685 байна. Тэдгээр хүүхдүүд хөгжлийн бэрхшээлтэй гэх тодотголтой бүхий л төрлийн өвчний хавсарсан шинжийг агуулж байна. Төр засгаас 2004 оноос хойш онцгойлон анхаарч янз бүрийн салбарын мэргэжилтүүдтэй хамтраад үйл ажиллагаа явуулж байгаа боловч төдийлөн үр дүнд хүрч чадахгүй байгаа нь харагдаж байна. Салбар бүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжих, оролцох, хамгаалуулах боломжийг хангаж өгөх аваас тэдгээр хүүхдүүдийн амьдрал ахуй сайжрах боломжтой юм.

Хууль эрх зүйн орчныг бид улам боловсронгуй болгомоор байна. Орон нутагт тусгай хэрэгцээт сургууль дор хаяж 2-3-ийг байгуулах шаардлагатай байна. Их дээд сургуульд суралцаж буй багш мэргэжлээр бэлтгэгдэж байгаа оюутнуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг арга зүй, чадвар, мэргэшилд тусгайлан бэлтгэж гаргадаг системийг нэвтрүүлмээр байна.

Сургуульд аливаа уралдаан тэмцээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бэлтгэж

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

тэднийг ч мөн олимпиад, спорт урлагийн арга хэмжээнд тэгш хамруулдаг баймаар байна.

Зөвхөн эрүүл хүүхэдтэй тэр дотроо онц сурдаг цөөхөн сурагчдыг олимпиадад бэлтгэдэг нийтлэг хандлагыг халж багш хүний ур чадварыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоо, хөгжих боломжид анхаарч ажилласан байдлаар үнэлж дүгнэдэг системийг боловсролын тогтолцоо, бодлого, стандартад тусгадаг байх.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээл, оролцоо, дэмжлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрт илрүүлэлт, оношилгоо, хандлага, тэгш хамруулах.

Ашигласан материал:

1. Батцэнгэл.Г (2020). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын сэтгэл зүйн үндэс. Монгол улс, Улаанбаатар хот.
2. Аутизм ба амьдрал (Орч. Н. Ганбаатар; Хян. Ц. Гэрэлтуяа)
3. Нийгмийн ажлын сургалтын төлөвлөгөөнд “Тусгай хэрэгцээт боловсролын хичээлийг “ тусгах нь

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД ЗОНХИЛОН ТОХИОЛДОЖ БУЙ СЭТГЭЛ ХӨДЛӨЛ, ЗАН ҮЙЛИЙН ХЭВ ШИНЖИЙГ СУДЛАХ НЬ

Б.Отгонбаатар, Н.Мөнхзолбоо¹

¹ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв
Otgonbaatar2515@gmail.com

Үндэслэл:

2023 оны статистикийн тоо баримтаар Монгол Улсад 14.600 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэдний гэр бүлийн гишүүдийн сэтгэл зүйн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болох олон хүчин зүйл бий. Тэдний гэр бүлд нь өдөр тутмын амьдралын үйл ажиллагаанд өөрчлөлт орох, дасан зохицох, хүүхдээ асрах, хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ хайх, нийгмээс тусгаарлагдах, ажил хөдөлмөр, эдийн засаг, санхүүгийн байдал зэрэгт хүндрэл үүсэж байдаг. Эдгээр асуудлууд нь хүүхдийн хөгжилд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн нэг болдог. Иймд хүүхдийн хөгжилд саад учруулж болох сэтгэл хөдлөл, зан үйлийн хэв шинжийг урьдчилан судлах, түүнээс сэргийлэх, үр дүнд суурилсан сэтгэл зүйн зөвлөгөө, заслын арга хэрэгслийг ашиглах зайлшгүй шаардлагатай.

Судалгааны зорилго:

Олон улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч нарын сэтгэл зүйн эрүүл мэндэд анхаарах, үнэлэх, нөлөөлж буй хүчин зүйлийг судлах зэрэг ажлуудыг эрчимтэй хийсээр байна. Харин Манай улсад энэ талын эмпирик судалгааны ажил хомс байсаар байна. Иймд бид уг судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зонхилон тулгарч буй сэтгэл зүйн эрүүл мэндийн асуудлуудыг илрүүлэх, хэв шинжийг тодорхойлох зорилготой.

Судалгааны арга зүй:

Уг судалгааны ажилд Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдийн Сэргээн Засах Хөгжлийн төвөөр үйлчлүүлж буй янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй 2-14 насны 60 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчийг хамруулан Сэтгэл хөдлөл зан үйлийн бэрхшээлийг илрүүлэх (SDQ) 2 хэсэг, 6 үзүүлэлтэй 32 асуулгаар судалгааг авсан. Цугларсан мэдээллийн өгөгдлийг SPSS 26 программ ашиглан шинжилгээ хийсэн.

Үр дүн:

Судалгааны үр дүнд хүүхдүүдэд харилцаа, сэтгэл хөдлөл, зан үйлийн бэрхшээл илүүтэй байна. Хүйс болон амьдарч буй газар зүйн байршил зэргээс хамаарсан ялгаа илэрсэн. Мөн бэрхшээлийн нөлөөллийн оноо хотын хүүхдүүдэд илүү өндөр байна.

Хүснэгт 1. Хүүхдийн онош

	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	F84	30	50.0	50.0
	G80	9	15.0	65.0
	R47.8	11	18.3	83.3
	Бусад	10	16.7	100.0
	Total	60	100.0	100.0

Судалгаанд оролцогчдыг бэрхшээлийн төрлөөр ангилан авч үзвэл аутизмын хүрээний эмгэгтэй оролцогч 50% (n-30), Тархины саа, саажилттай судлуулагчид 15% (n-9), Хэл ярианы хөгжлийн хоцрогдолтой 11% (n-11), бусад төрлийн оноштой судлуулагчид 16,7% (n-10) байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

Хүснэгт 2. Эрсдэлийн ерөнхий оноо

ЭЕО

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Эрсдэл бага	1	1.7	1.7	1.7
	Эрсдэл өндөр	59	98.3	98.3	100.0
	Total	60	100.0	100.0	

Судалгаанд оролцогчдын эрсдэлийн ерөнхий оноо өндөр түвшинтэй 98.3% (n-59), эрсдэл багатай 1.7% (n-1) гэсэн үр дүн гарсан байна. Үүнээс дүгнэн авч үзвэл судалгаанд оролцогчдын дунд сэтгэл хөдлөл, зан үйлийн эрсдэлт хүчин зүйлд өртөх магадлал өндөр байгааг харуулж байна.

Хүснэгт 3. Сэтгэлийн хөдөлгөөний илрэл

Сэтгэл_хөдлөлийн_илрэл

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Бага	46	76.7	76.7	76.7
	Дунд	9	15.0	15.0	91.7
	Өндөр	5	8.3	8.3	100.0
	Total	60	100.0	100.0	

Сэтгэл хөдлөлийн илрэлийг авч үзвэл бага түвшинд 76,7% (n-46), дунд түвшинд 15% (n-9), өндөр түвшин 8,3% (n-5) байна. Энэ нь судлуулагчдын хувьд сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадамж сул буюу илэрхийлэх чадамж бага байгааг илтгэж байна.

Хүснэгт 4. Зан төлөвийн илрэл

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Бага	16	26.7	26.7	26.7
	Дунд	11	18.3	18.3	45.0
	Өндөр	33	55.0	55.0	100.0
	Total	60	100.0	100.0	

Дээрх хүснэгтээс авч үзвэл судлуулагчдын зан төлөвийн илрэл өндөр 55% (n-33), дундаж түвшинд 18,3% (n-11), зан төлөвийн илрэл бага түвшинтэй 26,7% (n-16) оролцогч хамрагдсан байна.

Дүгнэлт:

Сэтгэл хөдлөл, зан үйлийн бэрхшээлийн ерөнхий оноо болон үзүүлэлт тус бүрийн оноог судлуулагчдын ерөнхий мэдээлэлтэй харьцуулан статистик шинжилгээг хийсэн ба судалгаанд оролцогчдын эрсдэлийн ерөнхий оноо өндөр түвшинтэй байна. Судлуулагчдын сэтгэл хөдлөл, зан үйлийн бэрхшээлийн ерөнхий үзүүлэлтээр нь харьцуулахад Улаанбаатар болон орон нутгийн хувьд ($U=.102215$, $p=.000$) ялгаатай үзүүлэлт гарсан. Мөн оношноос үл хамааран сэтгэл хөдлөл, зан төлөв, нийцтэй байдлын хувьд дунд болон өндөр түвшний бэрхшээлтэй байна гэсэн судалгааны үр дүн гарсан. Судалгааны үр дүнг нэгтгэн авч үзвэл Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн харилцаа, сэтгэл хөдлөл, зан үйлийн бэрхшээлийг бууруулах, хүүхдийн онцлогт тохирсон сэтгэл зүйн зөвлөгөө, арга аргачлалыг ашиглахаас гадна уг асуудлыг олон нийтэд таниулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээл, сэтгэл хөдлөл, сөрөг зан үйл.

Ашигласан материал:

1. Mellor, D. (2005) *Normative data for the Strengths and Difficulties Questionnaire in Australia. Australian Psychologist*, 40, 215-222.
2. Moriwaki A., Kamio Y. 'Normative data and psychometric properties of the Strengths and Difficulties Questionnaire among Japanese school-aged children.' *Child and Adolescent Psychiatry and Mental Health* 8(1) doi:10.1186/1753-2000-8-1. 2014.
3. Seligman, M., & Darling, B. R. (2007). *Ordinary families, special children (3rd edition)*.
4. <http://familytherapybasics.com/blog/2016/11/26/family-of-origin-exploration-for-the-therapist-create-your-genogram>

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТӨХ ЭРСДЭЛ БА НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, ШИЙДЭЛ

Ч.Дөлгөөн¹

¹Дорнод аймаг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв

Үндэслэл:

Бэлгийн хүчирхийлэл нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх, эрүүл мэндийг ноцтойгоор хөндөж буй асуудал юм. Хэдийгээр хүчирхийллийн эсрэг дуу хоолой нэмэгдэж байгаа ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал орхигдсоор байна. Судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 70%-д бэлгийн боловсролын хомсдолтой, 25%-д бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна (UNFPA, 2021). Энэ нь бэлгийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагыг онцолж байна. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн боловсролын нөхцөл Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 40%-иас илүү нь бэлгийн боловсролын хөтөлбөрт хамрагдаж чадаагүй, 70% нь энэ талаар хангалттай мэдлэггүй байна (UNICEF, 2020). Бэлгийн боловсролын мэдлэг олгох хөтөлбөрүүдийн хомсдол нь тэднийг өөрийгөө хамгаалах чадваргүй, хүчирхийлэлд өртөх эрсдэлд оруулж байна. Хүчирхийлэлд өртөх эрсдэл судалгаанаас үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 30%-иас илүү нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн бөгөөд гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртөх тохиолдол нийтлэг байдаг (WHO, 2018). Мөн тусгай хамгаалалт, тусламж үйлчилгээ авахад хүндрэлтэй байдал тэдний аюулгүй байдлыг улам дордуулдаг.

Судалгааны зорилго:

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн боловсролын нөхцөл, тэдний бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй холбогдсон асуудлуудыг судална.

Судалгааны арга зүй:

Баримт бичгийн судалгаа

Үр дүн:

1. Мэдээлэл болон боловсролын хомсдол

Монгол Улсад бэлгийн боловсролын хөтөлбөрүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан нь байтугай жирийн иргэдэд ч тун ховор зохион байгуулагддаг. Монголын Боловсролын Яам болон Эрүүл Мэндийн Яамны хамтарсан 2017 оны судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 40%-иас илүү нь бэлгийн боловсролын хөтөлбөрт оролцох боломжгүй байсан гэж мэдээлсэн байна. Энэ нь тус бүлгийн хүмүүст зориулсан бэлгийн боловсролын хөтөлбөрүүдэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэгийг харуулж байна.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн болон эмэгтэйчүүдийн эрхийн хязгаарлалт

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 50%-иас илүү нь бэлгийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний талаар ямар ч мэдлэггүй гэж үнэлэгдсэн байна (UNICEF, НҮБ-ын хүүхдийн сан, 2020). Бэлгийн боловсролын хөтөлбөрүүд нь зөвхөн ердийн боловсрол эзэмшсэн хүмүүст чиглэгдсэн байдаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай хөтөлбөрүүдийг нэвтрүүлэх нэн шаардлагатай байгаа нь дээрх үнэлгээнээс харагдана.

3. Хөгжлийн Бэрхшээлтэй Эмэгтэйчүүдийн Бэлгийн Хүчирхийлэлд Өртөх эрсдэл

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр байгаа гэж судалгааны дүнгээс харагддаг. Судалгаагаар, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 30%-иас илүү нь бэлгийн хүчирхийлэлд өртдөг гэж үзэж байгаа нь томоохон асуудал юм (World Health Organization, /ДЭМБ, 2018). Энэ нь Монгол Улсын тухайд ялангуяа тодорхой бэрхшээлтэй хүмүүст тусламж үйлчилгээ, хамгаалалт шаардлагатай байгааг харуулж байна.

4. Зөвшөөрөл өгөх чадвар болон сэтгэл зүйн тусламж

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хувьд бэлгийн зөвшөөрлийн тухай ойлголт, мөн бие махбодийн өөрчлөлт, бэлгийн харилцааны аюулгүй байдлын талаар ердийн хүмүүсийн ойлголт болон хандлагаас тусдаа байдаг. Өнгөрсөн жилүүдэд Монгол Улсад хийсэн судалгаагаар, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 60%-иас илүү нь өөрсдийгөө хамгаалахад шаардлагатай сэтгэл зүйн болон мэдээллийн тусламж авахад хүндрэлтэй байгаагаа илэрхийлсэн (НҮБ-ын салбар эмэгтэйчүүдийн байгууллага, 2021).

5. Нийгмийн тусгаарлалт ба эрхийн хязгаарлалт

Нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн оролцоо нь хязгаарлагдмал бөгөөд тэд олон талаараа тусгаарлагдсан байдаг. Монголд 2023 оны 5 сарын байдлаар 111,228 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагийн 46 хувь нь эмэгтэй хүн байна. Судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 40%-иас илүү нь нийгмийн идэвхтэй оролцоогүй байдаг бөгөөд энэ нь тэднийг хүчирхийлэлд өртөх эрсдэлд оруулдаг гэж дүгнэсэн (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах дэлхийн байгууллага, 2020). Мөн тус бүлгийн хүмүүс хүчирхийлэлд өртсөн тохиолдолд тусламж авах, хохирлоо тайлбарлах, хуулийн хамгаалалт авахад хүндрэлтэй байдаг.

6. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн үед тусламж үйлчилгээний хүртээмж

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 50%-иас илүү нь бэлгийн хүчирхийлэлд өртсөнийхөө дараа тусламж авахад асуудалтай байдгийг судалгаа харуулдаг (National Center for Mental Health, 2019). Тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, тэдний хувийн нууцлал, эрхийг хамгаалах боломжийг олгох нь чухал асуудал юм.

7. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр

2021 онд Монголын Хүчирхийлэлд Өртсөн Эмэгтэйчүүдийн Тусламжийн Төвөөс хийсэн судалгаагаар, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тоо 30%-40% орчим байдаг байна. Судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн: 35% нь гэр бүлд байсан үеийнхээ нөхцөл байдлыг нээлттэй хэлэлцдэггүй, 25% нь хүчирхийлэлд өртсөн ч хууль эрх зүйн тусламж авахад хэцүү гэж үздэг, 60% нь бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг холбож ойлгохгүй, тус тусад нь авч үзсэн байна. Эдгээр үзүүлэлтүүд нь гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийг илрүүлэх, шийдвэрлэхэд мэдээлэл дутагдалтай байгааг харуулж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хамгааллын үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байна.

8. Монгол Улсад бэлгийн боловсрол болон хүчирхийлэлд өртөх эрсдэлд урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн олон нийтийн судалгааны үр дүн

Судалгааны үр дүнгээс харахад 53% нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалахад нийгмийн анхаарал хангалтгүй гэж үзсэн. 40% нь нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хувьд тусгай сургалт, мэдээлэл хэрэгтэй гэж саналаа өгсөн. Эдгээр үзүүлэлтүүд нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд нийгмийн оролцоо дутагддаг, хандлагын өөрчлөлт шаардлагатай байгааг илтгэж байна.

Дүгнэлт:

Шийдэл ба арга хэмжээ

1. Бэлгийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохирсон бэлгийн боловсролын хөтөлбөр зохион байгуулж, орон даяар сургагч багш нарыг бэлтгэх.
 2. Тусгай үйлчилгээ нэвтрүүлэх: Хүчирхийлэлд өртсөн хүмүүст сэтгэл зүйн болон хууль эрх зүйн тусламжийг хүртээмжтэй болгох.
 3. Нийгмийн хандлага, хууль эрх зүйн орчныг өөрчлөх: Нийгмийн оролцоог нэмэгдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг боловсронгуй болгох.
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн боловсролын хомсдол нь хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байгаа нь тулгамдсан асуудал хэвээр байна. Үүнийг шийдвэрлэхийн тулд нийгмийн оролцоог нэмэгдүүлж, тэдэнд чиглэсэн боловсрол, хамгааллын системийг сайжруулах шаардлагатай байна.

Түлхүүр үгс: Бэлгийн боловсрол, хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн эрх.

Ашигласан материал:

1. Эрүүл Мэндийн Яам. (2017). *Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн боловсролын боломж ба хүрээ*. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Д. Энхболд, Ц. Мөнхсайхан. (2018). Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл ба нийгмийн оролцоо. *Монголын сэтгэл судлалын судалгаа*, 10, 45-60.
3. UN Women. (2020). *Ending Violence against Women and Girls with Disabilities: Challenges and Solutions*. New York: UN Women.
4. Ш. Ганзориг. (2019). *Монгол Улс дахь бэлгийн хүчирхийлэл, эрх зүйн хамгаалал*. Монгол Улс, Улаанбаатар хот: Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төв.
5. World Health Organization (WHO). (2020). Disability and Health. *World Health Organization Fact Sheet*. Geneva: WHO.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ТОДОРХОЙЛОХ ҮҮРЭГ БҮХИЙ САЛБАР КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХАД ТЕХНОЛОГИЙН ШИЙДЛИЙГ АШИГЛАХ НЬ

Г.Жаргалмаа, Б.Батхүү¹

¹Хараат Бус Судалгааны Хүрээлэн (IRIM)

jargalmaa@irim.mn

Үндэслэл:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын (ХБХЭМБНХ) төв комисс, түүний харьяаны 21 аймаг, 9 дүүргийн нийт 30 салбар комисс нь хамрах бүсийн хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоож, магадлах гол үүрэгтэй. Салбар комиссоор жилд дунджаар 10,000 орчим хүүхэд материалаа хэлэлцүүлчихдэг бөгөөд эдгээр хүүхдийн ойролцоогоор 25%-д нь “хөгжлийн бэрхшээлтэй” гэсэн шийдвэр гаргаж, эрүүл мэнд, боловсрол, нийгэм хамгааллын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан ажилладаг. Гэвч уг комиссын нэг хязгаарлагдмал тал нь салбар комиссын гишүүд бүгд “орон тооны бус” хэлбэрээр ажилладаг. Тэдний зарцуулж буй цагийг илүү үр ашигтай зарцуулах нь хурлаар орж, шийдвэр гаргуулж буй олон ХБХ-ийн хөгжилд нөлөөтэй учраас уг судалгааг гүйцэтгэж, салбар комиссын үйл ажиллагааны зохион байгуулалтыг хэрхэн илүү үр ашигтай болгох боломжтойг тодруулахыг зорьсон.

Судалгааны зорилго:

Аймаг/дүүргийн салбар комиссын үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, салбар комиссын чиг үүргийг бүрэн бөгөөд үр дүнтэй хэрэгжүүлэхэд технологийн шийдлүүдийг ашиглах боломжуудыг тодруулах нь судалгааны гол зорилго байв. Технологийн боломжит шийдлүүдийг тодорхойлохдоо хэрэгцээнд үндэслэсэн байхыг зорьж, салбар комиссын үйл ажиллагааны аль процесст сайжруулалт шаардлагатай эсэхийг нэгдүгээр шатанд зураглаж, дараагийн шатанд тодорхойлогдсон процессыг сайжруулахад хиймэл оюун ухааныг ашиглаж буй олон улсын туршлагауудыг судаллаа.


Судалгааны арга зүй:

Салбар комиссын үйл ажиллагааны нөхцөл байдлыг тодруулахдаа ХБХЭМБНХ-ийн төв комисс болон нийслэлийн гурван дүүрэг (СХД, ЧД, БЗД), орон нутгийн хоёр аймаг (Баянхонгор, Сэлэнгэ)-ийн салбарын комиссын төлөөллүүдтэй хагас бүтэцлэсэн хэлбэрээр 2024 оны 05 болон 11 саруудад чанарын ярилцлага хийж, технологийн боломжит шийдлүүдийг тодорхойлохдоо баримт бичгийн судалгааны системчилсэн аргыг ашигласан.

Үр дүн:

Төв болон салбар комисс нь 2021 оны 6 сарын 23-ний өдрийн Засгийн газрын 173-р тогтоолоор баталсан “Комиссын дүрэм”-д заасан үүргүүдийг мөрдлөг болгон үйл ажиллагаагаа явуулдаг. Эдгээр үүргийн хэрэгжилт, биелэлтийг тодруулахад салбар комиссын “хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, байнгын асаргаанд байх хугацааг сунгах, цуцлах шийдвэр гаргах” үүрэг хамгийн сайн хэрэгжилттэй (ойролцоогоор 1 сард гишүүдийн комиссын ажилд зарцуулж буй цагийн 60%-ийг эзэлнэ), харин тодорхойлсны дараа хүүхдийг хөгжүүлэх, хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийн биелэлт хамгийн сул (ойролцоогоор 1 сард комиссын ажилд зарцуулж буй цагийн 10% хүрэхгүйг эзэлнэ) байна. Хурлаар нэг хүүхдийн кейсийг шийдвэрлэхэд Дүрс 3-д харуулсан 6-10 алхамтай процессыг дамждаг. Эдгээр процесс дундаас үр дүн, үр ашигтай байдлын хувьд хамгийн сул явагдаж байгаа нь Алхам 5 болон 6 байна.

Схем 1. Салбар комиссын үйл ажиллагааны процесс, алхамтаар



Алхам 5. ХБХ-д шаардлагатай хөгжлийн дэмжлэгүүдийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих (Үр дүнтэй байдал сул): Салбар комисс нь хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлсны дараа эрүүл мэнд, боловсрол, нийгэм хамгааллын хөгжлийн цогц төлөвлөгөөг боловсруулж, эцэг эхэд танилцуулж зөвлөгөө өгөх, холбогдох байгууллагуудад мэдээлэх, уг төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих үүрэгтэй. Гэвч талуудтай хийсэн ярилцлагаар комиссын дүгнэлт, акт дээр маш ерөнхий дэмжлэгүүдийг тодорхойлж, зөвхөн эцэг эхэд уг төлөвлөгөөг хүлээлгэн өгдөг, ямар нэг дагасан холбон зуучлал, хяналт тавих ажлууд бага явагддаг байна. Ярилцлагаар мөн хөгжлийн төлөвлөгөөг хүүхэд бүрийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн байдлаар нарийн боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих системтэй арга дутмаг, ажлын ачааллаас шалтгаалж цаг зарцуулах боломж бага, хүүхэд бүрийн онцлогт тохирсон нарийвчилсан төлөвлөгөө гаргах чадавх харилцан адилгүй байгааг бүх талууд онцолж байв.

Боломжит шийдэл. Хиймэл оюун ухаан (AI)-д суурилж ХБХ-ийн хөгжлийн цогц төлөвлөгөөний саналыг боловсруулах: Салбар комиссын шийдвэрт үндэслэн хүүхдийн нас, хүйс, хөгжлийн онцлог, онош, чадвар алдалтын түвшин, хөгжлийн ерөнхий шинж тэмдэг, тусгай хэрэгцээ зэрэг ерөнхий мэдээллүүдийг AI-д суурилсан хэрэглэгдэхүүн (tool)-д оруулж, тухайн хүүхдэд зориулсан анхан шатны “Хөгжлийн төлөвлөгөө”-ний саналыг маш богино хугацаанд боловсруулах боломжтой. Энэ төрлийн жишиг түүлүүд гэвэл [MagicSchool.ai](#), [Rethink Ed](#), [Cognoa](#), [Easy-peasy.AI](#), [IEP Co-pilot](#) платформуудыг дурдаж болно. Салбар комиссын чиг үүргийн хэрэгжилтэд дэмжлэг болохын тулд энэ төрлийн хэрэглэгдэхүүнийг хөгжүүлэх/тохируулга хийхэд дараах зүйлсийг анхаарч, уялдуулах нь чухал. Үүнд:

- Монгол Улсад мөрдөгдөж буй хууль, журмууд, түүнийг хэрэгжүүлэх үүрэг бүхий тогтолцоо, хүчин төгөлдөр үйлчилгээнүүдтэй уялдуулах,
- Үйлчилгээ авах боломжит байгууллагууд, ТББ, аймаг/дүүргийн харьяалал бүхий байгууллага, нэгжүүдийн мэдээллийг оруулах,
- Хөгжлийн бэрхшээлийн төрөл нэг бүрийн онцлог, үүнээс үүдэлтэй өмнөх хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн хүүхдүүдийг туршлагуудыг харгалзах,
- Өгөгдөлд үндэслэн боловсруулсан төлөвлөгөөний саналыг мэргэжилтнүүд, эцэг эхийн санал зэрэгт үндэслэн өөрчлөх, сайжруулах уян хатан орон зайг үлдээх зэрэг болно.

Алхам 6. Кейсийн бүртгэл, хөтлөлт, тайлагнал (Үр ашигтай байдал сул): Шийдвэрлэгдсэн кейсийг бүртгэх, хүүхдийн хувийн хэрэг хөтлөх, нийт хүүхдийн бүртгэлийг хөтлөх, хурлаар орсон хүүхдүүд болон комиссын хурлын ирц, урамшууллын тооцоолол зэргийг багтаасан улирлын тайлан мэдээг бэлтгэж илгээх процесст цаасан ажилбар, механик ажиллагаа их ордог. ХБХ-ийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем ашиглалтад орж жигдрээгүйтэй холбоотойгоор тайлан мэдээг цаасаар бэлтгэн, шуудангаар Төв комисст хүргүүлэх, хүүхдийн бүртгэлийг гараар цаасан дээр, экселээр хөтлөх зэргээр нэгдсэн системгүйгээс үүдэлтэй.

Боломжит шийдэл. Салбар дундын өгөгдөл мэдээллийн нэгдсэн сан: Олон улсад CPIMS+ with Primero (Africa, Asia, and Latin America), Integrated Children’s System (ICS in United Kingdom), Ed-Fi Data Standard (United States), Integrated Case Management Systems (ICM in Canada) зэрэг системүүд нь боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хамгааллын байгууллагуудын

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

мэдээллийн датабаазыг интеграцлаж, хүүхдийн мэдээллийг цогцоор авах, хөгжлийн дэмжлэг, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хооронд нь уялдуулахад ихээхэн ач холбогдолтой туршлагаудад тооцогдож байна.

Салбар комиссын хэрэглээнд уг дундын санг нийцүүлэхийн тулд:

- **Холбогдох яамдууд болон төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэх:** Боловсрол, Эрүүл мэнд, Гэр бүл, Хөдөлмөр Нийгмийн хамгааллын яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг байгууллагын мэдээллийн санг нэгдсэн платформд холбож, регистрийн бүртгэлээр дамжуулан тухайн хүүхдийн авсан бүх үйлчилгээг, түүх үүсгэн хянах боломжтой байхаар хөгжүүлж болно.
- **Олон талт хэрэглэгчийн тохиргоог хийх:** Холбогдох үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагууд (цэцэрлэг, сургууль, эмнэлэг, халамжийн байгууллагууд г.м) тодорхой эрхээр хандаж өөрийн харьяаллын хүүхдүүдийн мэдээллийг авах, оруулах боломжтой байх, мөн бүр ахисан түвшинд бол эцэг эхчүүд өөрсдийн хүүхдийн мэдээллээ нэгдсэн системээс харах, хянах боломжтой байхаар платформ хэлбэрээр хөгжүүлэх боломжтой.

Дүгнэлт:

Төв болон анхны салбарууд комиссууд 2016 оноос эхлэн байгуулагдаж, өдгөө 8 жилийн хугацаанд институцлэлийн хувьд тодорхой түвшинд хүрч, үйл ажиллагаа нь жигдэрчээ. Тухайлбал, хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, байнгын асаргаанд байх хугацааг сунгах, цуцлах шийдвэр гаргах тал дээр салбар комиссууд харьцангуй чадавхажсан, холбогдох чиг үүргээ сайн биелүүлж байна. Харин цаашдаа, хөгжлийн бэрхшээлтэй болох нь нэгэнт тогтоогдсон хүүхдүүдийн “хөгжлийн төлөвлөгөө”-г гаргах, хүргэх талаас нь процессыг сайжруулах, үүнд хиймэл оюун ухаанд суурилсан хэрэглэгдэхүүн ашиглах боломжтойг онцлов. Мөн кейсийн бүртгэл, хөтлөлт, тайлагнал зэрэг механикаар хийж, цаг их авдаг, үр ашиг багатай ажлуудыг салбар дундын өгөгдлийн нэгдсэн сан нэвтрүүлэх замаар шийдвэрлэх зэрэг практик шийдлүүдийг энэхүү өгүүлэлд онцоллоо.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, салбар комисс, тодорхойлох процесс, хөгжлийн төлөвлөгөө, технологийн дэвшилтэт шийдэл.

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/220, А/475, А/812 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм, Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолын хавсралт
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, Нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэрийн маягт, Салбар комиссын хуралдаанд орсон хүүхдийн бүртгэлийн дэвтэр, Хүүхдийн хувийн хэргийн маягт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/220, А/475, А/812 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт
4. Cook, J., Baule, S. (2024, August 2). Leveraging AI to help special education teachers. eSchool News. Retrieved November 14, 2024, from <https://www.eschoolnews.com/digital-learning/2024/08/02/leveraging-ai-to-help-special-education-teachers/>
5. Almufareh, M. F., Kausar, S., Humayun, M., & Tehsin, S. (2024). A conceptual model for inclusive technology: advancing disability inclusion through artificial intelligence. Journal of Disability Research, 3(1), 20230060.

АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ ЭМГЭГТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХ ЗӨРЧИГДӨЖ БАЙГАА ТУХАЙ

М. Гэрэлмаа¹

¹ Дотоод хэргийн их сургууль, Эрх зүй, нийгмийн ухааны сургууль
munhbagerelmaa4@gmail.com

Үндэслэл:

Аутизмын шалтгааныг одоо хүртэл шинжлэх ухаан олж нээгээгүй байгаа бөгөөд тархины үйл ажиллагааны тодорхой нэг саатлын улмаас үүдэлтэй гэдэг дээр эрдэмтэд судалгаа шинжилгээ хийсээр байна. Шалтгаан нь тодорхойгүй байгаа тул эмчлэх, эдгээх, засах, хэвийн болгох гэсэн ойлголтын талаар одоо ярихад эрт байгаа гэдэгтэй маргах аргагүй. Тархины үйл ажиллагаатай холбоотой тархины хөгжилд нөлөөлдөг биологийн шалтгаантай учраас аутизмтай хүн насан туршдаа аутизмтай хэвээр байна. Гэвч энэ нь нийгмээс салган тусгаарлах шалтгаан болохгүй. Хүмүүс энэ талын мэдлэг мэдээлэл дутмаг байдгаас шалтгаалаад тэдний биднээс өөр байгааг хүлээн зөвшөөрч чадахгүй нийгмээс тусгаарлаж ялгаварлан гадуурхах үзэгдэл байсаар байгаа нь маш харамсалтай зүйл. Монгол улсын Үндсэн хуульд “хүн бүр эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй” гэж заасан миний бодлоор энэ нь орчин тойрон гэх ойлголтод зөвхөн барилга байгууламж зэрэг бус хүмүүс бид өөрсдөө бие биеийхээ орчин болж байдаг гэж бодож байна.

Судалгааны зорилго:

Аутизмтай иргэн ч гэсэн Монгол улсын иргэн тиймээс бусадтай л адил суурь эрхүүдийг нь эдлүүлэх боломж бололцоог бий болгохыг хүмүүст уриалах зорилгоор судалгааг хийв.

Судалгааны арга зүй:

Аутизмын тухай судалгааны тайлан, илтгэлүүд, нийгмийн сошиал медиа орчны мэдээллүүдэд агуулгын шинжилгээ хийн үр дүнг боловсруулав.

Үр дүн:

1. ЕБС-ийн хичээлийн системд аутизмын тухай таниулах зорилго бүхий хичээл оруулах хэрэгтэй. Яагаад гэвэл насан туршийн хүмүүжлийг бага насандаа авдаг тул хүүхдийг багаас нь хэн нэгний ялгаатай байдлыг хүндэлдэг болгож төлөвшүүлэх нь зүйтэй.
2. Аутизмтай хүүхдүүдэд эмчилгээ оношилгоо хийх орчинд анхаарал хандуулах хэрэгтэй. Аутизм нь бүрэн эдгэдэггүй ч гэсэн эмчилгээ хийснээр шинж тэмдэг багасах боломжтой байдаг.
3. Эцэг, эхчүүдэд аутизмын шинж тэмдгийн талаар таниулга хийж, эрт оношилж зөв харилцах боломжийг нэмэгдүүлэх.
4. Багш нарын боловсон хүчийг бэлдэхдээ мөн аутизмтай хүүхэдтэй харилцах арга зүй, тэднийг дэмжих арга зүйг эзэмшүүлдэг байх хэрэгтэй.
5. Нийгэмд зөв ойлголт түгээх ажлыг шат дараалалтай, үргэлжилсэн шинжтэй зохион байгуулах.
6. Аутизмтай хүүхдүүдийг энгийн сургуульд явуулж нийгмийн нэг хэсэг болгох ажиллагааг зохион байгуулах.
7. Сэтгэл зүйчид эцэг эх, хүүхдэд туслалцаа үзүүлэх тал дээр хөнгөлөлттэй хандах. Аутизм нь нийгмийн бүлгээр нь ялгагдаггүй тохиолддог тул сэтгэл зүйн зөвлөгөө авахад эдийн засгийн хувьд хүндрэлтэй гэр бүл ч гэсэн байгаа юм.

Дүгнэлт:

Аутизмын эмгэгтэй хүмүүс яг л тантай адил хүн гэдгийг ойлгож, хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тэдний онцлогийг ойлгох газар тун ховор байна. Иймээс гадуур гарч чадахгүй, сургаж чадахгүй, нийгмийн бүхий л харилцаанд орох эрхээ эдэлж чадахгүй байдалд байгаа олон хүмүүс байсаар байна. Аутизмтай хүүхэдтэйгээ эцэг, эхчүүд эмнэлгээр явахаар айдастай байдаг гэж хэлдэг. Нийгмийн бодит байдал ийм л байгаа. Хүмүүс ойлголтоо нэмэгдүүлэх шаардлагатай байна. Жишээ нь, тэргэнцэртэй хүнийг хараад хажууд нь заавал хүн байх хэрэгтэй гэж ойлгодог. Тэгтэл оюуны бэрхшээлтэй аутизмтай хүүхдүүдийг гаднаас нь хараад ялгарахгүй учир дэлгүүрт орилох ч юм уу, уйлахаар “Ёо ямар ядаргаатай юм”, “хүүхдэд халдчихвий дээ гээд хүүхдээс хол бай” гэх мэт харгис хэрцгийгээр төвөгшөөсөн хандлага маш их гаргадаг байна. Тэр хүүхдийн гаргаж

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

буй үйлдэл бусдын нүдээр зохисгүй харагдаж болно. Гэвч бусдад өөрийгөө ойлгуулахад тухайн үйлдэл нь цор ганц харьцах хэрэгсэл байдаг талаар хэн ч мэддэггүй, яг үнэндээ мэдэхийг ч хүсдэггүй байх.

Нийгмийн хандлага эцэг, эх хүүхдэд маш хэцүү байдаг. Аутизмтай хүүхэдтэй нэгэн ээж өгсөн ярилцлагадаа “Би өөрийнхөө төрүүлсэн хүүхдээс ичдэггүй, үнэндээ хааяа шантардаг, гэхдээ хүмүүс миний хүүхдийг гадуурхаж, муухай харьцахыг харах л хамгийн хэцүү санагддаг” гэсэн байсан. Эцэг, эхийн хамгийн ойрын хүнээс ч ирэх дарамт их байдаг. Тэгэхээр энэ хүүхэд уйлж, орилоод байгаа нь учиртай гэдгийг ойлгох хэрэгтэй. Аутизмтай хүүхдүүд гэдэг “Хэл ярианы хоцрогдолтой, нийгэмд биеэ авч явахдаа дутагдалтай бас давтагдмал үйлдэл хийгээд байдаг юм байна” гэдгийг мэдчихвэл хүмүүсийн ойлголт өөр болно. Ангид нь аутизмтай хүүхдүүд байвал “Миний хүү тусалж байгаарай” гэж бусад эцэг, эхчүүд үр хүүхдэдээ хэлж, ойлгуулж энэ талын мэдлэг мэдээллийг хүүхэд багачууддаа ойлгуулж сурган хүмүүжүүлэх нь эдгээр аутизмын хүрээний эмгэгтэй хүмүүсийн амьдрах нөхцөл сайжрахад томоохон нөлөөтэй юм. Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлд “Монгол улсын иргэн нь эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй” хэмээн заасан байдаг. Орчин гэдэгт зөвхөн хүрээлэн буй орчин буюу байгаль биш юм. Нийгэм хүмүүсээс бүрддэг, тиймээс хүмүүс өөрсдөө мөн адил бие биеийнхээ хүрээлэн буй орчин юм. Тиймээс хүн бүр өөрөөсөө эхлэн харах өнцгөө өөрчилж аутизмтай хүмүүсийн амьдарч чадах эрүүл аюулгүй орчин нь болж төлөвших хэрэгтэй байгаа юм. Тэд ч гэсэн бусад шиг л энгийн байхыг хүссэн, тэд бусдаас өөр байгаад хэн ч буруугүй гэтэл бид өдөр тутамдаа харцаараа л тэднийг эцэг эхтэй нь хамт яллаж байна. Хүнийг хүн чигээр нь хүлээн авдаг, хүний ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрдөг сэтгэл зүйн дархлаатай ард түмэн байх нь Ардчилсан нийгмийн гол шинж гэж бодож байна.

Түлхүүр үг: Аутизмын хүрээний эмгэг, харах өнцөг, ялгаварлан гадуурхалт, хүний эрх, нийгмийн оролцоо.

Ашигласан материал:

1. *Монгол улсын Үндсэн хууль 1992 он*
2. *Аутизмын тухай гарын авлага 2019 он*
3. *Монголын аутизмын холбооны нийтлэл*
4. *Аутизмын хүрээний бэрхшээлийн тухай ойлголт 2018 он*
5. *Сэтгэл судлаач: С.Уранбилэг-ийн нийтлэл*

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ТУСЛАХ АЖИЛТНЫГ БЭЛТГЭЖ БҮЙ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА (ӨРНӨ, ДОРНЫН 8-Н УЛСЫН ЖИШЭЭН ДЭЭР)

Б.Саранзаяа¹, Г.Лхам²

¹МУБИС-ТХБ-ын тэнхимийн багш

²Түгээмэл хөгжил төвийн туслах ажилтан МУБИС-ТНУБ-ийн 3-р дамжааны оюутан
saranzaya.b@msue.edu.mn

Үндэслэл:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд олон улсын туршлагад суурилсан сургалтын хөтөлбөр, арга зүйт Монгол Улсад боловсруулах шаардлагатай. Судалгаа нь тусламжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, ажилтнуудын нийгмийн баталгаа, ажлын нөхцөлийг хангах санал, зөвлөмж гаргахад чиглэгдэнэ.

Судалгааны зорилго:

Энэхүү судалгаа нь олон улсын туршлагад тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах мэргэшсэн ажилтнуудыг бэлтгэх сургалтын хөтөлбөр, арга зүйн сайн туршлагыг Монгол улсын өнөөгийн нөхцөл байдалтай харьцуулан судлахад чиглэгдсэн.

Судалгааны арга зүй:

Олон улсын туршлага, баримт бичгийн шинжилгээ, чанарын болон тоон судалгаа, кейс судалгаанд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах ажилтнуудын сургалтын арга зүй, стандарт, загварыг Монгол Улсад хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох.

Үр дүн:

Хүснэгт 1. Улс орнуудад ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах ажилтны тоон үзүүлэлт

Улс,	Туслах ажилтны тоо (ойролцоо),	Тайлбар
АНУ	1.2 сая	Гэрийн тусламж, асрамжийн төв, боловсролын салбар дахь туслах ажилтнууд
Герман	600,000	Нийгмийн халамж, эрүүл мэнд, боловсролын салбар дахь туслах ажилтнууд
Франц	500,000	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхдүүдэд туслах ажилтнууд
Австрали	250,000	National Disability Insurance Scheme (NDIS)-ийн хүрээнд ажилладаг ажилтнууд
Канад	400,000	Нийгмийн халамж, эрүүл мэнд, боловсролын салбарт ажилладаг туслах ажилтнууд
Япон	500,000	Асрамжийн төв, гэрийн үйлчилгээ, нийгмийн халамжийн салбарт ажилладаг
Солонгос	200,000	Эрүүл мэнд, нийгмийн халамжийн төвүүдэд ажилладаг
Норвеги	60,000	Хүн амын тоотой харьцуулахад туслах ажилтны хангалттай тоотой




График 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах ажилтны нэг цагийн дундаж цалинг (Монгол төгрөгт шилжүүлсэн) улс орнуудаар харьцуулсан байдал. Энэхүү графикаас тухайн орны амьжиргааны өртөг, эдийн засгийн нөхцөлөөс хамааран цалин хөлсний ялгааг харж болно.

Монгол Улсын хувьд: [Түгээмэл хөгжлийн төв /Universal Progress/](#) үйл

ажиллагааны чиглэл: хөгжлийн бэрхшээл. Өөрийн хувийн туршлага 2024 оны 10/8-10/31 хүртэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

нийт 65 цаг ажиллахад 455.000 төгрөг авсан. Нэг цагийн хөлс 7000 төгрөг байдаг.




График 2. Туслах ажилтнуудын насны дундаж үзүүлэлтийг улс орнуудаар харуулсан байдал. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах ажилтнуудын нас харилцан адилгүй бөгөөд тухайн улсын хөдөлмөрийн зах зээлийн онцлогоос хамаарч байна.




График 3. Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүнд туслах ажилтнуудын насны түвшнийг шугаман графикаар үзүүлэхэд голчлон 25-45 насны хүмүүс зонхилж байна. Энэ насны бүлэг нь ихэнх тохиолдолд туслах ажилтнуудын ажилд оролцох боломжтой, эрч хүчтэй, мэдлэг ойлголттой байна. Харин 45 наснаас дээш насныхан мөн оролцох боловч тэдний оролцоо харьцангуй бага байдаг. Энэхүү график нь туслах ажилтнуудын насны хуваарилалтыг ойролцоогоор илэрхийлэх бөгөөд тухайн салбарын байдал, шаардлагаас хамааран өөрчлөгдөж болно.

Хүснэгт 2. Улс орнуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах ажилтнуудыг бэлтгэж буй байдлын ижил ба ялгаатай талууд

Улс	Бэлтгэх арга	Давуу тал	Ижил тал
АНУ	Коллеж их сургуулийн мэргэжлийн сургалт гэрчилгээний хөтөлбөр	Олон төрлийн мэргэжлийн ур чадвар эзэмших боломжтой; олон салбарт ажиллах боломж	Мэргэжлийн сургалтад суурилсан, олон шатны гэрчилгээ шаарддаг
Герман	Тусгай мэргэжлийн сургалт (Ausbildung), нийгмийн халамжийн байгууллагад дадлага	Системчилсэн, практик туршлагаар баялаг	Сургалтад суурилсан, нарийн хяналт, шалгалттай
Франц	Коллеж, мэргэжлийн сургуулиуд, нийгмийн ажилтны сургалт	Хүний эрх, тэгш байдлын хичээлүүд түлхүү орсон	Сургалтын стандартчилал өндөр, боловсролын байгууллагад түшиглэсэн
Австрали	Коллеж, мэргэжлийн байгууллагын гэрчилгээний хөтөлбөр (TAFE)	Хувийн болон төрийн байгууллагуудад олон төрлийн хөтөлбөртэй	Гэрчилгээний түвшинтэй, ажил дээрээ дадлага хийх шаардлагатай
Канад	Коллеж, гэрчилгээ, байнгын дадлага	Ажлын байр, эрүүл мэндийн үйлчилгээний төвүүдэд ажиллах боломжтой	Олон шатлалтай боловсрол, гэрчилгээ шаардлагатай
Япон	Их сургууль, тусгай мэргэжлийн сургуулийн хөтөлбөр	Өндөр дээд сургуульд суурилсан, мэргэжлийн нарийн бэлтгэлтэй	Стандарт хичээлийн хөтөлбөртэй, нийгмийн оролцоо өндөр шаарддаг
Солонгос	Их сургууль, мэргэжлийн сургалтын төвүүдийн сургалт	Боловсрол, мэргэжлийн сургалт хосолсон,	Мэргэшүүлэх хөтөлбөртэй, олон шатлалтай сургалт
Норвеги	Коллеж, мэргэжлийн боловсролын байгууллага,	Хүний эрх, тэгш байдал, нийгмийн сайн сайхны сургалттай	Гэрчилгээ шаардлагатай, мэргэшсэн байдлын өндөр шаардлагатай

Дээрхээс үзэхэд бүх улс оронд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах ажилтнуудыг олон шатлалтай мэргэжлийн сургалтаар бэлтгэж, сертификат шаарддаг нийтлэг талтай. Харин сургалтын хөтөлбөр, арга барил, бодлого, санхүүжилт, практик дадлагын боломж зэрэг нь улс орнуудын хэрэгцээ, нөхцөлд тохируулан ялгаатай байдаг.

Дүгнэлт:

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах ажилтнуудыг олон шатлалтай, мэргэжлийн сургалтаар бэлтгэх, санхүүгийн болон нийгмийн дэмжлэгийг өргөжүүлэх шаардлагатай. Австралийн NDIS хөтөлбөрийн адил хувь хүний хэрэгцээнд тулгуурласан санхүүжилт, Японы тусгай мэргэжлийн боловсрол, АНУ-ын гэрчилгээний шаталсан системийг нэвтрүүлэх боломжтой бөгөөд Германы практик дадлагын хөтөлбөр, Норвегийн цогц халамжийн загварыг нутагшуулах нь чухал ач холбогдолтой. Эдгээрийг хэрэгжүүлснээр үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх боломжтой.

Түлхүүр үг: Нийгмийн хүртээмж, туслах ажилтны сургалт, мэргэжлийн ур чадвар, чанарын үнэлгээ, хөтөлбөрийн стандарт, технологийн дэмжлэг, сургалтын арга зүй.

Ашигласан материал:

1. *НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц – Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах үндсэн баримт бичиг.*
2. *ДЭМБ (2011) ба Дэлхийн банк (2022) – Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тулгамдсан асуудал, боловсрол, үйлчилгээний талаарх дэлхийн судалгаа, зөвлөмж.*
3. *АНУ-ын ADA National Network, Европын Холбоо, Австралийн институт (2019) – Туслах ажилтны сургалт, үйлчилгээний стандарт, бодлого, сайн туршлага.*
4. *Smith & Brown (2020) ба Thomas & Simmons (2018) – Туслах ажилтны сургалтын олон улсын туршлага, үйлчилгээний чанарыг сайжруулах хөтөлбөрийн судалгаа.*

АУТИЗМТАЙ ХҮҮХДИЙН ЭЦЭГ ЭХИЙН СЭТГЭЛ ЗҮЙН БАЙДАЛ

Г.Галцэцэг¹

¹65-р цэцэрлэгийн арга зүйч

galaagaltsetseg228@gmail.com

Үндэслэл:

65-р цэцэрлэг 17 бүлэгтэй бөгөөд аутизмын эмгэг оноштой 3-5 насны 12 хүүхэд суралцаж байна. Эдгээр хүүхдүүдийг бүлгийн багшийн ажиглалтын тэмдэглэл, зураг, бичлэг зэргээс үндэслэн эмчтэй хамтран эцэг эхтэй уулзах, ярилцах, хүүхдийн талаар мэдээлэл солилцон зөвлөгөө зөвлөмж өгч ажиллаж байна. Цэцэрлэгийн хэмжээнд оношлогдоогүй 4 хүүхэд Сэтгэцийн Эрүүл мэндийн төвийн хяналтад ажиглалтын хугацаатай. Бидний ажлын үр дүн нь хүүхдийг ажигласан мэдсэнээ, бусдаас өөр байгаа зэргийг ойлгуулах, эрт оношлуулснаар хүүхдийн хөгжилд хэрхэн нөлөөлөх талаар зөвлөж ажилласны үр дүнд Б.Ж /5 настай/ 2024.11.07, М.Г /3 настай/ 2024.10.29-нд детский аутизм /F84/, А.Н ажиглалтад нэмж бүртгүүлсэн.

Аутизмын эмгэг ихэвчлэн сургуулийн өмнөх насанд оношлогддог учир эцэг эхийн сэтгэл зүйн байдлыг нь анхаарах тэдэнд мэргэжлийн болон нөхцөл байдлын тусламж туслалцаа өгч чиглүүлэг хийх нь нэн шаардлагатай.

Судалгааны зорилго:

Сургуулийн өмнөх насны аутизмын эмгэгтэй ба байж болзошгүй гэсэн хүүхдийн эцэг эхийн сэтгэл зүйн байдлыг судлах


Судалгааны арга зүй:

- ✓ Мэдээлэл цуглуулах арга
- ✓ Ярилцлагын арга
- ✓ Ажиглалт тэмдэглэлийн арга
- ✓ Шийдлийг турших арга
- ✓ Асуудлыг олж илрүүлэх арга
- ✓ Шийдэлд суурилсан судалгааны арга
- ✓ Нэгтгэн дүгнэх арга


Үр дүн:

1. 2-5 насны 12 хүүхэд
2. Аутизм эмгэг оношлогдсон нас: 4 настайдаа 50%
3. Эцэг эхийн нас: 25-40 нас 80%
4. Хүүхдийнхээ оношийг 75 % нь зөвшөөрөхөд хугацаа шаардсан ба 25%
5. хүлээн зөвшөөрөөгүй.
6. Судалгааг ихэвчлэн буюу 75% ээжүүд бөглөсөн.
7. Гадуур гарахад эргэн тойрны хүмүүсийн 68% ажигласан, төвөгшөөсөн 33% байна.
8. Эргэн тойрны хүмүүсийн мэдлэг 58% мэдэхгүй, 41,7% ойлголттой гэсэн байна.

Судалгааны үр дүнд 4 настайдаа ихэвчлэн оношлогдож байна. Эдгээр эцэг эхийн хувьд тэдэнд сэтгэл зүйчийн зөвлөгөө, эмчилгээ, тусламж шаардлагатай ба нийгэмд түгээн дэлгэрүүлэх, сайнаар нөлөөлөх үйл ажиллагаа хийж байх шаардлагатай.



Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар



Дүгнэлт:

Аутизмтай хүүхдийн эцэг эхийн сэтгэл зүйн байдал судалгааг хийх явцад онол, практикийн талаас мэдлэгтэй, туршилт үйл ажиллагааны явцад мэдлэг хуримтлууллаа. Насанд хүрэгчдийн сэтгэл зүй, зан байдлыг судалсан эрдэмтдийн онол, тэгш хамран сургах боловсролын зэрэг ном гарын авлагууд, цахим мэдээллийн сайтууд, аутизмтай хүүхдүүдийн эцэг эхийн групп, гэр бүлийн радиогаар ярьж буй сэтгэгдлүүдийг сонсож үзсэн. Судалгааны явцад эцэг эхчүүд хүүхдээ ажиглаад хэлд орохыг нь хүлээж хугацаа алддаг. Хүүхдээ оношлуулсны дараа сэтгэл зүй нь бэлэн бус байдаг. Энэхүү хүлээлтүүдээс болж хүүхэдтэйгээ ажиллах хором цаг хугацааг алдаж байна. Тусгай мэргэжлийн төвд явах, аутизмын давуу талуудыг мэдэх, хүүхэдтэйгээ хэрхэн харьцах талаар эрэл хайгуул хийх шаардлагатай. Хүн ямар ч зүйлд бусдыг хуурч мэхлэх хандлага гаргана гэдэг нь эцсийн дүндээ өөрөө өөрийгөө л хуурч байна гэсэн үг. /Д.С.Лихачёв/ Хүүхдээ аутизмтай гэж оношлуулсны дараа сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эмгэгийн талаарх мэдээллийг ганцаарчлан ярилцаж тухайн хүнд асуудлыг даван туулахад туслах мэргэжлийн зөвлөгөө шаардлагатай байна.

Түлхүүр үг: Нийгмийн хам шинж, оношилгоо, сэтгэл зүйн байдал.

Ашигласан материал:

1. Тэгш хамран сургах боловсрол /бодлогын хураангуй/ 2023 он
2. Тэгш хамран сургах боловсролд хамтдаа 2022 он
3. Хөгжлийн бэрхшээлтэй сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам А/177
4. <https://medium.com/@enkhtushiglkhagvasuren/%D0%BF%D1%81%D0%B8%D1%85%D0%BE%D0%B0%D0%BD%D0%B0%D0%BB%D0%B8%D0%B7-e765bede5193>
5. <https://gogo.mn/r/ke6ky>
6. <https://indigo-papa.ru/node/480>
7. <https://dmh.yonsei.ac.kr/>
8. https://en.wikipedia.org/wiki/United_states_national_library_of_medicine

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮҮХДЭД ТЭГШ БОЛОМЖ ОЛГОЁ (ОРОН НУТАГ ДАХЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ, СУДАЛГААНЫ ҮР ДҮН)

Ч.Гажидмаа¹

¹Хэнтий аймаг, Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний газар
gajidmaachintogtoh@gmail.com

Үндэслэл:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ, тэдэнд тулгарч буй саад бэрхшээл, тулгамдсан асуудлын талаар, салбар хоорондын уялдаа болон бодлого хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулах зорилтын хүрээнд нотолгоонд суурилсан судалгаа хийх шаардлагатай болсон юм.

Судалгааны зорилго:

Нийгмийн халамжийн шинэчлэлийн хүрээнд “Монгол Улсын Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигт нийгмийн халамжийг зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцүүлж, амьжиргааг нь дээшлүүлэх, зорилтот бүлэгт чиглэсэн халамжийн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх, орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Хөгжлийн бэрхшээлтэй 139 хүүхдийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал цаашид анхаарах зарим асуудлыг судлан тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийв.

Судалгааны арга зүй:

Хэнтий аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба хүүхдээ асарч буй эх ба эцгийн талаарх үзүүлэлтийг ENALAMJ.MN халамжийн нэгдсэн систем мэдээллийн сангаас болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөр арга хэмжээнд хамрагдсан иргэдийн талаарх үзүүлэлтийг холбогдох мэргэжилтнээс нэгтгэн авч харьцууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, нийгмийн ажилтнаас асуулгын аргаар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхээс ганцаарчилсан ярилцлагын аргачлалаар тоон болон чанарын мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийн үр дүнг боловсруулав.

Үр дүн:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхтэй уулзахад хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулахад шаардлагатай хөтөлбөр, тусгай боловсрол олгох хүний нөөц орон нутагт хангалтгүй байгаа нь ажиглагдлаа. Мөн аймгийн төв Чингис хотын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 9 хүүхэд тусгай сургуульд /УБ/-т боловсрол эзэмшиж байгаа нь ар гэрийн анхаарал халамж сайн, амьжиргааны түвшин бас нөлөөлж байна. Хүүхдээ асарч буй эцэг эхийн 62,47 хувь нь ажил хөдөлмөр эрхлээд хүүхдээ эрүүл мэнд, боловсролын, нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд тэгш хамруулж байна. Мөн ажил эрхлээгүй боловч сайн дурын даатгалын шимтгэл төлж байгаа 13,1 хувь нь 2024 оноос хэрэгжсэн нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн хүрээнд хөнгөлөлт эдэлж нийгмийн баталгааг хангаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 2022 оноос эхлэн цалин тэтгэврийн нэмэгдэлтэй уялдуулан мөнгөн дүнг нэмэгдүүлж байгаа боловч өнөөдөр бодит нөхцөл байдал дээрээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн хамгааллын тэтгэмж хангалтгүй байна. Мөн ХБХүүхдэд олгож буй унаа, түлшний хөнгөлөлт болон тусгай хэрэгслийн мөнгөн дүн тогтмол байсаар ирснийг анхааралдаа аваасай гэж хүсэж байна.

Дүгнэлт:

- Оношны төрлөөр насаар бүлэглэн харьцуулалт хийхэд зарим нэг өвчин гэмтлийн хувьд ихээхэн хувийг эзэлсэн байдалтай байна. Мөн даун болон аутизм оноштой, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нэлээд байгаа боловч эдгээр хүүхдүүдэд тохирсон эмчилгээний арга зүй, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн цогц хөтөлбөр хэрэгтэй байна. Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэн, эрт оролцоог хангах асуудал салбар хоорондын уялдаа хангалтгүй байгаагаас шалтгаалан хоёрдогч бэрхшээлээс сэргийлэх, эмчилгээ, сэргээн засалт болон боловсролын аль алиныг дэмжих арга хэмжээ хангалтгүй байна.
- ХБХүүхдэд сар бүр олгож байгаа тэтгэмжийг 2024 оны 04 сарын 01-с 50,0 мян.төг-р

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

нэмэгдүүлсэн боловч 375,0 мянган төгрөгийн тэтгэмж хүүхдүүдийн эмчилгээний зардал, эм тарианд огт хүрэлцдэггүй. Хүүхдийн тэтгэмжээс гадна 302,5 мянган төгрөгийг хүүхэд асарсны тэтгэмж болгож эцэг, эхэд өгдөг. Энэ мөнгөөр сарын орлогогүй олон өрх амьдарч байна. Хөдөлмөрийн насны ээж, аавууд хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаанд байх шаардлагатай хүүхдээ харахаас өөр сонголтгүй. Мөн байнгын асаргаатай хүүхдүүдийн сурах, хөгжих эрхийг хангаж, амьдрах зардлын тэтгэмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна гэж үзэж байна.

- Хэрлэн суманд нийт 139 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас 92,3 хувь нь сургууль, цэцэрлэг, насан туршийн боловсролд хамрагдаж байгаа хэдий ч хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 7,7 хувь буюу 13 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа нь орон нутагт тусгай хэрэгцээт боловсрол олгох хүний нөөц дутагдалтай, салбар дундын уялдаа сул гэх мэт шалтгаанаас болж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бага ангидаа сургуульд сурах сонирхолтой ч анги ахих тусам үе тэнгийн хүүхдүүдийн шоолох, багшийн хайхрамжгүй байдал, хэт олон цагаар суух, жирийн хүүхдүүдтэй адил хэмжээнд суралцах боломжгүй шалтгаанаас болж сурах сонирхолгүй болж сургууль завсардалт үүсэж байна. Явган зам, нийтийн тээврийн орчин хангалттай бүрдээгүйн улмаас сургуульд явахад хүндрэлтэй.
- Асран хамгаалагчид болон бүс нутгийн нийгэм дэх хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хангалтгүй. Эцэг/эх, асран хамгаалагчид нь ажил эрхлэх боломж хомс тул ядууралд өртөмтгий байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг эхийн хувьд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээнд хамрагдалт харьцангуй бага байгаа нь эдгээр бүлэгт тохирсон ХАЛАМЖ-ХӨДӨЛМӨР эрхлэлтийг цогцоор шийдвэрлэсэн уян хатан бодлого шинэлэг хөтөлбөр арга хэмжээ шаардлагатай байгаа нь харагдаж байна. Орон нутагт тохируулгатай ажлын байр байхгүйгээс бага насны хүүхэдтэй болон байнгын асаргааны хүүхэдтэй эхчүүд ажил хийх боломж тааруу байна.

Түлхүүр үг: Тусгай хэрэгцээт боловсрол ,тохируулгатай ажлын байр, цогц хөтөлбөр, нөхөн сэргээх.

Ашигласан материал:

1. *Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөр 2022-2023 он*
2. *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль*
3. *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах бодлогыг хэрэгжүүлэх нь хөвсгөл аймгийн туршлагад суурилсан гарын авлага*
4. *Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тулгамдаж буй саад бэрхшээлийг тодорхойлох судалгаа"-ны тайлан*

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГЭМД ЭЗЛЭХ БАЙР СУУРИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ НЬ

Б.Уянга, Б.Батзаяа¹

¹Дотоод хэргийн их сургууль, Эрх зүй, нийгмийн ухааны сургууль, Хувийн эрх зүйн тэнхим
uyangabatsaikhan18@gmail.com

Үндэслэл:

Дэлхий дээр нэг тэрбум гаруй хүн ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байгаа бөгөөд бараг 200 сая хүн үйлдлийн бэрхшээлтэй амьдарч байна. Хурдацтай хөгжиж буй энэ зуунд дээд боловсролын салбар нь нийгмийн хэрэгцээ, шаардлагыг соргоогоор мэдэрч, шаардагдаж буй чиглэлээр өндөр мэдлэгтэй, өрсөлдөх чадвартай, хөрвөх чадамжтай хүний нөөцийг бэлтгэх, шинэ мэдлэг бүтээх, түүнийг хэрэглээнд нэвтрүүлэх, судалгаанд тулгуурласан бодлого, шийдвэр боловсруулах, шинжлэх ухаанд суурилсан хөгжлийн үндсийг бэхжүүлэхэд төрд дэмжлэг үзүүлж, улс орны хөгжилд хувь нэмэр оруулах үүрэгтэй. Хууль сахиулах байгууллага буюу төрийн тусгай алба хаагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэж хэн бэ?, Тэдэнд юугаар туслах вэ?, Хэрхэн харилцах вэ? гэсэн агуулгын хүрээнд албан үүргээ гүйцэтгэж байхдаа хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, зөв үйлдэл хийж, өөрөөрөө үлгэрлэн дуурайлал үзүүлэх, нийгэмд эерэг хандлага төлөвшүүлэх талаар үйл ажиллагаа зохион байгуулж, хэрэгжүүлэх юм. Дотоод хэргийн их сургуулийн эрдэмтэн багш, судлаач, албан хаагч, сонсогч, суралцагчдын хүний эрхийн мэдрэмж, мэдлэг, хандлагыг түшиглэн хууль сахиулах үйл ажиллагааны явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, үр дүн, нийгмийн оролцоог хангах, үзэл бодлыг түгээн сурталчилснаар ард иргэдийн сэтгэлгээнд өөрчлөлт оруулахад дэмжлэг үзүүлнэ.

Судалгааны зорилго:

ДХИС-ийн багш, алба хаагч, сонсогч суралцагчдад хүний эрхийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах талаар мэдлэг, мэргэшлийг олгохоор зорьж байна.

Судалгааны арга зүй:

ДХИС-ийн багш, алба хаагч, сонсогч, суралцагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдлэгийг олгож, хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, хууль сахиулах байгууллагын алба хаагчийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хүнлэг харилцах, ялгаварлан гадуурхахгүй байх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх юм.

Үр дүн:

Дотоод хэргийн их сургуулийн удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

- Нийгмийн хариуцлагын хүрээнд их сургуулийн багш, алба хаагч, сонсогч, суралцагчдад хүний эрхийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдлэг, мэдээллийг маш сайн ойлгуулах, тусалж дэмжих, хүндэтгэх, тэдний онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн заах арга зүйд сургахаар хичээнгүйлэн ажиллаж байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хүргэх үүднээс Их сургуулийн түүхэн танилцуулга, баримтат киног дохионы хэлээр, брайл үсгээр, тус тус хөрвүүлэн бэлтгэж, Их сургуулийн музейн үзэсгэлэнгийн танхимд байрлуулан, дуудлага.мн-тэй холбогдож дүрст дуудлага хийх боломжийг бүрдүүлсэн зэрэг дорвитой ажлуудыг хийсээр байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Бауыржаны баталсан “Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх нэгдсэн удирдамж”-ийн дагуу 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр тус газрын төлөөлөгчдийг Их сургуулийн Захиргааны удирдлагын газрын дарга болон Хүний нөөцийн албаны дарга хүлээн авч, уулзалт хийсэн.
- Их сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын сул орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сонгон шалгаруулалтаар авч ажиллуулах боломжтой тухай зарлал мэдээллийг байгууллагын цахим хуудасны ил тод цэсэд тогтмол шинэчлэн байршуулж байна. Энэ ажлын хүрээнд Их сургуулийн Биеийн тамир, албаны бэлтгэлийн институтын багшийн албан тушаалд паралимпын аварга, дэд хурандаа Э.Содномпэлжээг томилон ажиллуулж байна.
- Үйлчилгээний албан тушаалд ажиллах хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

бүртгүүлээгүй байна.

- Их сургуулийн албан хаагч, ажилтны гэр бүлийн гишүүдийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй 9 иргэн байдаг бөгөөд Их сургуулийн захирлын “Дэмжлэг олгох тухай” А/464 дүгээр тушаалаар тус бүр 1 сая төгрөгийн мөнгөн дэмжлэгийг нэг удаа олгосон байна.

Их сургуулийн алба хаагчид нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Их сургуулийн багш, албан хаагчид Онцгой байдлын сургуулийн 642 дугаар дамжааны дэд түрүүч Ц.Ариунзаяагийн эмчилгээний зардалд зориулан хандивын аян зохион байгуулж, нийт 18 сая төгрөгийг дэмжлэг үзүүлсэн.
- Нарантуул олон улсын худалдааны төвд хувиараа хөдөлмөр эрхэлдэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн М.Сайнсанаагаас 10 ширхэг шалны мод, 10 ширхэг дэрсэн шүүрийг 150,000 төгрөгөөр худалдан авч, Их сургуулийн цэвэрлэгээ үйлчилгээнд ашиглаж байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн албан хаагчидтай хамтран 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр “ЭХ ҮРС-ИТГЭЛТ ИРЭЭДҮЙ” өдөрлөгийг “Нийгмийн ажил” хөтөлбөрийн 512, 522 дугаар дамжааны сонсогчдын төлөөлөл хамтран сайн үйлсийн аян зохион байгуулсан.
- Тус их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн суралцагчид “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай” сэдвийн хүрээнд Тусгай хэрэгцээт харааны болон сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийг сургадаг ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн 1-12 дугаар ангийн 130 сурагчдад “Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан сайн үйлсийн аяныг амжилттай зохион байгуулсан.

Багш, судлаачдыг хөгжүүлэх, чадавхжуулах чиглэлээр:

- Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас 2024 оны 10 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулсан “Хүний эрхийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүн, ЛГБТ хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалт”-д Их сургуулийн 10 багш, албан хаагчийг хамруулсан.
- Монгол Улсын хууль, Нэгдсэн үндэсний байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцод заасан зарчмын дагуу хүний эрхийн байр сууринаас хандах, сонсголын бэрхшээлтэй иргэд дохионы хэлээр харилцаанд ороход саадгүй байх, Төрийн албан хаагчид хүн бүрд төрийн үйлчилгээг хүргэхийн тулд дохионы хэлний анхан шатны чадвартай байх нь чухал юм. Иймд сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг саадгүй, хүртээмжтэй хүргэх дохионы орчуулагч бэлтгэх албан хаагчдыг чадавхжуулахаар Дохионы хэлний үндэсний сургагч багш Б.Саранчимэгтэй хамтран “Шидэт гар” дохионы хэлний анхан шатны сургалтад 3 албан хаагч, 1 сонсогчийг хамруулан 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс зохион байгуулж байна.
- Их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн багш нар Нийслэлийн Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны Засаг дарга, Нийгмийн ажилтан, Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Нэг цэгийн үйлчилгээний ажилтан, бизнес эрхлэгчдийн төлөөлөл, Хэсгийн ахлагч нарын нийт 23 ажилтан, албан хаагчдад “Хүний эрхийг хангах механизмын тухай ойлголт”, “Хүний эрхийг хангах олон улсын механизм”, “Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоо”, “Хөгжлийн бэрхшээлтэй /тусгай хэрэгцээт/ иргэний эрхийг хангахад төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо” сэдвээр 4 цагийн сургалт зохион байгуулсан.

Дүгнэлт:

- ДХИС-ийн хөгжлийн тулгын чулуу болох хөтөлбөр, багш, судлаач, сургалтын орчныг сайжруулснаар ДХИС хөгжинө. Их сургууль хөгжсөнөөр хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, судалгаанд үндэслэсэн шийдвэр гаргах, хууль сахиулах үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хууль сахиулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, захиалагч байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангасан цогц чадамж бүхий мэргэжилтэн, хууль сахиулагч бэлтгэгдэн төгсөж, хуулийг хэлбэрэлтгүй сахиулснаар иргэд амар тайван амьдрах нөхцөл бүрдэх юм.

- Эдгээр ажлууд нь жижиг мэт харагдах боловч Дотоод хэргийн их сургууль нь Цагдаа, Онцгой, Шүүх, Хил хамгаалах байгууллагуудын төрийн тусгай албан хаагч болон төрийн албан хаагчийн тангараг өргөсөн боловсон хүчнийг бэлтгэж

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

байгаа тул сууринаас нь буюу тус их сургуульд 1 дүгээр дамжаанаас эхлэн суралцаж байгаа цаг хугацаанаас нь эхлэн дээрх ойлголтуудыг өгч, төлөвшсөн, хүнлэг, алба хаагчийг бэлтгэж нийгмийн өмнө тулгамдсан асуудлын нэгээхэн хэсгийг шийдвэрлэж байгаа гэдэгтээ итгэлтэй байна.

Санал:

- Дотоод хэргийн их сургууль болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар хамтран ажиллах санамж бичиг байгуулах
- Санамж бичгийн хүрээнд их сургуулийн бүрэлдэхүүн сургууль болох Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн “Эрх зүй” бакалаврын хөтөлбөрийн эцнээ хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг суралцуулах
- Дотоод хэргийн их сургуулийн сургалтын хөтөлбөрт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний ойлголт”-ын талаар 1 багц цагийн төлөвлөлтийг хийх,
- Сургалтын багц цагийн өөрчлөлтийг их сургуулийн Хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн тохиолдолд үндсэн буюу цагийн багш томилуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас Дотоод хэргийн их сургуулийн багш, алба хаагч, сонсогч, суралцагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалтыг зохион байгуулах, богино хугацааны сургалтад хамрагдаж, 2 байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, нийгэмд эергээр сурталчилж ажиллах, багш, алба хаагч, сонсогч, суралцагчдад сургалтад хамрагдсан гэрчилгээ олгох
- Бидний урагш алхаж буй нэг алхам жижиг мэт харагдах боловч Дотоод хэргийн их сургууль нь Цагдаа, Онцгой, Шүүх, Хил хамгаалах байгууллагуудын төрийн тусгай албан хаагчдыг бэлтгэж байгаа тул сууринаас нь буюу тус их сургуульд 1 дүгээр дамжаанаас эхлэн суралцаж байгаа цаг хугацаанаас нь эхлэн дээрх ойлголтуудыг өгч, төлөвшсөн, хүнлэг, алба хаагчийг бэлтгэж нийгмийн өмнө тулгамдсан асуудлын нэгээхэн хэсгийг шийдвэрлэж байгаа гэдэгтээ итгэлтэй байна.

Түлхүүр үг: Хууль сахиулах байгууллага, төрийн тусгай албан хаагч, хүний эрх

Ашигласан материал:

1. Хүний эрхийн конвенц., 1948.,
2. Монгол Улсын Үндсэн хууль., УБ., 1992 он;
3. Монгол Улсын Иргэний хууль., УБ., 2002 он;
4. Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль., УБ., 2016 он
5. Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН, ХҮҮХЭД АСРАХАД ТУЛГАМДАЖ БУЙ НИЙГМИЙН АСУУДЛУУД

Н.Зол¹, П.Цэрэнбазар²

¹ МУИС, Социологи, нийгмийн ажлын тэнхим, Социологийн докторант, ²Дэд Проф zolz.sw@gmail.com

Үндэслэл:

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр 106400 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагийн 59 мянга нь эрэгтэй, 47.4 мянга нь эмэгтэй байна. 2010 оны хүн ам орон сууцны тооллогоор 0-19 насны 15851 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байсан бол 2020 онд 11325 хүүхэд бүртгэгджээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 47.6 хувь нь төрөлхийн, 52.4 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Энэ нь хүн амын дунд төрөлхийн болон олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлд өртөх тохиолдол ойролцоо байгааг харуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 0-4 насны 5 хүүхэд тутмын 4 нь (85.3 хувь) төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудлаас гадна шийдвэрлэх ёстой асуудлын нэг нь тэднийг асарч буй иргэд, өрхийн нийгмийн асуудлууд байх нь зүйн хэрэг. Гэвч асаргаа үзүүлж буй иргэдэд сар бүрийн тусламжаас өөр тэдэнд чиглэсэн ямар бодлого хэрэгжиж байгаа нь тодорхойгүй байна. Иймд МУИС-ийн Нийгмийн ухааны сургуулиас 2023 оны 12 сараас 2024 оны 5 сарын хооронд 7 аймаг, хотын 4 дүүрэг мөн төрийн бус байгууллагад хийгдсэн судалгаа болно.

Судалгааны зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг асрахад тулгамдаж буй асуудлыг цогцоор тодорхойлох, хөлсгүй хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлыг тодруулахыг зорьсон болно.

Судалгааны арга зүй:

Судалгааг гүйцэтгэхдээ чанарын судалгааны арга ашиглан зудтай гурван аймаг, бусад дөрвөн аймгийн 59 малчин өрх мөн Улаанбаатар хотоос 21 өрх, 10 төрийн бус байгууллагаас талбарт ажиллан ганцаарчилсан ярилцлага хийсэн болно. Гүнзгийрүүлсэн ярилцлагын хүрээнд асрах хөдөлмөр эрхэлж буй иргэдэд тулгарч буй асуудал, уур амьсгалын өөрчлөлт, мал аж ахуйн хөдөлмөр үүнд хэрхэн нөлөөлж байгааг тодруулахыг зорьсон болно.

Үр дүн:

Судалгаанд нийтдээ 90 ганцаарчилсан ярилцлага хийсэн бөгөөд түүврийн хэмжээг дэлгэрэнгүй харвал дараах байдалтай байна.

График 1. Судалгаанд оролцогчид, байршлаар



Асрахуй хөдөлмөр эрхэлж буй иргэдийн хувьд 58 иргэн байсан бөгөөд уг иргэдийн боловсролын түвшинг харвал дараах байдалтай байна. Эдгээр иргэдийн ихэнх нь буюу 47 хувь нь бүрэн дунд боловсролтой, 17 хувь нь боловсролгүй иргэд байна. Судалгаанд оролцсон асрахуйн үйлчилгээ үзүүлдэг иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харвал дараах байдалтай байна. Үүнд: нийт судалгаанд оролцсон иргэдийн 83 хувь нь хөдөө, орон нутагт мал аж ахуй эрхэлдэг байна. Эдгээр иргэдийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, хүүхдийг асрахын хажуугаар өөрсдийн амь амьдралыг залгуулах шаардлагатай тул мал аж ахуй эрхлэн

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

амьдардаг байна.

Ярилцлагаас хамгийн өндөр давтамжтай байсан асуудлуудыг дурдвал:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд асарч буй иргэд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авах нөхцөл, цаг боломжгүй, нийгмийн харилцаанд ороход асуудалтай байна. Судалгаанд оролцсон иргэд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, өндөр настныг өөр хүнээр асруулах боломжгүй байдаг тул үргэлж өөрөө асардаг. Асрах ажил нь ээлжгүй үргэлжилдэг тухай ярилцлагад дурдсан байна. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэн асарч буй иргэдэд өдрийн, эсвэл цагаар асрах сувиллын үйлчилгээ, сувилагчийн хэрэгцээ өндөр байна.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн мөсөн, төмөр зуд болж байгаа нь өвлийн улирлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрахад улам хүндрэлтэй болгож байгааг дурдсан байна. Судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг асарч буй иргэдийн хувьд өглөө 6 цагаас үдшийн 23 цаг хүртэл мал маллах, асрахуйн ажил эрхэлдэг тухай дурдаж байв. Өдрийн 18 цагийн амсхийх завгүй энэхүү ажлыг долоо хоногоор тооцоолбол 126 цагийн ажил эрхэлж байна. Айл өрх бүрд асрахуйн ажлыг эрхэлж буй энэ дүр зураг нь хөдөлмөрийн хэвийн ажил хийх хугацаанаас даруй 3 дахин их хэмжээний ачаалалтай ажиллаж байгааг харуулж байна.

Дүгнэлт:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрахад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 3 дахин их цаг зарцуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрахад жендерийн асуудал давхар хөндөгдөж байна. Хүүхэд, өндөр настай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрсөн ээж, төрсөн охин, бэр нь асардаг байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрахад орон сууц, галлагааны систем, төвлөрсөн устай холбогдсон байдал нөлөөлж байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхөд орон сууц, дулааныг шийдвэрлэж өгөх нь нэн чухал асуудал юм. Судалгааны асуултын явцад сүүлийн жилүүдэд болсон зудын нөхцөл байдал хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрахад хүндээр нөлөөлсөн тухай иргэд илэрхийлж байв. Зудаас хамааралтай өрх амьжиргаагаа залгуулахад хүндрэлтэй болсноос гадна сумын төв, аймгийн төв орж эмнэлэгт үзүүлэх, эм хангамжаа хангахад хүндрэлтэй болж эхэлсэн байна. Судалгааны явцад хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлийг таньж оношлох явц удаашралтай хүндрэлтэй. Мөн хөнгөн хэлбэрийн зарим хөгжлийн бэрхшээлийг хөгжлийн бэрхшээлд оруулан тооцдоггүй нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асаргаа, нийгмийн бодлого, дэмжлэг хамрагдахгүй байх үндэслэл болж байна.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүд, асрахуй, асрахуйн асуудал.

Ашигласан материал:

1. New York:Levy economics institute, Bard College. (n.d.). Motherhood, mothering and care among Mongolian herder women. Agriculture and Human values, 1-19.
2. NSO. (2021). Report on the 2020 Census. Retrieved from www.1212.mn: www.1212.mn
3. NSO. (2024). Mongolian national statistical office database . Retrieved from www.1212.mn: www.1212.mn
4. Odontuya, T. (2016). On encouraging mothers of multiple children through the Order of the Mother Glorious in Mongolia. In N. Ijichi, A. Kato, & R. Sakurada, Rethinking representation of Asian women: Changes, continuity and everyday life, (pp. 35-49). New York: NY: Palgrave Macmillan.
5. Otgontugs, B., Boldbaatar, M., & Khishigt, D. (2024). Mapping childcare in Mongolia: Children as unpaid caregivers. A Path inclusive development: Unpacking Gender Inequalities in economic theory and policies (pp. 60-65). International workshop.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭЛЭГ БАЙДАЛ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИНД НӨЛӨӨЛӨХ НЬ

Ц.Содбилэг, Г.Гэрэлмаа¹

¹Хүүхдийн төв сувилал

ts.sod5180@gmail.com

Үндэслэл:

Хүүхдийн төв сувиллаар үйлчлүүлж байгаа R62.8 /бие бялдрын хөгжил саатах/, G80 /хүүхдийн тархины саа/ үндсэн оноштой сувилуулагч хүүхдийн тоо урд жилүүдээс нэмэгдэх хандлагатай, эдгээр хүүхдүүдэд удаан хугацааны сэргээн засах эмчилгээ, асаргаа сувилгаа зонхилон хэрэгцээтэй байдаг ба нийгэмшүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх нь маш чухал юм. Хүүхдийн өдөр тутмын асаргаа сувилгаанд орчин бүрдүүлэх, цэвэр байлгах, хооллох, тоглуулах, унтуулах, сургах хэрэгцээг зайлшгүй хангасан байх шаардлагатай тул эдгээр шаардлагыг хангасан, эмчилгээ үйлчилгээний олон төрлийг хамруулсан цогц үйлчилгээг үзүүлэх боломж бүхий СЗЭХэсгийг тохижуулан, хөгжлөөр хоцрох эрсдэлтэй, эсвэл хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй болох нь тогтоогдсон 5 хүртэлх насны хүүхдүүдийг цаашид тохиолдох сөрөг нөлөөллүүдээс сэргийлэх, цаг алдалгүй эрт сэргээн засах эмчилгээнд хамруулах, асран хамгаалагч нарыг дэмжих, цогц мэдлэгтэй болох боломжоор хангах, эрт үеийн хөгжлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна. Тус хэсгээр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн байдлыг үнэлж, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг тодорхойлох нь судалгааны ажил хийх үндэслэл болсон.

Судалгааны зорилго:

Үйлчилгээний шинэлэг байдлыг үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжтай холбон судлах.

Судалгааны арга зүй:

Хүүхдийн төв сувиллын СЗЭХэсгээр 2023.03.06-аас 2023 оны 11 сарын 14-ны өдрүүдэд үйлчлүүлсэн давхардсан тоогоор 140 хүүхдээс 2-4 удаагийн давтамжтай хамрагдсан 30 хүүхдийг сонгон авч судалгаанд хамруулав. Судалгаанд хамрагдсан хүүхдийн 56,7% бие бялдрын хөгжил саатсан, 36,7% тархины саажилт, 0,07% даун оношоор сувилуулсан. Үйлчилгээний сэтгэл ханамж, эмчилгээний үр дүн, эрүүл мэнд, хөгжлийн ахицын үнэлгээ, мэдлэг мэдээллийн хүртээмжийг тодорхойлох 6 өгөгдөл бүхий асуумжийн дагуу асран хамгаалагчтай ганцаарчилсан ярилцлага хийж, тэмдэглэл хөтөлсөн.

Үр дүн:

- Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчийн 70% нь 2 удаа, 30% нь 3-4 удаа давтамжтай эмчилгээнд хамрагдсан ба нийт хүүхдийн 40% нь /удаан хугацааны асаргаа шаардлагатай хүүхдүүд/ тодорхой ахиц, өөрчлөлт гарсан, 60% нь хөдөлгөөний идэвх сайжирч, үр дүнтэй байсан. 40% нь өөрийгөө илэрхийлэх, орчиндоо дасан зохицох чадвар, 30% хоол нойрондоо сайжирч, асран хамгаалагч нар 100% сэтгэл ханамж өндөр байгаагаа ярилцлагын үеэр илэрхийлсэн. “Бага насны хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн эрт үеийн дэмжлэг” сэдэвт сургалтад хамрагдсанаар хүүхдээ ойлгох, идэвхтэй харилцах, хөгжүүлэхэд нь дэмжлэг өгч, гэр бүлийн хүрээнд хүүхэдтэй ажиллах чадвар дээшилж, бусад хүүхдүүдийн эцэг эхтэй танилцах, бие биесийгээ дэмжих, урам өгөх хандлага ажиглагдсан гэж 100% хариулсан.
- Цогц тусламж үйлчилгээнд хамрагдсанаар сэтгэл ханамж өндөр байна гэж 100% хариулсан.

Дүгнэлт:

1. Хөдөлгөөн сэтгэхүйн хоцрогдолтой, тархины саажилттай хүүхдүүдэд үзүүлж буй цогц үйлчилгээний чанар хүртээмж хангалттай сайн байна гэж дүгнэлээ.
2. Давтан эмчлүүлэх хугацаа ойрхон байж цогц үйлчилгээндээ хамрагдах нь илүү үр дүнтэй байгаа тул асран хамгаалагч нарт санал болгон, эмчилгээний үр дүнг сайжруулах шаардлагатай.

Түлхүүр үг: Цогц үйлчилгээ, сэтгэл ханамж, хөдөлгөөний хоцрогдол, тархины саажилт.

БИЕ ДААН АМЬДРАХ ЭРХ

Д.Сонгохбаяр¹
¹ХБХХЕГ, мэргэжилтэн

Үндэслэл:

Хүн бүр байгалиас заяагдмал эрхэм зэрэг нандин чанартай, ижил үнэ цэнтэй мэндэлдэг. Үүгээрээ хүн бүр давтагдашгүй, онцлогтой учир адил хүндлэгдэж, хэнээс ч хамааралгүй, эрх чөлөөтэй байж, амьдралаа шийдэх, сонголт хийх боломжийг өөртөө агуулсан байдаг. Гэвч зөвхөн хүнд л байх хүний эрхэм зэрэг, нандин чанар хөгжлийн бэрхшээлтэй хүнд олон шалтгаанаас болж алдагдсаар ирсэн. Тиймээс 1960-аад оноос Америкаас эхлэн дэлхийн улс орнуудад тархаж хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдийн эрхийн төлөө хөдөлгөөнийг идэвхтэй өрнүүлж эхэлсэн. Энэхүү хүчтэй хөдөлгөөний үр дүнд нийгмийн хамгааллын салбарт олон шинэ тогтолцоо бий болсны нэг нь “Бие даан амьдрах эрх” бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн салбарт хувьсал хийсэн тогтолцоо болсон. Энэхүү тогтолцоог Монгол улсад нэвтрүүлэхээр 2016 онд батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн 32 дугаар зүйлд оруулсан явдал нь Монгол улсад НҮБ-аас баталсан ХБХЭТК-ын 19 дүгээр заалт хэрэгжих боломж бүрдсэн юм. Үүний дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэнд гэр бүлээс нь хэн нэгэн зайлшгүй үйлчлүүлэх хэрэгцээ шаардлага өдөр бүр тулгарч байгаа тул төрөөс тусгай шаардлага хангасан үйлчлэгч гаргаж өгч үйлчлүүлэх үйл ажиллагааг “Хувийн туслах” үйлчилгээг нэвтрүүлж байна.

Судалгааны зорилго:

Хувийн туслах үйлчилгээ авсан иргэдийн сэтгэл ханамж, үйлчилгээ үзүүлэгч /хувийн туслах/-дэд гарч буй бэрхшээл, цаашид анхаарах зүйлс, сайжруулах арга замыг тогтоох.

Судалгааны арга зүй:

- Фокус бүлгийн ярилцлага, анкет, кейс анализ
- Тоон болон чанарын шинжилгээ хийх

Хүнд хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үйлчилгээ үзүүлж байгаа 32 иргэд. Үйлчилгээнд хамрагдсан хүмүүсийг хүйсээр нь авч үзвэл эрэгтэй 12.5%, эмэгтэй 87.5%, 33 - 61 настай, Хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь харвал төрийн байгууллагат 25%, төрийн бус байгууллагат 62.5%, хувийн хэвшилд 12.5% ажиллаж байна. Бэрхшээлийн хэлбэрээр тодруулбал, тулгуур эрхтний бэрхшээлтэй буюу нуруу нугасны гэмтэлтэй 25%, харааны бэрхшээлтэй 50%, тулгуур эрхтэн саажилттай 25 % иргэд байна.

Үр дүн:

Нэг. Бие даан амьдрах эрх, хувийн туслах үйлчилгээний онол, арга зүйн загвар

Урьд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг зөвхөн халамж хүртэгчийн байр сууриас харж, тэдэнд хамаарах төрийн бодлого, нийгмийн халамжийн үйлчилгээг сэргээн засах, ангаах арга хэлбэрт голлон хэрэгжүүлдэг байсан. Гэвч өнөө үед үүнээс татгалзан хүний эрхэд суурилсан үзэл хандлагад тулгуурлан, хөгжлийн бэрхшээлтэй хүний бодит хэрэгцээг дэмжих, оролцоог голлосон тогтолцоо руу шилжиж байна. Өөрөөр хэлбэл төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг аль болох нийгмийн амьдралд оролцуулах, бие даасан шийдвэр, сонголт хийсэн хариуцлагатай амьдрахад дэмжихэд чиглэдэг. Ийм үзэл баримтлал бүхий нийгмийн хамгааллын тогтолцоог олон улсад бие даан амьдрах эрх /Independent Living / гэж нэрлэдэг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг өмнө нь зөвхөн эмч, мэргэжилтэн мэдэж, дэмжлэг тусалцааг үзүүлдэг гэх үзэл бодол байв. Харин “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө адилхан хөгжлийн бэрхшээлтэй хүнийхээ хүсэл, хэрэгцээ шаардлагыг ойлгож чадах мэргэжилтэн юм” гэсэн үзлээр 1972 онд АНУ-ын Калифорни мужийн Беркли хотын иргэн Эд Робертс (булчингийн сулрал гэх хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй) дэлхийн хамгийн анхны “Бие даан амьдрах төв”-ийг үүсгэн байгуулсан. Беркли хотоос цаашлан Хьюстон, Бостон зэрэг АНУ даяар адилхан үйл ажиллагаатай төвүүд бий болсон. Ийнхүү Америкаас эхтэй уг тогтолцоо Канад, Европын улс орнуудад түгээн дэлгэрсээр 1986 онд Япон улсад “Human care” холбоо загвар төслөөр эхлүүлж өдгөө нийгмийн хамгааллын тогтолцоо болон Азийн Солонгос, Тайланд, Нипал, Пакистан, Тайвань зэрэг улсуудад хэрэгжиж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрхийг НҮБ-аас 2006 онд баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар


конвенц"-ийн 19 дүгээр зүйлд тодорхой зааж өгснөөр улс орнууд хэрэгжүүлж эхэлсэн байна. 2016 онд батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн 32 дугаар зүйлд оруулсан явдал нь Монгол улсад НҮБ-аас баталсан ХБХЭТК-ын 19 дүгээр заалт хэрэгжих боломж бүрдсэн юм. ХНХ-ын сайдын 2021 оны А/187 тоот тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”-ыг баталж, ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/167 тоот тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал”-ыг баталснаар тус үйлчилгээг 2023 оны 6 дугаар сараас эхлэн үзүүлж эхэлсэн. Эхний удаа буюу 2023 онд зөвхөн ажил хөдөлмөр эрхэлж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй 32 иргэнд тус үйлчилгээг үзүүлээд байна.

Хоёр. Үйлчилгээ авч байгаа иргэдээс судалгааг авч үзэхэд:
График 1. Үйлчилгээ нь хэрэгцээ, шаардлагад нийцэж буй эсэх



Судалгаанд оролцсон хүмүүс 100% тийм гэж хариулсан.

График 2. Үйлчлүүлэгч үйлчилгээ авч байгаа байгууллагадаа үйлчилгээний хөлсны 10% -ийг өөрөө гаргаж байгаа эсэх



Хүндрэлтэй байдаг гэж 42.3 % нь, Зөв гэж 42.3, Зарим талаараа хариуцлагатай болгох үүднээс байх ёстой ч юм шиг. Хоёрдмол утгатай гэж 15.4 %


1. Үнэлгээний асуумж таны хэрэгцээг зөв тодорхойлж чадаж байна уу?



Чадаж байгаа гэж 28.5%, Үгүй. Бэрхшээлийн хэлбэрээр нь асуумжаа гаргах хэрэгтэй. Тэгэхгүй бол оноо нь буурч байна гэж 71.5%,


График 3. Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээс шалтгаалж цагийн үнэлгээ өөр байх нь зөв эсэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар



Цагийн үнэлгээ өөр байх хэрэгтэй гэж 42.3 %, цагийн үнэлгээ адил байх шаардлагатай гэж 42.3 %, Цагийн үнэлгээ бага гэж 15.4%

График 4. Үйлчилгээ авснаар нийгмийн оролцоо, амьдралын чанарт гарч өөрчлөлт гарсан эсэх



Нийгмийн амьдралд оролцох оролцоо нэмэгдсэн, бие даасан байдал нэмэгдсэн, амьдралын чанар сайжирч, цалингаа бүтнээр авч байгаа. Хэн нэгнээс туламж гуйхгүй болсон, бухимдал багассан, ажлын бүтээмж сайжирсан, өөрийнхөөрөө байх боломж бүрдсэн гэж 100% хариулсан байна.

Гурав. Үйлчилгээг сайжруулах талаарх санал:

Цаашдаа нийгмийн үйлчилгээнд оролцох боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна /Үзвэр үзэх, дэлгүүр хэсэх, гадуур найзтайгаа уулзах гэх мэт. / Цагийн үнэлгээг нэмэгдүүлбэл оюутнууд ч гэсэн цалин авч ажиллах боломжтой болно гэж хариулсан байна. Тухайлбал, Аутизмтай, Даунтай хүмүүст энэ үйлчилгээ хэрэгтэй юу? Хэрэгтэй бол ямар үйлчилгээ байх уу?, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үл ойлголцлын асуудал гарвал ажил дээр нь дуудлагаар очиж асуудлыг нь шийдвэрлэдэг үйлчилгээ байж болох уу? гэсэн асуудлуудыг цаашид судалж шийдвэрлэх хэрэгтэй байна.

Дүгнэлт:

Төрийн үйлчилгээ бүх хүнд тэгш хүртээмжтэй байх ёстой. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээ”-г ХБИ-дэд үзүүлснээр Монгол улс НҮБ-аас 2006 онд баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц”-ийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж байгаа үйл ажиллагаа болсон. Цаашид “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээ”-г хүнд хэлбэрийн ХБИ-ийн дунд хүртээмжтэйгээр дэлгэрүүлэх, зөвхөн хөдөлмөр эрхлэхтэй нь холбож үзэхээс гадна бусад нийгмийн үйлчилгээ талаас нь хөгжүүлэх, үнэлгээ хийж байгаа асуумжуудыг хөгжлийн бэрхшээл тус бүрээр хийх (нийтлэг 54 асуултуудад хариулах нь үйлчилгээний цаг багасах шалтгаан болж байгаа Жишээ нь: Тэргэнцэртэй хүний хийж чадахгүй байгаа үйлдлийг хараагүй хүн хийж чаддаг байх, хараагүй хүний хийж чаддаггүй зүйлийг тэргэнцэртэй хүн хийж чаддаг байх зэрэг нь чадаж байгаа гэж үзэж оноог нь хасдаг байна), хэрэгцээ шаардлага байгааг анхааран авч үзэх хэрэгтэй байна.

Түлхүүр үг: Тогтолцоо, иргэдийн сэтгэл ханамж, хувийн туслах, хүртээмж.

Ашигласан материал:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц”
2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хууль
3. ХНХ-ын сайдын 2021 оны А/187 тоот тушаал
4. ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/167 тоот тушаал
5. <https://www.accessliving.org/newsroom/tag/disability-history/> Independent Living History

